



Улсын Статистик Ажиллагаа

# ОРОН СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛ



**1**

БОЛОВСРОЛ,  
БИЧИГ ҮСГИЙН  
МЭДЛЭГ

**2**

ШИЛЖИХ  
ХӨДӨЛГӨӨН,  
СУУРЬШИЛ

**3**

ӨНДӨР  
НАСТАЙ

**4**

ӨРХ-ГЭР  
БҮДИЙН БАЙДАЛ,  
ГЭРЛЭЛТ

**5**

ХӨГЖЛИЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ  
ИРГЭД

**6**

ЖЕНДЕРИЙН  
ТЭГШ БАЙДАЛ

**8**

ИНТЕРНЕТ,  
ГАР УТАСНЫ  
ХЭРЭГЛЭЭ

**9**

ХҮҮХЭД,  
ЗАЛУУЧУУД

**10**

ЭДИЙН ЗАСГИЙН  
ИДЭВХ

**11** ХҮН АМЫН ТОО

ХҮН АМЫН  
ХЭТИЙН ТООЦОО  
2010-2040

**12**

МЯНГАНЫ  
ХӨГЖЛИЙН  
ЗӨРИЛГЭЙН  
ЗАРИМ  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО**

**ОРОН СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛ**

Улаанбаатар хот  
2011 он

DDC  
310'517  
X-822

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: [nso@magicnet.mn](mailto:nso@magicnet.mn)

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж  
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

 BEST COLOR INTERNATIONAL "BCI" Хэвлэлийн компани  
Утас: 319032

ISBN 978-99929-64-54-5

## АГУУЛГА

Өмнөх үг.....	5
Сэдэвчилсэн судалгаа бичихэд оролцогчид .....	6
Хүснэгтийн жагсаалт.....	7
Зургийн жагсаалт.....	10
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ</b>	
1.1. Товч ойлголт.....	12
1.2. Судалгааны зорилго.....	12
1.3. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод хэрэглэсэн орон сууцтай холбогдох ойлголт, тодорхойлолт .....	12
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ НӨХЦӨЛ</b>	
2.1. Монгол Улсын өрхийн тоо, өөрчлөлт .....	18
2.2. Өрхийн тоо, сууцны төрөл. ....	22
2.3. Өрхийн тоо, сууцны өмч, эзэмшлийн хэлбэр .....	25
2.4. Өрхийн сууцны нөхцөл.....	28
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛ</b>	
3.1. Гэрт амьдардаг өрх.....	40
3.2. Гэрт амьдардаг өрхийн цахилгааны хангамж .....	45
3.3. Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл.....	52
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ</b>	
4.1. Сууцны багтаамж .....	64
4.2. Байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамж.....	67
4.3. Байшинд амьдардаг өрхийн дэд бүтэц, ахуйн нөхцөл.....	70
<b>ТАВДУГААР БҮЛЭГ: ӨРХӨД ТООЛОГДООГҮЙ ХҮН АМЫН СУУЦНЫ НӨХЦӨЛ</b>	
5.1. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны өмчийн болон эзэмшлийн хэлбэр .....	82
5.2. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны ахуйн нөхцөл.....	85
Дүгнэлт, зөвлөмж.....	91
Хавсралт .....	97



*Хүмүүнд төр эрхэм. Мөрд хүмүүн эрдэнэ*

## ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ орон сууцны хангамж хүрэлцээ, тав тухтай байдлын талаарх тоо баримтыг 40 гаруй жилийн өмнөөс цуглуулж ирсэн баялаг туршилтаар юм. Тухайлбал, хүн ам, орон сууцны 1969 оноос хойших 5 тооллогод хүн амын орон сууцны нөхцөлийн талаарх тоо баримтыг тодорхойлж иржээ. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнг үндэслэн “Орон сууцны ахуй нөхцөл” гэсэн сэдэвчилсэн судалгаа хийсэн нь төр засгаас сүүлчийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд юуны өмнө орон байрны асуудлыг шийдвэрлэхийн чухлыг анхаарч, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцлийг сайжруулахад чиглэсэн бодлого хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох чухал ач холбогдолтой юм. Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь 5 бүлэг, хавсралтаас бүрдэж байгаа юм. Сэдэвчилсэн судалгааны 1 дүгээр бүлэгт судалгааны зорилго, сууцны тухай ойлголт, тодорхойлолт, 2 дугаар бүлэгт өрхийн тоо, орон сууцны төрөл нөхцөл, 3 дугаар бүлэгт гэрт амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл, 4 дүгээр бүлэгт байшинд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл, 5 дугаар бүлэгт сууцны ус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөлийн талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан. Тооллогын дүнг үндэслэн цаашид төр засгаас хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлого хөтөлбөрийг төлөвлөж хэрэгжүүлэхтэй холбогдсон санал зөвлөмжийг тусгасан дүгнэлтийг оруулж өгсөн нь чухал ач холбогдолтой болжээ.

Сэдэвчилсэн судалгаанд тооллогын дүнгээс нэлээд дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг аймаг, нийслэлийн түвшинд гаргаж хавсаргасан нь хэрэглэгчдийн таашаалд нийцнэ гэдэгт найдаж байна.

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН  
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА**

*S. Mendsaikhan* С.МЭНДСАЙХАН

## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

#### Лувсанцэрэнгийн Зулцэцэг

Эдийн засагч, Статистикч, Хүн ам зүйч  
Нийгмийн хөгжил судалгааны багийн ахлагч

#### Сүрэнгийн Навчаа

Эдийн засагч, Статистикч, Хүн ам зүйч  
Нийгмийн хөгжил судалгааны багийн судлаач

#### Батцэнгэлийн Тунгалаг

Нийгмийн ухааны магистр  
Нийгмийн хөгжил судалгааны багийн судлаач

### ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

#### Цэнджавын Бадрах

Эдийн засагч  
ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

#### Жигжидсүрэнгийн Ядамсүрэн

Санхүү-Эдийн засагч  
Эдийн засгийн ухааны доктор, профессор

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

#### Тогтоо Алтанцэцэг

Эдийн засагч, Хүн ам зүйч  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он.....	18
Хүснэгт 2.2.	Өрхийн тоо, аймаг, нийслэлээр, өрхийн хэлбэрээр, 2010 он .....	20
Хүснэгт 2.3.	Өрхийн тоо, хот, хөдөө, өрхийн хэлбэр, хувиар, 2010 он.....	21
Хүснэгт 2.4.	Өрхийн тоо, хот, хөдөө, ам бүлийн тоо, хувиар, 2010 он .....	21
Хүснэгт 2.5.	Өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	22
Хүснэгт 2.6.	Өрхийн тоо, сууцны төрөл, хувиар, 2000, 2010 он .....	23
Хүснэгт 2.7.	Өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	23
Хүснэгт 2.8.	Өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны төрөл, хот, хөдөөгөөр, хувиар, 2010 он .....	24
Хүснэгт 2.9.	Өрхийн тоо, сууцны төрөл, өмчийн хэлбэр, хувиар, 2010 он .....	25
Хүснэгт 2.10.	Өрхийн тоо, сууцны өмчийн хэлбэр хот, хөдөө, хувиар, 2010 он .....	25
Хүснэгт 2.11.	Өрхийн тоо, аймаг, нийслэл, өрхийн сууцны өмчийн хэлбэр, хувиар, 2010 он .....	26
Хүснэгт 2.12.	Өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	27
Хүснэгт 2.13.	Өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны эзэмшлийн хэлбэр, хувиар, 2010 он ..	27
Хүснэгт 2.14.	Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	28
Хүснэгт 2.15.	Өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэрээр, 2010 он.....	29
Хүснэгт 2.16.	Хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэрээр, 2010 он .....	30
Хүснэгт 2.17.	Орон сууцны нөхцөл сайтай өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	31
Хүснэгт 2.18.	Орон сууцны нөхцөлийг хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	32
Хүснэгт 2.19.	Орон сууцны нөхцөлийг хагас хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	33
Хүснэгт 2.20.	Орон сууцны нөхцөлийг дутуу хангасан өрхийн тоо аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр 2010 он .....	34
Хүснэгт 2.21.	Орон сууцны нөхцөлийг муу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр 2010 он .....	35
Хүснэгт 2.22.	Орон сууцны нөхцөлийг огт хангадаагүй өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр 2010 он .....	36
Хүснэгт 3.1.	Гэрт амьдардаг өрхийн тоо, ам бүл, гэрийн ханын тоо, хувиар, 2010 он.....	40
Хүснэгт 3.2.	Гэрт амьдардаг өрхийн тоо, ам бүл, гэрийн ханын тоо, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	41
Хүснэгт 3.3.	Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, .....	42
Хүснэгт 3.4.	Гэрт амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, ханын тоо, хувиар, 2010 он .....	43
Хүснэгт 3.5.	Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, ханын тоо, хувиар, 2010 он .....	44
Хүснэгт 3.6.	Гэрт амьдардаг өрхийн цахилгааны хангамж, эх үүсвэр, хот, хөдөөгөөр, 2010 он .....	45



Хүснэгт 3.7.	Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгаанаар хангасан байдал, 2010 он .....	48
Хүснэгт 3.8.	Гэрт амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгаанаар хангасан байдал, 2010 он .....	50
Хүснэгт 3.9.	Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны хангамжийн байдал, 2010 он .....	51
Хүснэгт 3.10.	Гэрт амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөлийн үзүүлэлт, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	52
Хүснэгт 3.11.	Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хувиар, 2010 он .....	53
Хүснэгт 3.12.	Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усны эх үүсвэрээр, 2010 он .....	55
Хүснэгт 3.13.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөл сайтай өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	56
Хүснэгт 3.14.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөлийг хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	57
Хүснэгт 3.15.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөлөөр хагас хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	58
Хүснэгт 3.16.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөлөөр дутуу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	59
Хүснэгт 3.17.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөлийг муу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	60
Хүснэгт 3.18.	Гэрт амьдардаг ахуйн нөхцөлийг огт хангаагүй өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	61
Хүснэгт 4.1.	Байшинд амьдардаг өрхийн тоо, сууцны талбайн хэмжээ, хувиар, 2010 он .....	64
Хүснэгт 4.2.	Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүлийн тоо, өрөөний тоо, хувиар, 2010 он .....	65
Хүснэгт 4.3.	Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, өрөөний тоо, хувиар, 2010 он .....	66
Хүснэгт 4.4.	Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүл, өрөөний тоогоор, 2010 он .....	67
Хүснэгт 4.5.	Байшинд амьдардаг өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөөгөөр, 2010 он .....	68
Хүснэгт 4.6.	Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгаанаар хангасан байдал, 2010 он .....	68
Хүснэгт 4.7.	Байшинд амьдардаг өрхийн тоо, халаалтын төрөл, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он .....	70
Хүснэгт 4.8.	Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэлээр, халаалтын төрлөөр, хувиар, 2000, 2010 он .....	71
Хүснэгт 4.9.	Байшинд амьдардаг өрхийн усан хангамжийн төрөл, хувиар, 2010 он .....	72
Хүснэгт 4.10.	Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хувиар, 2000, 2010 он .....	72

Хүснэгт 4.11.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөл сайтай өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	75
Хүснэгт 4.12.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	76
Хүснэгт 4.13.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	77
Хүснэгт 4.14.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	78
Хүснэгт 4.15.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг муу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	79
Хүснэгт 4.16.	Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг огт хангаагүй өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	80
Хүснэгт 5.1.	Зориулалтын бус, бусад байранд амьдардаг өрхийн сууцны өмчийн болон эзэмшлийн хэлбэрээр, 2010 он .....	82
Хүснэгт 5.2.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны өмчийн хэлбэр, аймаг, нийслэлээр, 2010 он .....	83
Хүснэгт 5.3.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, аймаг, нийслэл, хувиар, 2010 он .....	84
Хүснэгт 5.4.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, ундны усны эх үүсвэрээр, 2010 он .....	85
Хүснэгт 5.5.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усны эх үүсвэр, хувиар, 2010 он .....	86
Хүснэгт 5.6.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хувиар, 2010 он .....	87
Хүснэгт 5.7.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэр, хувиар, 2010 он .....	87
Хүснэгт 5.8.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, бохир ус зайлуулдаг хэлбэрээр, 2010 он .....	88
Хүснэгт 5.9.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэлээр, бохир ус зайлуулдаг хэлбэр, хувиар 2010 он .....	88
Хүснэгт 5.10.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэрээр, 2010 он .....	89
Хүснэгт 5.11.	Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэрээр, 2010 он .....	90

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Өрх, өрхөд хамааралгүй тоологдсон хүн амын тоо, 2010 он.....	14
Зураг 2.2.	Өрхийн тоо, хэлбэрээр, 2010 он.....	19
Зураг 2.3.	Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2010 он.....	22
Зураг 2.4.	Өрхийн тоо, сууцны ахуйн нөхцөлийг хангасан байдал, 2010 он.....	37
Зураг 3.1.	Гэрт амьдардаг өрхийн тоо, гэрийн ханын тоогоор, хувиар, 2010 он.....	41
Зураг 3.2.	Долоо түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин, аймаг, нийслэлээр, 2010 он.....	45
Зураг 3.3.	Гэрт амьдардаг өрхийн тоо, цахилгааны эх үүсвэрээр, хувиар, 2010 он.....	46
Зураг 3.4.	Гэрт амьдардаг цахилгаанаар хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он.....	47
Зураг 3.5.	Гэрт амьдардаг хотын нийт өрхөд цахилгааны эх үүсвэргүй өрхийн эзлэх хувь, 2000, 2010 он.....	49
Зураг 3.6.	Гэрт амьдардаг өрхийн тоо, усан хангамжийн эх үүсвэр, хувиар, 2010 он.....	54
Зураг 3.7.	Гэрт амьдардаг хот, хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлөөр хангасан байдал, хувиар, 2010 он.....	62
Зураг 4.1.	Байшинд амьдардаг нийт өрхөд 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь, 2000, 2010 он.....	65
Зураг 4.2.	Байшинд амьдардаг цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо, аймаг, нийслэл, хувиар, 2010 он.....	69
Зураг 4.3.	Байшинд амьдардаг өрхийн, хатуу хог, хаягдал зайлуулалтын хэлбэр, хувиар, 2010 он.....	73
Зураг 4.4.	Байшинд амьдардаг өрхийн бохир ус зайлуулалтын хэлбэр, хувиар, 2010 он.....	74
Зураг 4.5.	Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдал, 2010 он.....	80

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хавсралт 2.2.	Хотын өрхийн тоо, аймаг нийслэл, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөөгөөр, 2010 он.....	98
Хавсралт 2.1.	Өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны эзэмшил, хот, хөдөөгөөр, 2010 он.....	99
Хавсралт 4.1	Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны талбай, хот, хөдөөгөөр, 2010 он.....	100
Хавсралт 4.2.	Байшинд амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, өрөөний тоо, хувиар, 2010 он.....	101
Хавсралт 4.3.	Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, өрөөний тоо, хувиар, 2010 он.....	102

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОРОН СУУЦНЫ ТУХАЙ  
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ



## 1.1. ТОВЧ ОЙЛГОЛТ

Хүн амьд явах үндсэн нөхцөлийн нэг нь орон сууц юм. Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ орон сууцны хүрэлцээ хангамж, тав тухтай байдлын тухай тоо баримтыг 40 гаруй жилийн өмнөөс цуглуулж ирсэн баялаг туршлагатай. Хүн ам, орон сууцны 1969 оноос хойших 5 удаагийн тооллогод хүн амын орон сууцны нөхцөлийн талаарх тоо баримтыг гаргаж иржээ. Үүнээс гадна 1940, 1969, 1979, 1989 онд улс, хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллого явуулж байсан аж. Тус улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш ард иргэдээ орон сууцжуулах үүний дотор төрийн өмчийн орон сууцыг үнэ төлбөргүй хувьчлах тухай хуулийг 1996 онд батлан хэрэгжүүлснээр улс, хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллого явуулах шаардлагагүй болсон билээ.

Монгол Улсын төр засгаас сүүлчийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд орон байрны асуудлыг шийдвэрлэхийн чухлыг анхаарч, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ. Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогод "Орон сууцны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын төвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл амьдрах нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй хэсэг юм" гэж тодорхойлсон байдаг.

## 1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Орон сууцны төрөл, ахуйн нөхцөлийн сэдэвчилсэн судалгааны гол зорилго нь хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнг үндэслэн орон сууцны төрөл, ахуйн нөхцөл байдлыг 2000 оны холбогдох үзүүлэлтэй зэрэгцүүлж, өнгөрсөн 10 жилд манай улсын хүн амын сууцны төрөл, ахуйн нөхцөл хэр зэрэг өөрчлөгдсөнийг улсын хэмжээгээр аймаг, нийслэлийн төвшинд тодорхойлоход оршино. Цаашид хүн амын орон сууцны хүрэлцээ хангамж, орон сууцны төрөл, нөхцөлийг сайжруулах, ялангуяа хүн амын эрүүл ахуйн нөхцөл, орчны бохирдлыг багасгах талаар төр засгаас баримтлах бодлого хөтөлбөрийг боловсруулахад суурь мэдээлэл, санал зөвлөмж гаргахад чиглэгдэж буй.

## 1.3. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ОРОН СУУЦТАЙ ХОЛБОГДОХ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн ам, орон сууцны тооллогод сууц гэдэг ойлголтыг ихээхэн өргөн хүрээгээр авч үздэг. Тухайлбал; бүх төрлийн байшин, гэр, цаатны урц, оюутан сурагчид, ажиллагчдын дотуур болон нийтийн байр, цэргийн хүрээ, хорих анги, асрамжийн газрын байр зэрэг хүн амьдрахад зориулагдсан бүхий л байр сууцыг хамруулахаас гадна хүн амьдрахад зориулагдаагүй, аж ахуйн нэгж, албан байгууллагад тохируулан төрөл бүрийн зориулалтаар барьсан, хүмүүс оршин сууж амьдрахаар тохижуулсан барилга байшин болон тооллогын товын үед хүн амьдарч байсан орон сууцны орц, хонгил, дулааны шугам сүлжээний худаг, вагончик, түр урц зэргийг хамруулдаг.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод өрх, хүн амын амьдарч байгаа сууцыг гэр, байшин, зориулалтын бус болон бусад сууц гэж дөрөв ангилж тодорхойлов.

№	Ойлголт	Тодорхойлолт
1.	<b>Гэр</b>	Монголын ард түмний уламжлалт сууц болох бүх төрлийн гэр, цаатны урцыг хамааруулсан.
2.	<b>Байшин</b>	Байшин гэж нэг, түүнээс дээш өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байрыг хэлнэ. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин, нийтийн зориулалтын бусад байрыг энд хамааруулсан.
3.	<b>Зориулалтын бус сууц</b>	Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй боловч хүн амьдрахад зориулан өөрчлөн засч тохижуулсан, гэхдээ тоолох үед хүн амьдарч байгаа сууцыг хамруулсан.
4.	<b>Бусад сууц</b>	Тоолох үед хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох, байрыг хамааруулсан. Байшинг төрлөөр нь орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, нийтийн байр, нийтийн зориулалтын бусад гэж ангилсан.
5.	<b>Орон сууцны байшин</b>	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
6.	<b>Бие даасан тохилог сууц</b>	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.
7.	<b>Сууцны тусдаа байшин</b>	Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
8.	<b>Оюутан сурагчдын нийтийн байр</b>	Бүх шатны сургуулиудийн оюутан, сурагчдын хамтран амьдрахад зориулагдсан байр
9.	<b>Ажиллагчдын нийтийн байр</b>	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр
10.	<b>Нийтийн зориулалтын бусад байр</b>	Амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр
11.	<b>Өрөөний тоо</b>	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.
12.	<b>Сууцны талбай (кв.метр)</b>	Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр

**13. Төвлөрсөн усан хангамж** Улсын болон тухайн орон нутгийн усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж байгууллагаас орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, нийтийн болон нийтийн зориулалтын бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа системийг хамруулна.

*Бие даасан систем.* Тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан бага хэмжээний, улсын болон орон нутгийн дулаан, усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж байгууллагаас хамааралгүйгээр бие даасан байдлаар ус түгээж байгаа системийг ойлгоно.

*Зөөврийн усан хангамж.* Өрхийн ус зөөдөг хэрэгслийн төрөл, хэлбэрээс үл хамааран, усны машинаар ус зөөвөрлөдөг ус, ус түгээх байр, гүний худаг, уурхайн худаг, усан сан, суваг, усжуулалтын хоолой, булаг, шанд, гол мөрөн нуур зэрэг гадаргууны ус, борооны болон тогтоол усыг хамааруулна.

**14. Төвлөрсөн бус усан хангамж**

*Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр.* Хот, суурин газрын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байр.

*Хамгаалагдсан худаг.* Зураг төслийн дагуу баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг, дээгүүрээ байгууламжтай, эрүүл ахуйн бүс тогтоож хашсан, хамгаалтад байдаг. Амьтан орох боломжгүй худгийг хамааруулна.

*Хамгаалагдсан булаг шанд.* Усны эх ундарга нь тусгай хамгаалалтад байдаг, засч тохижуулан хашиж хамгаалсан булаг шандыг хамааруулна.

*Цэвэршүүлж савласан ус.* Аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн цэвэршүүлэн савласан ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.

**15. Цахилгааны эх үүсвэр**

*Төвлөрсөн систем.* Төрийн өмчийн дулааны болон усан цахилгаан станц, гадаадаас цахилгаан дамжуулах сүлжээгээр (Дэд станц) цахилгаанаар хангагддаг бол төвлөрсөн систем гэж ойлгоно.

*Дизель станц.* Орон нутгийн хэмжээнд бие даасан дизель станцад холбогдсон сүлжээгээр цахилгаанаа авдаг өрхийг хамруулна.

*Сэргээгдэх эрчим хүч.* Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан эрчим хүч болгодог төхөөрөмжийг хамруулна.

*Бага оврын цахилгаан үүсгүүр.* Тухайн нэг өрх болон хэсэг өрхийн цахилгааны хэрэгцээг хангах зорилготой бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг хамруулна.

*Төвлөрсөн систем.* Дулааны цахилгаан станц, төвлөрсөн уурын зуухаар дулааны шугам сүлжээнд холбогдсон сууцыг хамруулна.

*Нам даралтын зуух.* Нэг болон хэсэг өрхийн дулааныг хангахад зориулсан бага оврын төхөөрөмжөөр дулаан хангах төхөөрөмж.

**16. Халаалтын эх үүсвэр**

*Цахилгаан үүсгүүр.* Тухайн өрхийн дулааны хэрэгцээг хангахад зориулсан цахилгаан эрчим хүчээр ажилладаг төхөөрөмж.

*Ердийн галлагаа.* Бүх төрлийн түлээ, нүүрсээр галладаг пийшин, зуух ашигладаг өрх.

<p>17. <b>Ариун цэврийн байгууламж</b></p>	<p><i>Сайжруулсан ариун цэврийн байгууламж.</i> Ариутгах татуурга (Ариутгах татуурга гэж бохир усыг цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээг хамруулна) бүхий ариун цэврийн байгууламж, түүнчлэн ердийн нүхэн жорлонг оруулна.</p> <p><i>Сууцны доторх.</i> Сууц дотор байрлах, бохир усны төвлөрсөн болон бие даасан системд холбогдсон бие засах газар болон сууцны дотор талд байнга ашиглахаар суурилуулсан био суултуур.</p> <p><i>Сууцны гаднах.</i> Сууцны гадна байрлах нүхэн жорлон орно. Нүхэн жорлон гэдэгт агааржуулагч хоолой болон яндантай, газар ухаж доторлосон суудалд тааруулж гаргасан нүхтэй, гадна ус орохоос хамгаалж, бүх талаас нь хаалт хийсэн бие засах газар орно.</p>
<p>18. <b>Бохир ус зайлуулах төхөөрөмж.</b></p>	<p>Бохир усыг цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай шугам сүлжээ, барилга байгууламж бүхий төвлөрсөн болон бие даасан систем ашиглан зайлуулах, бохир усны цооногт цуглуулах, эсвэл задгай асгах байдлаар зайлуулдаг төхөөрөмж.</p> <p><i>Төвлөрсөн системээр зайлуулдаг.</i> Улсын болон орон нутгийн бохир ус зайлуулалт хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, нийтийн болон нийтийн зориулалтын бусад байрны төвлөрсөн байдлаар бохир усаа зайлуулдаг системийг хамруулна.</p> <p><i>Бие даасан системээр зайлуулдаг.</i> Тухайн орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан орон нутгийн усан хангамж хариуцсан аж ахуйн нэгж байгууллагаас хамааралгүйгээр бохир усаа зайлуулах бага хэмжээний системийг оруулна.</p> <p><i>Цооногт асгадаг.</i> Зориулалтын муу усны цооног болон жорлонгийн нүхэнд хийж бохир усаа зайлуулдаг өрхийг хамруулна.</p>
<p>19. <b>Хатуу хог хаягдал зайлуулах</b></p>	<p><i>Үйлчилгээний байгууллагаар.</i> Улсын болон орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (Хог ачигч) гэрээ хийж хог хаягдлыг тогтмол эсвэл тогтсон хугацаагүй ачиж зайлуулдаг тохиолдлыг хамрууллаа.</p> <p><i>Өөрсдөө зайлуулдаг</i> <i>Зөвшөөрсөн цэгт.</i> Албан ёсны тохижилт үйлчилгээний байгууллагын зааварчилгаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн цэгт зайлуулдаг тохиолдлыг хамрууллаа.</p> <p><i>Тогтсон газар байхгүй.</i> Тухайн өрх хатуу хог хаягдлыг зайлуулах тодорхой газар байхгүй ил задгай асгадаг, булдаг, шатаадаг тохиолдлыг хамруулав.</p>





*Хүмүүнд төр эрхэм. Мөрд хүмүүн эрдэнэ*

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ  
ТӨРӨЛ, НӨХЦӨЛ



## 2.1. МОНГОЛ УЛСЫН ӨРХИЙН ТОО, ӨӨРЧЛӨЛТ

### ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Нэг орон байранд амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралынхаа наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг **өрх** гэнэ. Өрхийн ам бүл хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой болон огт хамааралгүй хүмүүс байж болно гэсэн ерөнхий ойлголтыг 2010 оны тооллогод баримталсан нь өмнөх тооллогынхтой тохирч байгаа юм. Гэвч өрхөд тоолсон, өрх үүсгээгүй тоолсон хүний тодорхойлолт өмнөх тооллогоос ялгаатай байв. Гэр бүл, ураг төрлийн хамааралтай хүмүүс өрх болж тоологдох, хоорондоо огт хамааралгүй хүмүүс нэг орон байранд хамт тоологдох гэсэн 2 хэлбэр байлаа. Өрхөд хамаарахгүй хүмүүст цэрэг, хоригдол, оюутан, албан болон албан бусаар ашигт малтмал олборлогчид, орон гэргүй иргэн зонхилж байсан. Энэ нь хүн амын орон сууцны төрөл, зориулалтыг тодорхойлоход зайлшгүй анхаарах асуудал юм.

ЗУРАГ 2.1. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2010 ОН



Суурин хүн амын 96.5 хувь нь 713.8 мянган өрхөд, үлдсэн 3.5 хувь буюу 93.8 мянган хүн өрхөд хамаарахгүйгээр тоологджээ. Өрхөд тоологдсон хүний хувь өмнөх тооллогын үеэс 2 пунктээр буурсан бол өрхөд хамаарахгүй хүний хувь эсрэгээрээ 2 пунктээр нэмэгдсэн нь оюутан, сурагчид, албан бусаар ашигт малтмал олборлогч нэмэгдсэнтэй холбоотой.

ХҮСНЭГТ 2.1. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Байршил	2000		2010		2010 / 2000 %
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>541.1</b>	<b>100.0</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>131.9</b>
Хот	296.4	54.8	479.5	67.2	161.8
Хөдөө	244.7	45.2	234.3	32.8	95.7

ЗУРАГ 2.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Нийт өрхийн 10.6 хувь нь ганц бие, 62.4 хувь нь ам бүлээрээ, 24.9 хувь нь нийлмэл, 2.1 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Нийлмэл буюу эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрх ч олон юм. Энэ нь манай орны өрхийн ам бүлийн бүтцийн түгээмэл хэлбэр бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь эцэг эх, ахмад настнаа хүндлэн асардаг уламжлалт заншилтай холбоотой. Түүнээс гадна өрхийн гишүүдийн дотор өрхийн тэргүүлэгчтэй садан төрлийн, холын хамаатан эсвэл садан төрлийн холбоогүй хүмүүс хамт амьдрах тохиолдол ч байна.

Өрхийг хэлбэрээр нь ангилж, аймаг, нийслэлээр харуулахад ялгаатай байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 2.2. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР,  
2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл өрх		Холимог өрх	
		мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>75.9</b>	<b>10.6</b>	<b>445.0</b>	<b>62.4</b>	<b>177.9</b>	<b>24.9</b>	<b>14.9</b>	<b>2.1</b>
Архангай	24.6	3.3	13.5	18.0	73.5	2.9	11.9	0.3	1.2
Баян-Өлгий	19.2	0.7	3.5	15.2	79.0	3.3	17.1	0.1	0.3
Баянхонгор	21.7	3.0	13.8	14.8	68.2	3.6	16.4	0.3	1.6
Булган	15.8	2.0	12.6	11.0	69.5	2.5	16.1	0.3	1.8
Говь-Алтай	14.6	1.7	11.7	10.7	73.3	2.1	14.2	0.1	0.8
Дорноговь	16.5	2.4	14.6	10.1	61.1	3.5	20.9	0.6	3.4
Дорнод	18.9	2.4	12.5	10.7	56.8	5.0	26.3	0.8	4.4
Дундговь	10.9	1.3	11.7	7.2	65.7	2.2	20.2	0.3	2.4
Завхан	18.6	2.3	12.3	13.5	72.5	2.6	14.1	0.2	1.1
Өвөрхангай	28.1	2.9	10.3	19.3	68.7	5.6	19.8	0.3	1.1
Өмнөговь	14.9	2.2	14.8	9.5	63.9	2.7	18.3	0.4	3.0
Сүхбаатар	14.1	1.3	9.4	9.4	66.7	3.1	21.9	0.3	2.1
Сэлэнгэ	26.9	2.9	10.7	18.4	68.3	5.2	19.3	0.5	1.7
Төв	24.7	3.5	14.0	16.9	68.4	3.9	16.0	0.4	1.6
Увс	18.6	1.7	9.0	14.5	77.8	2.3	12.1	0.2	1.0
Ховд	18.9	1.6	8.7	14.3	75.3	2.8	14.6	0.3	1.4
Хөвсгөл	33.0	4.0	12.3	24.0	72.6	4.6	13.8	0.5	1.4
Хэнтий	19.1	2.9	15.0	12.2	63.9	3.5	18.3	0.5	2.8
Дархан-Уул	24.2	2.3	9.5	14.9	61.5	6.5	27.0	0.5	2.0
Улаанбаатар	302.2	28.8	9.5	162.7	53.8	103.0	34.1	7.7	2.5
Орхон	24.3	2.2	8.9	15.4	63.3	6.4	26.4	0.4	1.5
Говьсүмбэр	3.8	0.6	15.5	2.5	64.0	0.7	18.8	0.1	1.7

Ганц бие өрхийн нийт өрхөд эзлэх хувь Говьсүмбэр, Хэнтий, Өмнөговь, Дорноговь аймгуудад өндөр байгаа бол харин нийлмэл ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Улаанбаатар, Орхон, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дундговь аймгуудад, холимог өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дорнод, Дорноговь, Өмнөговь аймгуудад илүү хувийн жинтэй байна.

### ХҮСНЭГТ 2.3. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд			Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл ам бүлтэй өрх		Холимог ам бүлтэй өрх	
	мян. өрх	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>75.9</b>	<b>10.6</b>	<b>445.0</b>	<b>62.4</b>	<b>177.9</b>	<b>24.9</b>	<b>14.9</b>	<b>2.1</b>		
Хот	479.5	47.2	9.9	275.6	57.5	145.2	30.3	11.4	2.4		
Хөдөө	234.3	28.7	12.2	169.4	72.3	32.7	13.9	3.5	1.5		

Өрхийн бүтцийг хот, хөдөөгөөр ангилахад ялгаатай тал нэлээд ажиглагдана. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод (145.2 мянга) хөдөөнөөс (32.7 мянга) 4.4 дахин их байгаа нь өмнөх тооллогын үеэс (2000 онд энэ үзүүлэлт 2 дахин их байсан) 2 дахин өсчээ. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ, хангамж дутмаг, хөдөөгөөс шилжин ирэгчид хамаатан садантайгаа хамт амьдрах нь ихэссэн нь нөлөөлж байна. Үүний зэрэгцээгээр хотод ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеэс 2.1 дахин нэмэгдсэн нь хөдөөгөөс шилжин ирэгчид тусдаа өрх үүсгэн тоолуулсантай холбоотой юм.

### ХҮСНЭГТ 2.4. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд		1-2		3-4		5-6		7+	
	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>190.6</b>	<b>26.7</b>	<b>337.6</b>	<b>47.3</b>	<b>154.0</b>	<b>21.6</b>	<b>31.6</b>	<b>4.4</b>
Хот	479.5	100.0	124.0	25.9	229.7	47.9	102.3	21.3	23.6	4.9
Хөдөө	234.3	100.0	66.6	28.4	107.9	46.1	51.7	22.1	8.0	3.4

Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.3 байсан бол 2010 онд 3.6 болж буурав. Өрхийн ам бүлийн тоо хот, хөдөөд ялгаатай боловч 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд адил байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь сүүлчийн 10 жилд ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2000 онд 1-2 ам бүлтэй өрх хөдөөд хотоос 4.5 пунктээр илүү байсан бол 2010 онд хотод хөдөөгөөс 2.5 пунктээр илүү болсон байна. Энэ нь хотод их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр эрхлэхээр шилжин ирэгчид тусдаа эсвэл хамаатнууд нийлж өрх болж тоологдсонтой холбоотой байж болох талтай. Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо ч хотод хөдөөгөөс 3 дахин олон байгаа нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Ерөнхийд нь дүгнэж үзвэл хөдөөгөөс хот суурин руу чиглэсэн шилжих хөдөлгөөн хотын өрхийн бүтцэд багагүй нөлөөлж байгааг тооллогын дүн харуулна.


Өрхийн ам бүлийн дундаж тоо Баян-Өлгий аймагт хамгийн өндөр бөгөөд улсын дунджаас бараг нэг хүнээр илүү байна. Энэ зөрүү 2000 оноос нэмэгдсэн нь улсын хэмжээний өрхийн ам бүлийн тоо өмнөх тооллогын үеэс нэлээд буурсантай холбоотой.

Ховд, Увс аймгийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дунджаас бас илүү байна. Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий аймагт улсын дунджаас 3 дахин илүү байгаа нь үндэсний онцлог юм. Увс, Ховд аймаг, Улаанбаатар хотод уг үзүүлэлт улсын дунджаас дээгүүр байна.

## 2.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ

Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэрт, байшин, зориулалтын бус, бусад гэж ангилсаныг дээр тэмдэглэсэн. Зориулалтын бус, бусад гэсэн ангиллын сууц хүний амьдрах тав тухтай орчинг хангах шаардлагад нийцэхгүй гэсэн агуулгыг илэрхийлж байгаа юм. Дараагийн тэмдэглэх зүйл бол нэгээс илүү сууцтай өрхийн хувьд хүйтний улиралд амьдардаг сууцных нь байдлаар тооллогын асуулгыг оруулж тодорхойлсон болно.

ЗУРАГ 2.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010 ОН



Орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 45.2 хувь нь уламжлалт сууц гэрт, 53.6 хувь нь байшинд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцад амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеэс 5.7 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 4.6 пунктээр нэмэгджээ. Энэ нь өрх сүүлчийн жилүүдэд хот, хөдөөд орон сууцад амьдрах, өөрсдөө байшин барьж суух нь нэмэгдэж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.5. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>479.5</b>	<b>100.0</b>	<b>234.3</b>	<b>100.0</b>
Гэр	322.8	45.2	156.7	32.7	166.1	70.9
Байшин	382.8	53.6	316.1	65.9	66.7	28.5
Зориулалтын бус сууц	8.1	1.1	6.6	1.4	1.5	0.6
Бусад	0.1	0.0	0.1	0.0	0.0	0.0

Хотын болон хөдөөний өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 65.9 хувь нь байшинд, 32.7 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, гэрт амьдардаг өрхийнх нэмэгджээ. Гол төлөв томоохон хот, аймгийн төвүүдэд хөдөөгөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд эхлээд гэр хороололд суурьшдагтай холбоотой. Хотын байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 48.8 хувиар өссөн боловч гэрт амьдрагчдын тоо илүүтэй нэмэгджээ. Хөдөөгийн өрхийн 70.9 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 7.4 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрхийнх 6.8 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө хот, хөдөөгийн гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жингийн зөрүү тооллого хооронд буурч байна. Хот,

хөдөөд байшинд амьдардаг өрх нэмэгдэж байгаа нь тохилог сууцад суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч, орон сууцаар хангах бодлого хөтөлбөрийн үр дүн тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгааг харуулж байна.

Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 21.3 хувийг эзэлж, 2000 оноос 0.7 пунктээр буурсан байна. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2000 оноос 4.7 пунктээр өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух бололцоо нэмэгдсэнийг харуулах үзүүлэлт юм. Нийт өрхийн 0.5 хувь нь бие даасан тохилог сууцад амьдарч байгаа нь хот суурин газарт тохилог сууц (хаус) нэмэгдэж буйг харуулна. Өмнөх тооллогын үед ийм төрлийн сууц барьж суух нь эхлэлийн төдий байсан тул тусд нь тодорхойлоогүй байжээ.

### ХҮСНЭГТ 2.6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Сууцны төрөл	2000		2010	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>541.1</b>	<b>100.0</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>
Гэр	275.6	50.9	322.8	45.2
Зориулалтын бус сууц	3.4	0.6	8.1	1.1
Бусад	0.8	0.1	0.1	0.0
Байшин	261.3	48.3	382.8	53.6
Орон сууцны байшин	119.0	22.0	152.3	21.3
Бие даасан тохилог сууц <sup>1</sup>	-	-	3.8	0.5
Сууцны тусдаа байшин	133.9	24.7	209.9	29.4
Нийтийн байр <sup>2</sup>	8.4	1.6	16.7	2.3

<sup>1</sup> 2000 онд бие даасан тохилог сууцыг тусад нь тодорхойлоогүй

<sup>2</sup> оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байрыг хамт авч үзэв.

Гэрт амьдардаг өрх хөдөөд дийлэнх байгаа боловч сумын төв, хөдөөгөөр ангилахад ялгаа нь илүү тодорхой харагдана. Тухайлбал, сумын төвд оршин суудаг өрхийн 46.9 хувь, хөдөөгийн 14.9 хувь нь байшинд амьдарч, 2000 оноос 3.6-4.8 пунктээр нэмэгдсэн. Энэ нь нэг талаас хүн амын амьжиргааны төвшин 2000 онтой харьцуулахад дээшилж байшинд тохь тухтай амьдрах нөхцөл бүрдсэнтэй холбоотой.

### ХҮСНЭГТ 2.7. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Сууцны төрөл	Бүгд	Байршил				
		Хөдөө	Сумын төв	Тосгон	Аймгийн төв	Улаанбаатар
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Гэр	45.2	84.7	52.0	36.7	39.4	28.9
Байшин	53.6	14.9	46.9	62.3	59.1	69.7
Зориулалтын бус сууц	1.1	0.3	1.1	1.0	1.5	1.4
Бусад <sup>1</sup>	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

<sup>1</sup> оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн бусад байр



Тосгонд амьдардаг өрхийн 62.3 хувь нь байшинд амьдарч байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх тооллогын үр дүнтэй харьцуулах боломжгүй юм. Учир нь “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” Монгол Улсын хуулийн дагуу тосгонд хамаарах суурин 2000 онд 29 байснаа 2010 онд 17 болж өөрчлөгдсөн.

Өрхийн тоог амьдардаг орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай тал ажиглагдана.

#### ХҮСНЭГТ 2.8. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрх-бүгд	Гэрт амьдардаг өрх			Байшинд амьдардаг өрх			Зориулалтын бус, бусад		
		Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>45.2</b>	<b>32.7</b>	<b>70.9</b>	<b>53.6</b>	<b>65.9</b>	<b>28.5</b>	<b>1.1</b>	<b>1.4</b>	<b>0.6</b>
Архангай	100.0	73.6	43.0	82.9	26.2	56.7	16.8	0.3	0.2	0.3
Баян-Өлгий	100.0	5.1	2.9	6.3	94.5	96.5	93.4	0.4	0.6	0.3
Баянхонгор	100.0	86.2	74.8	93.3	13.5	24.9	6.3	0.4	0.3	0.4
Булган	100.0	53.6	21.5	65.3	45.8	77.4	34.3	0.6	1.1	0.4
Говь-Алтай	100.0	83.5	68.1	91.1	16.0	31.7	8.2	0.6	0.3	0.8
Дорноговь	100.0	45.4	32.0	63.7	53.2	66.5	35.2	1.4	1.6	1.1
Дорнод	100.0	31.5	16.1	50.6	62.0	74.1	47.0	6.5	9.8	2.4
Дундговь	100.0	82.4	71.1	88.4	17.2	28.2	11.2	0.4	0.6	0.4
Завхан	100.0	74.9	57.9	80.8	24.8	41.6	18.9	0.3	0.5	0.3
Өвөрхангай	100.0	82.2	67.0	91.4	17.5	32.7	8.2	0.3	0.3	0.4
Өмнөговь	100.0	80.1	72.2	85.0	19.1	26.7	14.4	0.8	1.1	0.6
Сүхбаатар	100.0	69.7	50.4	78.3	28.3	45.4	20.7	2.0	4.2	1.0
Сэлэнгэ	100.0	24.6	12.7	36.3	74.6	86.5	62.9	0.8	0.8	0.9
Төв	100.0	62.1	39.7	66.2	36.7	57.7	32.9	1.2	2.6	1.0
Увс	100.0	84.9	78.0	89.0	14.8	21.8	10.7	0.3	0.2	0.3
Ховд	100.0	73.4	58.9	81.9	26.1	40.7	17.5	0.5	0.4	0.5
Хөвсгөл	100.0	62.7	45.0	72.1	36.9	54.8	27.5	0.4	0.2	0.5
Хэнтий	100.0	61.7	51.4	70.3	37.7	47.9	29.1	0.7	0.7	0.6
Дархан-Уул	100.0	17.5	16.6	22.0	81.0	81.8	77.1	1.5	1.6	0.9
Улаанбаатар	100.0	29.0	29.0	-	69.7	69.7	-	1.4	1.4	-
Орхон	100.0	24.4	23.6	46.5	74.6	75.4	52.9	1.0	1.0	0.6
Говьсүмбэр	100.0	35.7	38.2	29.0	62.8	61.4	66.7	1.5	0.5	4.4

Гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баянхонгор, Увс, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад (Дархан-Уул, Орхон аймгийг оруулахгүйгээр) бусдаас өндөр байгаа нь өмнөх тооллогын үетэй бараг адил байна. Харин байшинд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин Баян-Өлгий, Сэлэнгэ, Дорнод аймгуудад (Дархан-Уул, Орхон аймгийг оруулахгүйгээр) бусдаас өндөр байгаа нь өмнөх тооллогын үетэй ижил байгаагаас үзэхэд аймгийн гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жингийн харьцаа өнгөрсөн 10 жилд өөрчлөгдсөнгүй. Баян-Өлгий аймгийн нийт өрхөд байшинд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин 2000 онд 91.7 байсан бол 2010 онд 96.5 болж өсчээ. Тус аймгийн ард түмэн эрт үеэс уламжлан том гэрт амьдарч ирсэн боловч уг гэр нь өвлийн улиралд хүйтэн, дулаан хадгалах чадвар муу байдагтай холбоотойгоор Казахууд хот, хөдөөгүй байшин барьж амьдардаг

болсонтой холбоотойгоор байшинд суудаг өрхийн тоо бусад аймгаас өндөр байна. Гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин 2010 онд 2000 оноос Дархан-Уул аймагт 4.9 пунктээр, Орхон аймагт 5.4 пунктээр тус тус нэмэгдсэн нь эдгээр аймгуудад бусад аймгаас олон өрх шилжин ирж тэд гол төлөв гэр хороололд суурьшиж байгаатай холбоотой.

### 2.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

Сууцны өмчийн хэлбэрийг 2010 оны тооллогод тодорхойлохдоо төрийн болон хувийн гэх 2 ангилалд хувааж, хувийн өмчийг дотор нь иргэний, аж ахуй нэгж байгууллагын гэж ангилсан. Уг үзүүлэлтийг 2000 онд төрийн, хувийн, холимог гэж ангилж байжээ. Сууцны өмчийн хэлбэрийг 2000 оныхтой ерөнхий ангиллын хувьд харьцуулж үзэв.

#### ХҮСНЭГТ 2.9. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Сууц төрөл	Бүгд		Төрийн өмчийн		Хувийн өмчийн			
					Аж ахуйн нэгж, байгууллагын		Иргэний	
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>11.6</b>	<b>1.6</b>	<b>15.5</b>	<b>2.2</b>	<b>686.7</b>	<b>96.2</b>
Гэр	322.8	100.0	1.3	0.4	1.3	0.4	320.3	99.2
Байшин	382.8	100.0	9.4	2.5	11.0	2.9	362.4	94.7
Зориулалтын бус сууц	8.1	100.0	0.9	11.4	3.2	39.9	3.9	48.8
Бусад	0.1	100.0	0.0	31.9	0.0	31.9	0.0	36.1

Нийт өрхийн 98.4 хувь хувийн (96.2 хувь нь иргэний, 2.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцад амьдарч байгаа нь 2000 оноос 7.7 пунктээр нэмэгджээ. Гэрт суудаг өрхийн 99.6 хувь нь хувийн (99.2 хувь нь иргэний, 2.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцад байгаа нь 2000 оноос 0.1 пунктээр өсөв. Байшинд амьдардаг өрхийн 2.5 хувь нь төрийн өмчийн сууцад, 97.5 хувь нь хувийн (94.7 хувь нь иргэний, 2.9 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцад амьдарч байна. Харин 2000 оны тооллогын дүнгээс үзэхэд байшинд амьдардаг нийт өрхийн 16.6 хувь нь төрийн, 81.6 хувь нь хувийн өмчийн сууцад амьдарч байжээ. Төрийн өмчийн сууц ийнхүү багассан нь улсаас сууцыг хувьчилж, иргэдээ өмчтэй болгох бодлого хэрэгжүүлэх ажил дууссантай холбоотой.

#### ХҮСНЭГТ 2.10. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Өмчлөлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>479.5</b>	<b>100.0</b>	<b>234.3</b>	<b>100.0</b>
Төрийн өмчийн	11.6	1.6	7.4	1.5	4.2	1.8
Хувийн өмчийн	702.2	98.4	472.1	98.5	230.0	98.2
ААНБ-ын	15.5	2.2	12.6	2.6	2.9	1.3
Иргэний	686.7	96.2	459.6	95.8	227.1	96.9

Өрхийн өмчийн хэлбэрийг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд төрийн өмчийн сууцад амьдарч байгаа өрх хөдөөд (1.8 хувь), хотоос (1.5) илүү байсан бол 2000 онд эсрэгээрээ хотод (12.5 хувь), хөдөөгөөс (3.1 хувь) илүү байжээ. Хувийн өмчийн сууцад амьдардаг өрх хөдөөд 98.2 хувь, хотод 98.5 хувь байгаа нь 2000 оноос тус тус 1.6, 12.6 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 2.11. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨРХИЙН СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо-бүгд	Өмчийн хэлбэрээр			Өрхийн тоо-бүгд	Өмчийн хэлбэрээр		
		төрийн	аж ахуйн нэгжийн	иргэний		төрийн	аж ахуйн нэгжийн	иргэний
<b>БҮГД</b>	<b>713 780</b>	<b>11 610</b>	<b>15 498</b>	<b>686 672</b>	<b>100.0</b>	<b>1.6</b>	<b>2.2</b>	<b>96.2</b>
Архангай	24 551	160	171	24 220	100.0	0.7	0.7	98.7
Баян-Өлгий	19 225	144	205	18 876	100.0	0.7	1.1	98.2
Баянхонгор	21 695	161	111	21 423	100.0	0.7	0.5	98.7
Булган	15 807	148	162	15 497	100.0	0.9	1.0	98.0
Говь-Алтай	14 562	205	99	14 258	100.0	1.4	0.7	97.9
Дорноговь	16 543	927	773	14 843	100.0	5.6	4.7	89.7
Дорнод	18 895	625	671	17 599	100.0	3.3	3.6	93.1
Дундговь	10 895	253	104	10 538	100.0	2.3	1.0	96.7
Завхан	18 574	193	126	18 255	100.0	1.0	0.7	98.3
Өвөрхангай	28 051	303	109	27 639	100.0	1.1	0.4	98.5
Өмнөговь	14 939	393	246	14 300	100.0	2.6	1.6	95.7
Сүхбаатар	14 145	493	153	13 499	100.0	3.5	1.1	95.4
Сэлэнгэ	26 889	355	826	25 708	100.0	1.3	3.1	95.6
Төв	24 687	621	743	23 323	100.0	2.5	3.0	94.5
Увс	18 641	166	86	18 389	100.0	0.9	0.5	98.6
Ховд	18 944	155	139	18 650	100.0	0.8	0.7	98.4
Хөвсгөл	33 007	227	199	32 581	100.0	0.7	0.6	98.7
Хэнтий	19 147	938	349	17 860	100.0	4.9	1.8	93.3
Дархан-Уул	24 227	424	840	22 963	100.0	1.8	3.5	94.8
Улаанбаатар	302 242	3 809	8 789	289 644	100.0	1.3	2.9	95.8
Орхон	24 273	384	497	23 392	100.0	1.6	2.0	96.4
Говьсүмбэр	3 841	526	100	3 215	100.0	13.7	2.6	83.7

Өрхийн тоог сууцны өмчийн хэлбэр, аймаг нийслэлээр ангилж үзэхэд зарим нэг ялгаатай тал байна. Төрийн өмчийн сууцны нийт сууцад эзлэх хувийн жин улсын дүнгээр 1.6 хувь байхад энэ үзүүлэлт Говьсүмбэр аймагт 13.7 хувь байгаа нь улсын дунджаас бараг 9 дахин өндөр байна. Энэ нь тус аймгийн нутагт байгаа хуучин ЗХУ-ын цэргийн албан хаагчдын сууцыг төрийн төсөвт байгууллагууд мэдэлдээ авч засвар хийн ажиллагчдаа зээлээр өгсөн нь нөлөөлсөн ажээ. Мөн Дорноговь, Хэнтий аймгийн нийт сууцад улсын өмчийн сууцны эзлэх хувь улсын дунджаас нэлээд өндөр байна. Харин иргэний хувийн өмчийн сууцны нийт сууцад эзлэх хувийн жин дээрх аймгуудад ерөнхийдөө ойролцоо байгаа нь орон сууцны хувьчлал жигд явагдсаныг харуулна.

ХҮСНЭГТ 2.12. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ,  
ХУВИАР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>479.5</b>	<b>100.0</b>	<b>234.3</b>	<b>100.0</b>
Өөрийн эзэмшлийн	619.0	86.7	401.1	83.6	217.9	93.1
Бусдын сууцанд түрээстэй суудаг	45.0	6.3	40.9	8.5	4.0	1.7
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	43.5	6.1	33.0	6.9	10.6	4.5
Бусад	6.3	0.9	4.5	0.9	1.7	0.7

Улсын хэмжээний нийт өрхийн хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх зэргийг илэрхийлэх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Улсын хэмжээнд нийт өрхийн 13.3 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрээс 78.4 мянга нь хотын өрх юм. Хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь орон сууцны хэрэгцээг гол төлөв шинэ гэр, байшин барьж хангах боломжтой байдагтай холбоотой. Нэг орон байранд 2–оос дээш өрх хамт амьдарч байгаа нөхцөлд тэдний хэнийх нь сууц эзэмшигч болох хэнийх нь хамт сууж байгааг асуун ялгаж тоолсон тул эзэмшлийн хэлбэрийг тодорхой илэрхийлэх бололцоотой болсныг тэмдэглэх нь зүйтэй.

ХҮСНЭГТ 2.13. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР  
ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Өөрийн эзэмшлийн	Бусдын сууцанд түрээстэй амьдардаг	Бусдын сууцанд түрээсгүй амьдардаг	Бусад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>86.7</b>	<b>6.3</b>	<b>6.1</b>	<b>0.9</b>
Архангай	100.0	94.0	1.4	4.0	0.5
Баян-Өлгий	100.0	94.9	2.4	2.2	0.4
Баянхонгор	100.0	98.3	0.7	0.8	0.2
Булган	100.0	92.5	1.7	5.1	0.7
Говь-Алтай	100.0	96.1	2.0	1.7	0.2
Дорноговь	100.0	78.8	9.0	10.1	2.2
Дорнод	100.0	77.1	7.4	13.2	2.3
Дундговь	100.0	95.5	2.3	1.8	0.5
Завхан	100.0	95.3	1.3	2.8	0.6
Өвөрхангай	100.0	97.5	1.1	1.1	0.4
Өмнөговь	100.0	91.6	3.6	4.4	0.4
Сүхбаатар	100.0	90.0	1.7	6.7	1.6
Сэлэнгэ	100.0	84.3	4.7	9.7	1.2
Төв	100.0	88.1	3.4	6.9	1.6
Увс	100.0	97.5	0.8	1.2	0.5
Ховд	100.0	95.6	1.3	2.8	0.4
Хөвсгөл	100.0	92.6	1.0	5.8	0.6
Хэнтий	100.0	83.7	3.5	11.3	1.5
Дархан-Уул	100.0	81.5	10.4	7.4	0.7
Улаанбаатар	100.0	81.7	10.3	7.0	0.9
Орхон	100.0	86.5	6.3	6.7	0.4
Говьсүмбэр	100.0	84.9	6.2	7.9	0.9

Өөрийн эзэмших сууцгүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймаг, нийслэлд бусдаас өндөр байна. Өөрийн эзэмшлийн сууцгүй өрх хотод, ялангуяа Улаанбаатар, Дархан, Эрдэнэтэд ихэнх нь байна. Эдгээр 3 хотод өөрийн гэсэн сууцгүй нийт өрхийн 66 хувь нь оршин сууж байна. Нийслэл хотод 55.2 мянган өрх (Хавсралт-2.1) өөрийн гэсэн сууцгүй байгаад анхаарч Улаанбаатар хотыг орон сууцжуулах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатайг тооллогын дүн харуулж байна.

## 2.4. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

### ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг 2000 оноос нэлээд дэлгэрүүлж авсан. Энэ нь сүүлчийн жилд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсонтой холбоотой. Тиймээс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулахад суурь мэдээлэл болох юм.

### ХҮСНЭГТ 2.14. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>479.5</b>	<b>100.0</b>	<b>234.3</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	548.0	76.8	456.1	95.1	91.9	39.2
Дизель станц	19.7	2.8	9.3	1.9	10.4	4.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	110.2	15.4	6.3	1.3	103.9	44.4
Бага оврын цахилгаан үүсгүүр	12.3	1.7	2.2	0.5	10.1	4.3
Цахилгааны эх үүсвэргүй	23.6	3.3	5.6	1.2	18.0	7.7

Улсын хэмжээнд нийт өрхийн 96.7 хувь нь цахилгааны эх үсвэртэй байгаа нь өмнөх тооллогын үеэс 29.4 пунктээр илүү байв. Энэ нь улс орон даяар, ялангуяа хөдөөгийн айл өрхийг цахилгаанаар хангах талаар өнгөрсөн 10 жилд хэрэгжүүлсэн бодлого хөтөлбөрийн үр дүн харагдаж байна. Улсын хэмжээнд 23.6 мянган өрх цахилгаангүй байна. Энэ нь өмнөх тооллогын үеэс 7.5 дахин буурсан үзүүлэлт. Цахилгаангүй өрхийн 91.3 хувь нь гэрт амьдардаг бөгөөд 78.3 хувь нь хөдөө суудаг ажээ. Сэргээгдэх эрчим хүч ашигладаг өрхийн 94.3 хувь хөдөө орон нутагт байгаа нь ийм төхөөрөмжийн хэрэгцээ нэмэгдэхийг хүснэгтээс харж болно.

Цахилгааны эх үүсвэрээр хангах арга хэмжээ өмнөх тооллогын үеэс нэлээд сайжирсан боловч аймаг орон нутагт бас жигд биш байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 2.15. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо-бүгд	Цахилгааны эх үүсвэрээр			
		Үүсвэртэй	Хувь	Үүсвэргүй	Хувь
<b>БҮГД</b>	<b>713 780</b>	<b>690 170</b>	<b>96.7</b>	<b>23 610</b>	<b>3.3</b>
Архангай	24 551	22 437	91.4	2 114	8.6
Баян-Өлгий	19 225	18 575	96.6	650	3.4
Баянхонгор	21 695	20 236	93.3	1 459	6.7
Булган	15 807	14 985	94.8	822	5.2
Говь-Алтай	14 562	13 991	96.1	571	3.9
Дорноговь	16 543	15 634	94.5	909	5.5
Дорнод	18 895	18 000	95.3	895	4.7
Дундговь	10 895	10 338	94.9	557	5.1
Завхан	18 574	17 700	95.3	874	4.7
Өвөрхангай	28 051	26 449	94.3	1 602	5.7
Өмнөговь	14 939	14 102	94.4	837	5.6
Сүхбаатар	14 145	13 221	93.5	924	6.5
Сэлэнгэ	26 889	26 193	97.4	696	2.6
Төв	24 687	23 400	94.8	1 287	5.2
Увс	18 641	17 896	96.0	745	4.0
Ховд	18 944	17 702	93.4	1 242	6.6
Хөвсгөл	33 007	30 701	93.0	2 306	7.0
Хэнтий	19 147	17 916	93.6	1 231	6.4
Дархан-Уул	24 227	23 916	98.7	311	1.3
Улаанбаатар	302 242	298 935	98.9	3 307	1.1
Орхон	24 273	24 067	99.2	206	0.8
Говьсүмбэр	3 841	3 776	98.3	65	1.7

Улсын хэмжээний нийт өрхөд цахилгааны эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн эзлэх хувь Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Хэнтий аймгуудад бусдаас өндөр байгаад анхаарч арга хэмжээ авах шаардлагатайг харуулна. Нийслэл хотын өрхийн 1.1 хувь нь цахилгаан эх үүсвэргүй байгаа нь бага мэт боловч үнэндээ 3.3 мянган өрх буюу улсын хэмжээний цахилгаангүй өрхийн 14.0 хувийг эзэлж буй нь анхаарууштай асуудал юм.

Улсын хэмжээнд хот суурин газрын өрх үндсэндээ цахилгааны эх үүсвэртэй болсон. Хотын нийт өрхийн 1.2 хувь нь буюу 5.6 мянган өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангаагүй байгаагийн дотор Дундговь, Архангай, Сүхбаатар, Хэнтий аймгийн хотын өрхийн 2-оос дээш хувь нь цахилгаангүй байна (Хавсралт-2.2).

Хөдөөгийн өрхийн цахилгааны эх үүсвэрийн хувь нэлээд ялгаатай байгааг дараах хүснэгт харуулж байна.

ХҮСНЭГТ 2.16. ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо-бүгд	Цахилгааны эх үүсвэрээр			
		Үүсвэртэй	Хувь	Үүсвэргүй	Хувь
<b>БҮГД</b>	<b>234 277</b>	<b>216 278</b>	<b>92.3</b>	<b>17 999</b>	<b>7.7</b>
Архангай	18 792	16 819	89.5	1 973	10.5
Баян-Өлгий	12 145	11 539	95.0	606	5.0
Баянхонгор	13 306	11 950	89.8	1 356	10.2
Булган	11 590	10 829	93.4	761	6.6
Говь-Алтай	9 732	9 251	95.1	481	4.9
Дорноговь	7 004	6 240	89.1	764	10.9
Дорнод	8 415	7 624	90.6	791	9.4
Дундговь	7 079	6 622	93.5	457	6.5
Завхан	13 737	12 890	93.8	847	6.2
Өвөрхангай	17 439	15 955	91.5	1 484	8.5
Өмнөговь	9 292	8 522	91.7	770	8.3
Сүхбаатар	9 788	8 953	91.5	835	8.5
Сэлэнгэ	13 549	13 054	96.3	495	3.7
Төв	20 885	19 617	93.9	1 268	6.1
Увс	11 609	10 979	94.6	630	5.4
Ховд	11 939	10 742	90.0	1 197	10.0
Хөвсгөл	21 566	19 544	90.6	2 022	9.4
Хэнтий	10 401	9 342	89.8	1 059	10.2
Дархан-Уул	4 180	4 033	96.5	147	3.5
Орхон	821	794	96.7	27	3.3
Говьсүмбэр	1 008	979	97.1	29	2.9

Улсын хэмжээнд хөдөөгийн 18 мянга шахам өрх цахилгааны эх үүсвэргүй байгаа нь нийт өрхийн 7.7 хувь, эдгээр өрхийг цахилгаанаар хангах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ Архангай, Баянхонгор, Дорноговь, Ховд, Дорнод аймгийн хөдөөгийн өрхийг цахилгааны эх үүсвэртэй болгоход түлхүү анхаарах нь зүйтэй юм. Эдгээр аймгийн цахилгааны эх үүсвэргүй өрх хөдөөгийн улсын хэмжээний нийт өрхийн 40 орчим хувийг эзэлж байна.

**ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ**

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулгын хуудсанд өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлт, тухайлбал ундны усны эх үүсвэр, хатуу хог хаягдал болон бохир усаа зайлуулах хэлбэр, бие засах газар зэрэг үзүүлэлтийг оруулсан. Эдгээр үзүүлэлт нь өрхийн сууцны төрлөөс хамаарч ялгаатай байдлаар тоологдсон. Гэвч гэр, байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдлыг тус бүрд нь тодорхойлж, боломжтой үзүүлэлтийг улсын хэмжээгээр нэгтгэн үзүүлэв.

Энэ номын 3 дугаар бүлэгт гэрт амьдардаг, 4 дугаар бүлэгт байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдлын тус бүрийнх нь онцлогийг тусгасан болно. Ингэхдээ өрхийн ахуйн нөхцөлийн голлох 5 үзүүлэлтийг сонгож нэгтгэн, өрх ахуйн нөхцөлийг хэр зэрэг хангасныг дараах байдлаар ангилж харуулсан (гэр байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл тус бүрийн онцлогыг 3, 4 дүгээр бүлэгт тодорхой оруулав).

У - Ундны усны баталгаат эх үүсвэртэй өрх.

Ц - Цахилгааны эх үүсвэрээр хангасан өрх.

Ж - Бие засах газраа дангаараа ашигладаг өрх.

Б - Бохир ус зайлуулах систем, тодорхой цэгтэй өрх.

Х - Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, эсвэл зөвшөөрөгдсөн цэгт асаж, тогтмол зайлуулдаг өрх.

Өрхийг ахуйн нөхцөлийг хангасан байдлыг дараах 6 ангилал болгож үзэв. Үүнд:

- Ахуйн нөхцөл **сайтай** өрх (Дээрх 5 нөхцөлөөр бүгд хангасан)
- Ахуйн нөхцөлийг **хангасан** өрх ( Дээрх 5 нөхцөлөөс 4-нь хангасан)
- Ахуйн нөхцөлийг **хагас хангасан** өрх (Дээрх 5 нөхцөлөөс 3-нь хангасан)
- Ахуйн нөхцөлийг **дутуу хангасан** өрх (Дээрх 5 нөхцөлөөс 2-нь хангасан)
- Ахуйн нөхцөлийг **муу хангасан** өрх (Дээрх 5 нөхцөлөөс 1-нь хангасан)
- Ахуйн нөхцөлийг **хангаагүй** өрх (Дээрх 5 нөхцөлөөс альныг нь ч хангаагүй)

### ХҮСНЭГТ 2.17. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	УЦЖБХ	Хувь	Бүгд	УЦЖБХ	Хувь	Бүгд	УЦЖБХ	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>188 595</b>	<b>26.7</b>	<b>472 860</b>	<b>173 043</b>	<b>36.6</b>	<b>232 784</b>	<b>15 552</b>	<b>6.7</b>
Архангай	24 487	1 579	6.4	5 746	1 071	18.6	18 741	508	2.7
Баян-Өлгий	19 153	462	2.4	7 041	449	6.4	12 112	13	0.1
Баянхонгор	21 618	2 065	9.6	8 366	1 207	14.4	13 252	858	6.5
Булган	15 718	1 165	7.4	4 169	491	11.8	11 549	674	5.8
Говь-Алтай	14 476	1 512	10.4	4 817	869	18.0	9 659	643	6.7
Дорноговь	16 318	3 573	21.9	9 391	2 909	31.0	6 927	664	9.6
Дорнод	17 663	3 626	20.5	9 451	3 446	36.5	8 212	180	2.2
Дундговь	10 846	1 847	17.0	3 793	1 085	28.6	7 053	762	10.8
Завхан	18 515	1 705	9.2	4 815	766	15.9	13 700	939	6.9
Өвөрхангай	27 958	3 886	13.9	10 582	2 597	24.5	17 376	1 289	7.4
Өмнөговь	14 819	2 380	16.1	5 584	1 592	28.5	9 235	788	8.5
Сүхбаатар	13 860	1 685	12.2	4 173	1 246	29.9	9 687	439	4.5
Сэлэнгэ	26 666	4 012	15.0	13 235	2 803	21.2	13 431	1 209	9.0
Төв	24 389	3 080	12.6	3 704	1 480	40.0	20 685	1 600	7.7
Увс	18 588	2 831	15.2	7 016	1 757	25.0	11 572	1 074	9.3
Ховд	18 852	2 521	13.4	6 977	2 063	29.6	11 875	458	3.9
Хөвсгөл	32 878	2 531	7.7	11 417	1 560	13.7	21 461	971	4.5
Хэнтий	19 022	3 262	17.1	8 687	2 645	30.4	10 335	617	6.0
Дархан-Уул	23 869	10 845	45.4	19 727	9 656	48.9	4 142	1 189	28.7
Улаанбаатар	298 133	121 586	40.8	298 133	121 586	40.8	-	-	-
Орхон	24 032	11 032	45.9	23 216	10 834	46.7	816	198	24.3
Говьсүмбэр	3 784	1 410	37.3	2 820	931	33.0	964	479	49.7

Улсын хэмжээний нийт өрхийн 26.7 хувь нь ахуйн нөхцөлийг сайн хангасны дотор нийслэлээс гадна Эрдэнэт, Дархан зэрэг том хот төвтэй аймаг, хэдүйгээр хүн ам цөөнтэй боловч орон сууцны байшин олонтой Говьсүмбэр аймгийн өрхийн орон сууцны нөхцөл нь бусад аймгаас илүү сайн байдаг аж. Өрхийнх нь орон сууцны нөхцөл нь бусад аймаг, улсын дунджаас нэлээд доогуур байгаа аймагт Баян-Өлгий, Архангай, Булган, Хөвсгөл, Завхан,



Баянхонгор, Говь-Алтай зэрэг орж байна. Тооллогын дүнгээс үзэхэд хотын өрхийн орон сууцны нөхцөлийг хангасан байдал нь хөдөөгийн өрхөөс илүү байгаа нь зүй ёсны асуудал билээ. Гэвч улсын хэмжээнд орон сууцны нөхцөл сайтай хотын өрх нийт хотын өрхөд эзлэх хувь 36.6 хувь байгаа нь хөдөөгийн өрхийн улсын дунджаас 5.5 дахин өндөр байна. Гэхдээ том хотоос гадна аймгийн төвийн дотор Дорнод аймгийн төв нь орон сууцны байшин олонтой, орон сууцны нөхцөлөөр сайтай өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь улсын дундажтай ижил байна. Олон хүн төвлөрсөн хот суурин газарт амьдарч байгаа өрхийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, үүний дотор хатуу хог хаягдал, бохир ус зайлуулах, бие засах цэгийг олшруулах, зөв байршуулах асуудлыг зохицуулахад орон нутгийн удирдах байгууллагууд сайтар анхаарах шаардлагатай байгааг тооллогын дүнгээс харж болно.

#### ХҮСНЭГТ 2.18. ОРОН СУУЦНЫ НӨХЦЛИЙГ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>133 350</b>	<b>18.9</b>	<b>472 860</b>	<b>103 718</b>	<b>21.9</b>	<b>232 784</b>	<b>29 632</b>	<b>12.7</b>
Архангай	24 487	2 569	10.5	5 746	1 142	19.9	18 741	1 427	7.6
Баян-Өлгий	19 153	256	1.3	7 041	178	2.5	12 112	78	0.6
Баянхонгор	21 618	3 974	18.4	8 366	2 175	26.0	13 252	1 799	13.6
Булган	15 718	1 412	9.0	4 169	366	8.8	11 549	1 046	9.1
Говь-Алтай	14 476	3 060	21.1	4 817	1 058	22.0	9 659	2 002	20.7
Дорноговь	16 318	3 086	18.9	9 391	2 273	24.2	6 927	813	11.7
Дорнод	17 663	2 576	14.6	9 451	1 931	20.4	8 212	645	7.9
Дундговь	10 846	2 985	27.5	3 793	1 540	40.6	7 053	1 445	20.5
Завхан	18 515	3 979	21.5	4 815	1 401	29.1	13 700	2 578	18.8
Өвөрхангай	27 958	6 722	24.0	10 582	3 732	35.3	17 376	2 990	17.2
Өмнөговь	14 819	5 139	34.7	5 584	2 975	53.3	9 235	2 164	23.4
Сүхбаатар	13 860	2 236	16.1	4 173	1 152	27.6	9 687	1 084	11.2
Сэлэнгэ	26 666	1 797	6.7	13 235	780	5.9	13 431	1 017	7.6
Төв	24 389	3 750	15.4	3 704	968	26.1	20 685	2 782	13.4
Увс	18 588	4 542	24.4	7 016	2 520	35.9	11 572	2 022	17.5
Ховд	18 852	3 860	20.5	6 977	2 481	35.6	11 875	1 379	11.6
Хөвсгөл	32 878	5 470	16.6	11 417	2 927	25.6	21 461	2 543	11.8
Хэнтий	19 022	3 825	20.1	8 687	2 455	28.3	10 335	1 370	13.3
Дархан-Уул	23 869	4 189	17.5	19 727	3 897	19.8	4 142	292	7.0
Улаанбаатар	298 133	63 768	21.4	298 133	63 768	21.4	-	-	-
Орхон	24 032	3 645	15.2	23 216	3 554	15.3	816	91	11.2
Говьсүмбэр	3 784	510	13.5	2 820	445	15.8	964	65	6.7

Ахуйн нөхцөлийг хангасан өрх гэдэгт ямар өрхийг хамруулж байгаа талаар хэрэглэгчид тодорхой ойлгуулахын тулд дэлгэрэнгүй оруулав. Ундны усаа төвлөрсөн системээр хангадаг, эсвэл төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг шанд, цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг өрхийг, ундны усны баталгаат эх үүсвэртэй гэж үзсэн. Төвлөрсөн усан хангамж гэх ойлголтод ус олборлох, цэвэрлэх, дамжуулах, зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах системийг хамруулна. Төвлөрсөн бус усан хангамжид ус олборлож зөөвөрлөн түгээж, хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах системийг хамруулна. Онцгой болон энгийн хамгаалалтын бүс гэдэгт усны эх ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас

газрыг усан сан бүхий газраас 200 мөртөөс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүсийг, 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүсийг тогтоосон байна.

Цахилгааны төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгэвэр зэрэг цахилгаан гаргах үүсвэрээс үл хамааран цахилгаан гэрэлтэй өрхийг цахилгаанаар хангагдсан гэж үзсэн. Байшинд амьдардаг өрхийн хувьд сууц дотроо бие засах газартай, гэрт амьдардаг өрхийн хувьд бие засах газраа дангаараа ашигладаг, бохир ус зайлуулах төвлөрсөн болон төвлөрсөн бус системтэй, эсвэл зориулалтын цооногт асгадаг, хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, эсвэл тогтмол асгаад тодорхой хугацаанд зайлуулдаг өрхийг тухайн ахуйн нөхцөлийг хангасан өрх гэж үзэв. Дээрх нөхцөлөөс аль нэгийг нь хангаагүй боловч бусад 4 нөхцөлийг хангасан өрхийг ахуйн нөхцөлийг хангасан өрхөд хамруулж байгаа юм.

Ахуйн нөхцөлийг хангасан өрх улсын дунджаар 18.9 хувь байгаагийн дотор хотын өрхийн 21.9 хувь, хөдөөгийн өрхийн 12.7 хувь байна. Усны сав, ундарга нь онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоогүй булаг, шанд, хамгаалагдаагүй худаг, гол, мөрөнөөс усаа хэрэглэдэг, болон зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувьд ундны усны баталгаат эх үүсвэртэй тооцогдоогүй байгаа болохоор хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлийг хангасан өрхийн эзлэх хувь доогуур байхад нөлөөлөх талтай. Хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгийд 0.6 хувь байгаа нь улсын дунджаас 11 дахин доогуур байгаад энэ аймгийн төр захиргааны байгууллага анхаарах нь зүйтэй юм. Мөн дээрх үзүүлэлт Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Дорнод, Булган аймгуудад улсын дунджаас доогуур байна.

#### ХҮСНЭГТ 2.19. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙГ ХАГАС ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>209 468</b>	<b>29.7</b>	<b>472 860</b>	<b>156 722</b>	<b>33.1</b>	<b>232 784</b>	<b>52 746</b>	<b>22.7</b>
Архангай	24 487	6 347	25.9	5 746	2 904	50.5	18 741	3 443	18.4
Баян-Өлгий	19 153	2 046	10.7	7 041	915	13.0	12 112	1 131	9.3
Баянхонгор	21 618	5 156	23.9	8 366	3 600	43.0	13 252	1 556	11.7
Булган	15 718	5 154	32.8	4 169	1 817	43.6	11 549	3 337	28.9
Говь-Алтай	14 476	3 465	23.9	4 817	2 046	42.5	9 659	1 419	14.7
Дорноговь	16 318	4 876	29.9	9 391	2 920	31.1	6 927	1 956	28.2
Дорнод	17 663	5 856	33.2	9 451	3 393	35.9	8 212	2 463	30.0
Дундговь	10 846	1 902	17.5	3 793	602	15.9	7 053	1 300	18.4
Завхан	18 515	5 332	28.8	4 815	1 750	36.3	13 700	3 582	26.1
Өвөрхангай	27 958	5 884	21.0	10 582	3 220	30.4	17 376	2 664	15.3
Өмнөговь	14 819	2 927	19.8	5 584	840	15.0	9 235	2 087	22.6
Сүхбаатар	13 860	3 652	26.3	4 173	1 182	28.3	9 687	2 470	25.5
Сэлэнгэ	26 666	8 004	30.0	13 235	3 678	27.8	13 431	4 326	32.2
Төв	24 389	8 032	32.9	3 704	1 035	27.9	20 685	6 997	33.8
Увс	18 588	3 674	19.8	7 016	1 818	25.9	11 572	1 856	16.0
Ховд	18 852	4 121	21.9	6 977	1 893	27.1	11 875	2 228	18.8
Хөвсгөл	32 878	9 971	30.3	11 417	5 471	47.9	21 461	4 500	21.0
Хэнтий	19 022	5 912	31.1	8 687	2 635	30.3	10 335	3 277	31.7
Дархан-Уул	23 869	6 355	26.6	19 727	4 726	24.0	4 142	1 629	39.3
Улаанбаатар	298 133	101 877	34.2	298 133	101 877	34.2	-	-	-
Орхон	24 032	8 096	33.7	23 216	7 793	33.6	816	303	37.1
Говьсүмбэр	3 784	829	21.9	2 820	607	21.5	964	222	23.0

Орон сууцны ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь ерөнхийдөө жигдэвтэр байгаа нь орон сууцны нөхцөл сайн хангасан байдлаас онцлогтой байна. Орон сууцны нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 29.7 хувь байгаагийн дотор дунджаас дээш хувьтай аймаг, нийслэл 8, улсын дундажтай ойролцоо нэг аймаг, улсын дунджаас доогуур хувьтай 13 аймаг байна. Хотын өрхөөс орон сууцны нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 33.1 байгаагийн дотор улсын дунджаас дээш хувьтай 8 аймаг, нийслэл, ойролцоо нэг аймаг, доогуур хувьтай 13 аймаг байна. Эдгээрээс Баян-Өлгий аймгийн орон сууцны нөхцөлийг хагас хангасан өрхийн хувь нэлээд доогуур байна. Хөдөөгийн өрхөд орон сууцны нөхцөлийг хагас хангасан өрхийн эзлэх хувь улсын дунджаар 22.7 байгаагийн дотор үүнээс дээгүүр үзүүлэлтэй аймаг 11, доогуур үзүүлэлтэй аймаг 9, улсын дундажтай ойролцоо аймаг нэг байна.

**ХҮСНЭГТ 2.20. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙГ ДУТУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР 2010 ОН**

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>80 487</b>	<b>11.4</b>	<b>472 860</b>	<b>31 937</b>	<b>6.8</b>	<b>232 784</b>	<b>48 550</b>	<b>20.9</b>
Архангай	24 487	5 791	23.6	5 746	444	7.7	18 741	5 347	28.5
Баян-Өлгий	19 153	9 088	47.4	7 041	5 301	75.3	12 112	3 787	31.3
Баянхонгор	21 618	2 415	11.2	8 366	1 114	13.3	13 252	1 301	9.8
Булган	15 718	4 070	25.9	4 169	1 174	28.2	11 549	2 896	25.1
Говь-Алтай	14 476	1 153	8.0	4 817	508	10.5	9 659	645	6.7
Дорноговь	16 318	2 233	13.7	9 391	1 159	12.3	6 927	1 074	15.5
Дорнод	17 663	3 534	20.0	9 451	613	6.5	8 212	2 921	35.6
Дундговь	10 846	958	8.8	3 793	103	2.7	7 053	855	12.1
Завхан	18 515	2 638	14.2	4 815	881	18.3	13 700	1 757	12.8
Өвөрхангай	27 958	2 465	8.8	10 582	541	5.1	17 376	1 924	11.1
Өмнөговь	14 819	1 495	10.1	5 584	116	2.1	9 235	1 379	14.9
Сүхбаатар	13 860	1 811	13.1	4 173	234	5.6	9 687	1 577	16.3
Сэлэнгэ	26 666	9 656	36.2	13 235	4 939	37.3	13 431	4 717	35.1
Төв	24 389	4 787	19.6	3 704	204	5.5	20 685	4 583	22.2
Увс	18 588	1 773	9.5	7 016	485	6.9	11 572	1 288	11.1
Ховд	18 852	2 910	15.4	6 977	525	7.5	11 875	2 385	20.1
Хөвсгөл	32 878	7 967	24.2	11 417	1 106	9.7	21 461	6 861	32.0
Хэнтий	19 022	2 814	14.8	8 687	591	6.8	10 335	2 223	21.5
Дархан-Уул	23 869	1 973	8.3	19 727	1 246	6.3	4 142	727	17.6
Улаанбаатар	298 133	9 481	3.2	298 133	9 481	3.2	-	-	-
Орхон	24 032	769	3.2	23 216	577	2.5	816	192	23.5
Говьсүмбэр	3 784	706	18.7	2 820	595	21.1	964	111	11.5

Өрхийн орон сууцны ахуйн нөхцөлийг дутуу хангагдана гэдэгт сонгосон 5 нөхцөлөөс 2 нөхцөлийг хангасан өрхийг хамруулж байгаа юм. Орон сууцны нөхцөл дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь өндөр байх дутам тухайн аймаг, нийслэлийн өрх орон сууцны нөхцөл нь хангалттай биш гэсэн агуулгыг илэрхийлнэ. Нөгөө талаар, орон сууцны нөхцөлийг дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бага байх нь орон сууцны нөхцөл сайтай, эсвэл орон сууцны нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь өндөр байсан нөхцөлд тухайн аймаг, нийслэлийн хувьд эерэг үзүүлэлт болно. Харин орон сууцны нөхцөл сайтай, орон сууцны нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бага байсан тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн өрхийн орон сууцны нөхцөл хангалтгүй байгааг илэрхийлэх юм.

Орон сууцны нөхцөлийг дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 11.4 хувь байгаагийн дотор Баян-Өлгий, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай аймгийнх нэлээд өндөр байна. Дээрх аймгийн орон сууцны нөхцөл сайтай, орон сууцны нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусдаас өндөр байгаагүйг өмнөх хүснэгтээс харагдаж байснаас харахад эдгээр аймгийн өрхийн орон сууцны нөхцөл төдийлөн хангалттай биш байгааг илэрхийлнэ.

**ХҮСНЭГТ 2.21. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙГ МУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ,  
НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР 2010 ОН**

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>82 005</b>	<b>11.6</b>	<b>472 860</b>	<b>6 583</b>	<b>1.4</b>	<b>232 784</b>	<b>75 422</b>	<b>32.4</b>
Архангай	24 487	6 921	28.3	5 746	131	2.3	18 741	6 790	36.2
Баян-Өлгий	19 153	6 796	35.5	7 041	183	2.6	12 112	6 613	54.6
Баянхонгор	21 618	6 973	32.3	8 366	238	2.8	13 252	6 735	50.8
Булган	15 718	3 495	22.2	4 169	303	7.3	11 549	3 192	27.6
Говь-Алтай	14 476	4 874	33.7	4 817	278	5.8	9 659	4 596	47.6
Дорноговь	16 318	1 975	12.1	9 391	121	1.3	6 927	1 854	26.8
Дорнод	17 663	1 765	10.0	9 451	63	0.7	8 212	1 702	20.7
Дундговь	10 846	2 784	25.7	3 793	391	10.3	7 053	2 393	33.9
Завхан	18 515	4 290	23.2	4 815	16	0.3	13 700	4 274	31.2
Өвөрхангай	27 958	7 769	27.8	10 582	461	4.4	17 376	7 308	42.1
Өмнөговь	14 819	2 516	17.0	5 584	54	1.0	9 235	2 462	26.7
Сүхбаатар	13 860	3 865	27.9	4 173	312	7.5	9 687	3 553	36.7
Сэлэнгэ	26 666	2 964	11.1	13 235	963	7.3	13 431	2 001	14.9
Төв	24 389	4 130	16.9	3 704	17	0.5	20 685	4 113	19.9
Увс	18 588	5 169	27.8	7 016	379	5.4	11 572	4 790	41.4
Ховд	18 852	4 780	25.4	6 977	11	0.2	11 875	4 769	40.2
Хөвсгөл	32 878	5 829	17.7	11 417	270	2.4	21 461	5 559	25.9
Хэнтий	19 022	2 655	14.0	8 687	300	3.5	10 335	2 355	22.8
Дархан-Уул	23 869	445	1.9	19 727	184	0.9	4 142	261	6.3
Улаанбаатар	298 133	1 265	0.4	298 133	1 265	0.4	-	-	-
Орхон	24 032	455	1.9	23 216	423	1.8	816	32	3.9
Говьсүмбэр	3 784	290	7.7	2 820	220	7.8	964	70	7.3

Орон сууцны нөхцөлийг муу хангасан өрхөд 5 нөхцөлөөс зөвхөн нэг нөхцөлийг хангасан өрхийг хамруулж байгааг дээр тэмдэглэсэн. Нийслэл, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгийн орон сууцны нөхцөлийг муу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин улсын дунджаас нэлээд бага байгаа нь эдгээр аймаг, нийслэлийн өрх ахуйн нөхцөл сайтай, ахуйн нөхцөлийг хангасан байдал нь бусдаас нэлээд өндөр хувьтай байсныг өмнөх 2.17 болон 2.18 дугаар хүснэгтээс харж болно. Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий (Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, нийслэл орохгүйгээр)-ээс бусад аймгийн сууцны нөхцөлийг муу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин улсын дунджаас 2-3 дахин өндөр байгааг цаашид анхаарч ард иргэдийнхээ тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгай арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх шаардлага байгааг тооллогын дүн харуулж байна.


ХҮСНЭГТ 2.22. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙГ ОГТ ХАНГАДААГҮЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь
<b>БҮГД</b>	<b>705 644</b>	<b>11 739</b>	<b>1.7</b>	<b>472 860</b>	<b>857</b>	<b>0.2</b>	<b>232 784</b>	<b>10 882</b>	<b>4.7</b>
Архангай	24 487	1 280	5.2	5 746	54	0.9	18 741	1 226	6.5
Баян-Өлгий	19 153	505	2.6	7 041	15	0.2	12 112	490	4.0
Баянхонгор	21 618	1 035	4.8	8 366	32	0.4	13 252	1 003	7.6
Булган	15 718	422	2.7	4 169	18	0.4	11 549	404	3.5
Говь-Алтай	14 476	412	2.8	4 817	58	1.2	9 659	354	3.7
Дорноговь	16 318	575	3.5	9 391	9	0.1	6 927	566	8.2
Дорнод	17 663	306	1.7	9 451	5	0.1	8 212	301	3.7
Дундговь	10 846	370	3.4	3 793	72	1.9	7 053	298	4.2
Завхан	18 515	571	3.1	4 815	1	0.0	13 700	570	4.2
Өвөрхангай	27 958	1 232	4.4	10 582	31	0.3	17 376	1 201	6.9
Өмнөговь	14 819	362	2.4	5 584	7	0.1	9 235	355	3.8
Сүхбаатар	13 860	611	4.4	4 173	47	1.1	9 687	564	5.8
Сэлэнгэ	26 666	233	0.9	13 235	72	0.5	13 431	161	1.2
Төв	24 389	610	2.5	3 704	-	-	20 685	610	2.9
Увс	18 588	599	3.2	7 016	57	0.8	11 572	542	4.7
Ховд	18 852	660	3.5	6 977	4	0.1	11 875	656	5.5
Хөвсгөл	32 878	1 110	3.4	11 417	83	0.7	21 461	1 027	4.8
Хэнтий	19 022	554	2.9	8 687	61	0.7	10 335	493	4.8
Дархан-Уул	23 869	62	0.3	19 727	18	0.1	4 142	44	1.1
Улаанбаатар	298 133	156	0.1	298 133	156	0.1	-	-	-
Орхон	24 032	35	0.1	23 216	35	0.2	816	-	-
Говьсүмбэр	3 784	39	1.0	2 820	22	0.8	964	17	1.8

Орон сууцны ахуйн нөхцөлийг огт хангаагүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 1.7 хувь буюу 11.7 мянган өрх байна. Ялангуяа, хотын орон сууцны нөхцөлийг огт хангаагүй 857 өрх дотор нийслэлд 156 өрх байгаа нь хотын орон сууцны нөхцөлийг хангаагүй 5 өрхийн нэг нь болж байгаа нь анхаарал татаж байна. Төв суурин газарт амьдарч байгаа өрх орон сууцны нөхцөлийг хангаагүй байх нь зөвхөн тухайн өрхийн асуудал бус орон нутгийн тухайлбал баг, хорооны нийт ард иргэнд хамааралтай, орчны эрүүл ахуй, байгаль орчны бохирдол, хүн амын эрүүл мэндэд хамааралтай юм. Иймээс тухайн орон нутгийн захиргаа уг асуудалд зориуд анхаарч ажиллах шаардлагатай юм.

Өрхийн орон сууцны ахуйн нөхцөлийг хангасан байдлаар нэгтгэн харуулбал дараах байдалтай байна (Зураг 2.4).

ЗУРАГ 2.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ,  
2010 ОН





*Хүмүүнд төр эрхэм. Мөрд хүмүүн эрдэнэ*

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛ





### 3.1. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХ

Монголын ард түмний уламжлалт үндэсний сууц болох гэрт нийт өрхийн 45-аас илүү хувь нь амьдарч байгааг дээр тэмдэглэсэн.

ХҮСНЭГТ 3.1. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛ, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Ханын тоо							
			<5		5		6		7+	
	мян. өрх	хувь	мян. өрх	дүнд эзлэх хувь	мян. өрх	дүнд эзлэх хувь	мян. өрх	дүнд эзлэх хувь	мян. өрх	дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>322.8</b>	<b>100.0</b>	<b>82.0</b>	<b>25.4</b>	<b>181.7</b>	<b>56.3</b>	<b>50.8</b>	<b>15.7</b>	<b>8.3</b>	<b>2.6</b>
1-2	88.0	100.0	31.3	35.6	44.8	51.0	10.4	11.9	1.4	1.5
3-4	150.4	100.0	35.2	23.4	87.8	58.4	23.7	15.7	3.8	2.5
5-6	71.6	100.0	13.3	18.5	41.7	58.2	14.1	19.6	2.6	3.7
7+	12.8	100.0	2.2	17.5	7.4	57.9	2.6	20.5	0.5	4.0

Гэрт амьдардаг өрхийн 56.3 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаагаас үзэхэд таван ханатай гэр манай ард түмний түгээмэл сууц гэж үзэж байна. Гэрийн ханын тоогоор талбайн хэмжээг тооцож болох хэдий ч аймаг орон нутаг, үндэс, угсааны уламжлалт зан заншилтай холбоотойгоор ханын толгойн тоо, зууравчны хэмжээнээс хамаарч, гэрийн хэмжээ бүс нутгуудад өөр өөр байдгийг хэрэглэгчид, судлаачид зөв ойлгох нь зүйтэй. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр гэрийн ханын тоо нэмэгдэх нь зүй ёсны асуудал бөгөөд энэ зүй тогтлыг дээрх хүснэгтээс ажиглаж болно.

Гэрт амьдардаг өрхийн ханын тоо, ам бүлийн тоогоор ангилж үзэхэд 2010 онд 2000 оноос мэдэгдэхүйц том өөрчлөлт гараагүй байна. Энэ нь манай ард түмэн олон мянган жил гэрт амьдарсаар ирсэн түүхэн уламжлал, тухайлбал гэрийн зай талбай, ам бүлийн тооны хоорондох уялдаа холбоог нарийн тогтоож ирсэн нь цөөн жилийн дотор өөрчлөгдөхгүйг харуулж байна. Гэвч зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хүн амын амьжиргааны төвшний өөрчлөлт, шилжих хөдөлгөөн зэргээс хамааран гэрийн ханын тоог, ам бүлийн тоогоор ангилж үзэхэд зарим өөрчлөлт гарсан байна. Таваас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 10 жилийн өмнөхөөс 4.8 пунктээр нэмэгдсэн бол харин 6, түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 3.0 пунктээр буурсан байна. Долоо, түүнээс дээш ам бүлтэй 5-аас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин 2000 онд 11.5 байсан бол 2010 онд 6 пунктээр өсч, харин 6 ханатай гэрт амьдрагчдын хувь 2.1 пунктээр буурсан аж.


Гэрт амьдардаг өрхийн тоог гэрийн ханын тоо, ам бүлийн тоо, хот, хөдөөгөөр ангилахад бас ялгаатай тал байгааг хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 3.2. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛ, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Ханын тоо							
			<5		5		6		7 +	
	мян. өрх	хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
<b>ХОТ-БҮГД</b>	<b>156.6</b>	<b>100.0</b>	<b>42.0</b>	<b>26.8</b>	<b>95.2</b>	<b>60.8</b>	<b>16.1</b>	<b>10.3</b>	<b>3.3</b>	<b>2.1</b>
1-2	40.0	100.0	14.8	37.0	21.6	54.0	3.1	7.7	0.5	1.3
3-4	74.2	100.0	18.9	25.5	46.4	62.5	7.3	9.8	1.6	2.1
5-6	34.7	100.0	6.9	19.9	22.2	63.9	4.6	13.2	1.0	3.0
7+	7.7	100.0	1.4	18.4	5.0	64.9	1.1	14.1	0.2	2.6
<b>ХӨДӨӨ-БҮГД</b>	<b>166.1</b>	<b>100.0</b>	<b>40.0</b>	<b>24.1</b>	<b>86.4</b>	<b>52.1</b>	<b>34.6</b>	<b>20.9</b>	<b>4.9</b>	<b>3.0</b>
1-2	47.8	100.0	16.5	34.5	23.2	48.5	7.3	15.3	0.8	1.8
3-4	76.1	100.0	16.3	21.4	41.3	54.3	16.3	21.4	2.2	2.9
5-6	37.0	100.0	6.4	17.3	19.5	52.7	9.5	25.7	1.6	4.3
7+	5.1	100.0	0.8	16.3	2.4	47.5	1.5	30.1	0.3	6.1

Тав түүнээс цөөн ханатай гэрт амьдардаг хотын өрх бүх өрхийн 26.8 хувийг эзэлж байхад уг үзүүлэлт хөдөөд 2.7 пунктээр бага байна. Мөн түүнчлэн 5 ханатай гэрт хотын бүх өрхийн 60.8 хувь нь амьдарч байхад хөдөөд энэ үзүүлэлт хотоос 8.1 пунктээр бага, харин 6 болон 7 түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь хөдөөд хотоос өндөр байгаа нь хөдөөд том гэрт амьдардаг нь харагдаж байна.

ЗУРАГ 3.1. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТООГООР, ХУВИАР, 2010 ОН



Гэрт амьдардаг өрхийн ам бүлийн тоо, ханын тоогоор аймаг, нийслэлд ялгаатай байдгийг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 3.3. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Ханын тоо			
		<5	5	6	7+
БҮГД	100.0	25.4	56.3	15.7	2.6
Архангай	100.0	10.4	78.6	10.8	0.3
Баян-Өлгий	100.0	7.4	28.3	62.2	2.1
Баянхонгор	100.0	35.7	62.9	1.2	0.2
Булган	100.0	17.5	69.3	11.6	1.6
Говь-Алтай	100.0	16.3	61.9	21.6	0.2
Дорноговь	100.0	53.1	45.9	0.9	0.1
Дорнод	100.0	64.5	34.9	0.5	0.1
Дундговь	100.0	43.7	55.3	0.8	0.1
Завхан	100.0	4.3	29.4	61.8	4.5
Өвөрхангай	100.0	19.3	80.3	0.3	0.1
Өмнөговь	100.0	44.6	54.5	0.7	0.2
Сүхбаатар	100.0	66.1	33.5	0.3	0.2
Сэлэнгэ	100.0	16.9	59.9	17.0	6.2
Төв	100.0	27.4	67.1	4.2	1.3
Увс	100.0	0.5	6.2	63.9	29.4
Ховд	100.0	5.9	27.5	64.5	2.2
Хөвсгөл	100.0	7.0	53.2	38.0	1.9
Хэнтий	100.0	58.8	40.4	0.6	0.1
Дархан-Уул	100.0	18.6	61.7	15.0	4.7
Улаанбаатар	100.0	28.0	65.2	5.7	1.1
Орхон	100.0	14.3	65.3	18.1	2.3
Говьсүмбэр	100.0	43.1	54.6	1.7	0.6

Аймаг орон нутгийн онцлогоос хамаарч гэрийн ханын хэмжээ янз бүр байж болох боловч дээрх хүснэгтээс үзэхэд улсын дунджаар 25.4 хувь нь таваас цөөн ханатай гэрт амьдарч байхад Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Хэнтий аймгуудад улсын дунджаас 2 илүү дахин олон өрх амьдарч байгаа нь тухайн аймгуудын онцлог юм. Мөн 5 ханатай гэрт улсын хэмжээний гэрт амьдардаг бүх өрхийн 56.3 хувь нь амьдарч байгаа нь 5 ханатай гэр манай ард түмний түгээмэл сууц гэдгийг харуулж байгааг дээр тэмдэглэсэн. Гэвч энэ үзүүлэлт аймаг тус бүрд харилцан адилгүй байгааг хүснэгт 3.3-аас ажиглаж болно. Тухайлбал, Увс аймагт 5 ханатай гэрт бүх өрхийнх нь дөнгөж 6.2 хувь, Ховдод 27.5 хувь, Баян-Өлгийд 28.3 хувь, Завханд 29.4 хувь байгаа нь улсын дунджаас бараг 2 дахин цөөн юм. Гэтэл 6 ханатай гэрт амьдардаг бүх өрхийн эзлэх хувь Ховдод 64.5, Увсад 63.9, Баян-Өлгийд 62.2, Завханд 61.8 хувийг эзэлж байна. Дээрх байдлаас үзэхэд баруун аймгийн ард түмэн нэлээд том гэрт харин зүүн аймгийнхан арай цөөн ханатай гэрт амьдардаг нь харагдаж байна.

Дээрх байдал нь аймгуудын гэрт амьдардаг өрхийн тоог хот, хөдөөгөөр ангилахад бас ялгаатай тал ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 3.4. ГЭРТ АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХАНЫН  
ТОО, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Үүнээс: Ханын тоогоор			
		<5	5	6	7+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	26.9	60.7	10.3	2.1
Архангай	100.0	16.6	81.0	2.1	0.3
Баян-Өлгий	100.0	11.6	46.9	41.1	0.5
Баянхонгор	100.0	32.8	66.7	0.4	0.1
Булган	100.0	26.7	60.7	10.5	2.1
Говь-Алтай	100.0	13.9	66.3	19.6	0.2
Дорноговь	100.0	48.7	50.1	1.0	0.1
Дорнод	100.0	66.0	33.3	0.6	0.1
Дундговь	100.0	45.3	54.2	0.6	0.0
Завхан	100.0	7.0	35.6	55.6	1.7
Өвөрхангай	100.0	18.8	80.6	0.6	0.0
Өмнөговь	100.0	39.4	59.9	0.6	0.1
Сүхбаатар	100.0	56.8	42.5	0.2	0.4
Сэлэнгэ	100.0	26.9	62.1	8.8	2.3
Төв	100.0	34.4	64.4	1.1	0.1
Увс	100.0	0.9	6.9	59.0	33.2
Ховд	100.0	5.8	29.6	62.0	2.6
Хөвсгөл	100.0	9.3	68.4	21.4	0.9
Хэнтий	100.0	56.8	42.3	0.9	0.0
Дархан-Уул	100.0	20.2	62.5	14.1	3.2
Улаанбаатар	100.0	28.0	65.2	5.7	1.1
Орхон	100.0	14.6	66.3	17.2	1.9
Говьсүмбэр	100.0	39.8	57.9	1.6	0.7


Гэрт амьдардаг өрхийг гэрийн ханын тоо, хот, хөдөөгөөр ангилж үзэхэд нэлээд сонирхолтой дүр төрх ажиглагдаж байна. Нийт өрхийн дотор 5 хүртэл ханатай гэрт амьдардаг өрхийн хувийн жингээр Увс аймаг хамгийн бага байсныг дээр тэмдэглэсэн. Энэ аймгийн хотын өрхийн дотор 5 хүртэл ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин хотод 0.9 хувь байгаа бол хөдөөд 0.4 хувь байна. Ийм харьцаа Баян-Өлгийд 11.6:6.2 хувь, Завханд 7.0:3.6 хувь Хөвсгөлд 9.3:6.2 хувь байна. Мөн 6 ханатай гэрт амьдардаг хот, хөдөөгийн өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жингийн харьцаа Архангайд 2.1:12.1 хувь, Баян-Өлгийд 41.1:67.8 хувь, Хөвсгөлд 21.4:43.5 хувь байгаагаас үзэхэд хотын өрх хөдөөнийхөөс арай цөөн ханатай гэрт амьдардаг нь харагдаж байна. Энэ нь төв суурин газарт хашааны зай талбай, түлээ нүүрсний хэрэгцээ, хангамжаас хамаарсан зардалтай холбоотойгоор цөөн ханатай гэрт амьдрах сонирхол давамгайлж байж болох юм.

ХҮСНЭГТ 3.5. ГЭРТ АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010 ОН.

Аймаг, нийслэл	Бүгд	Ханын тоо			
		<5	5	6	7+
БҮГД	100.0	24.1	52.1	20.9	3.0
Архангай	100.0	9.4	78.2	12.1	0.3
Баян-Өлгий	100.0	6.2	23.3	67.8	2.6
Баянхонгор	100.0	37.2	61.0	1.6	0.2
Булган	100.0	16.4	70.4	11.7	1.5
Говь-Алтай	100.0	17.2	60.2	22.3	0.3
Дорноговь	100.0	56.1	43.1	0.7	0.1
Дорнод	100.0	63.9	35.5	0.5	0.1
Дундговь	100.0	43.0	55.9	0.9	0.2
Завхан	100.0	3.6	27.8	63.4	5.2
Өвөрхангай	100.0	19.5	80.1	0.2	0.2
Өмнөговь	100.0	47.3	51.7	0.8	0.2
Сүхбаатар	100.0	68.8	30.9	0.3	0.1
Сэлэнгэ	100.0	13.4	59.2	19.9	7.5
Төв	100.0	26.7	67.4	4.5	1.4
Увс	100.0	0.4	5.9	66.5	27.3
Ховд	100.0	5.9	26.6	65.5	2.0
Хөвсгөл	100.0	6.2	48.1	43.5	2.2
Хэнтий	100.0	60.0	39.3	0.5	0.2
Дархан-Уул	100.0	12.9	58.8	18.2	10.0
Орхон	100.0	9.9	51.6	30.6	7.9
Говьсүмбэр	100.0	55.5	42.5	2.1	0.0

Тооллогын дүнгээр долоо түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь аймаг, нийслэлд ялгаатай байгааг Зураг 3.2-д үзүүлэв. Долоо түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 2.56 байхад уг үзүүлэлт Увс аймагт 11.5 дахин их байна. Энэ нь тухайн аймгийн ард түмний зан заншилтай холбоотой боловч орон сууцны зай талбай, хүртээмж оршин суугчдын ахуйн нөхцөл талаас нь тусгайлан судалж үзвэл сонирхолтой байж болох талтайг судлаачид, нийгмийн ажилтнууд анхааралдаа авах нь зүйтэй.

ЗУРАГ 3.2. ДОЛОО ТҮҮНЭЭС ДЭЭШ ХАНАТАЙ ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН НИЙТ ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН



### 3.2. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ


Гэрт амьдардаг өрхийн цахилгааны хангамжийг 2010 онд өмнөх тооллогын үеэс нэлээд дэлгэрүүлэнгүй, тухайлбал цахилгааны эх үүсвэрээр нь ангилж авсан.

ХҮСНЭГТ 3.6. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ, ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>322.8</b>	<b>100.0</b>	<b>156.7</b>	<b>100.0</b>	<b>166.1</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	182.3	56.5	139.4	88.9	42.9	25.9
Дизель станц	12.5	3.9	5.5	3.5	7.0	4.2
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	96.5	29.9	5.7	3.6	90.8	54.7
Бага оврын цахилгаан үүсгүүр	10.2	3.2	1.6	1.0	8.7	5.2
Цахилгааны эх үүсвэргүй	21.2	6.5	4.6	3.0	16.6	10.0


Гэрт амьдардаг бүх өрхийн 93.5 хувь нь цахилгаанаар хангасан байгаа нь өмнөх тооллогын үеэс 2.2 дахин өссөн том дэвшил гарсан гэж үзэж болохоор байна. Үүний дотор хотын өрхийн 97.1 хувь, хөдөөгийн өрхийн 90.0 хувь нь цахилгаанаар хангасан нь өнгөрсөн тооллогын үеэс 3.6 дахин өссөн нь амжилт бөгөөд өнгөрсөн хугацаанд хөдөө орон нутгийг цахилгааны эх үүсвэртэй болох талаар төр засгаас хэрэгжүүлсэн хөтөлбөр, авсан арга хэжээний бодит үр дүн билээ.

ЗУРАГ 3.3. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, ХУВИАР, 2010 ОН



Улсын хэмжээнд цахилгааны хангамж нэлэнхүйдээ сайжирсны дотор Дархан-Уул, Говь-Алтай, Орхон аймаг, нийслэл хотоос бусад аймагт цахилгаанаар хангасан өрхийн тоо 2-оос дээш дахин өссөний дотор Баян-Өлгийд 5.1, Ахангайд 4.1, Дорнодод 3.3, Хөвсгөлд 3.1, Баянхонгорд 3.0 дахин өссөн нь бусдаас илүү байна.

ЗУРАГ 3.4. ГЭРТ АМЬДАРДАГ ЦАХИЛГААНААР ХАНГАСАН ӨРХИЙН НИЙТ  
ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, 2000, 2010 ОН



Өнгөрсөн 10 гаруй жилд цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар дорвитой өөрчлөлт хийж чадсан боловч цаашид анхаарах асуудал байна. Улсын хэмжээнд гэрт амьдардаг 21.2 мянган өрх цахилгаангүй байгаагийн дотор хотын 4.6 мянга, хөдөөгийн 16.6 мянган өрх байна. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж болон цахилгааны бага оврын тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага нэлээд байгааг харуулж байна.

Гэрт амьдардаг өрхийн цахилгааны хангамж нэлэнхүйдээ сайжирсан боловч аймаг, нийслэлд харилцан адилгүй байна.




ХҮСНЭГТ 3.7. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНААР ХАНГАСАН БАЙДАЛ, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд		Цахилгаантай өрх		Цахилгаангүй өрх	
	Өрхийн тоо	хувь	Өрхийн тоо	эзлэх хувь	Өрхийн тоо	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>100.0</b>	<b>301 619</b>	<b>93.4</b>	<b>21 217</b>	<b>6.6</b>
Архангай	18 062	100.0	15 990	88.5	2 072	11.5
Баян-Өлгий	978	100.0	803	82.1	175	17.9
Баянхонгор	18 695	100.0	17 248	92.3	1 447	7.7
Булган	8 473	100.0	7 760	91.6	713	8.4
Говь-Алтай	12 152	100.0	11 590	95.4	562	4.6
Дорноговь	7 514	100.0	6 648	88.5	866	11.5
Дорнод	5 949	100.0	5 299	89.1	650	10.9
Дундговь	8 974	100.0	8 420	93.8	554	6.2
Завхан	13 906	100.0	13 048	93.8	858	6.2
Өвөрхангай	23 055	100.0	21 463	93.1	1 592	6.9
Өмнөговь	11 973	100.0	11 156	93.2	817	6.8
Сүхбаатар	9 860	100.0	8 974	91.0	886	9.0
Сэлэнгэ	6 603	100.0	6 046	91.6	557	8.4
Төв	15 329	100.0	14 081	91.9	1 248	8.1
Увс	15 821	100.0	15 090	95.4	731	4.6
Ховд	13 908	100.0	12 785	91.9	1 123	8.1
Хөвсгөл	20 691	100.0	18 570	89.7	2 121	10.3
Хэнтий	11 810	100.0	10 677	90.4	1 133	9.6
Дархан-Уул	4 249	100.0	4 024	94.7	225	5.3
Улаанбаатар	87 537	100.0	84 857	96.9	2 680	3.1
Орхон	5 924	100.0	5 776	97.5	148	2.5
Говьсүмбэр	1 373	100.0	1 314	95.7	59	4.3

Гэрт амьдардаг цахилгааны эх үүсвэргүй өрхийн эзлэх хувийн жин Баян-Өлгий, Архангай, Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Хэнтий аймгууд бусдаас нэлээд өндөр байна. Цаашид цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэхдээ дээрх аймгуудыг тэргүүн ээлжинд анхаарах нь зүйтэй юм. Гэхдээ аймаг, нийслэлийг суурьшлаар нь ангилж үзвэл бас ялгаатай, анхаармаар асуудал байгаа нь харагдаж байна.

ЗУРАГ 3.5. ГЭРТ АМЬДАРДАГ ХОТЫН НИЙТ ӨРХӨД ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010 ОН



Гэрт амьдардаг хотын цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Сэлэнгэд 8.6, Баян-Өлгийд 6.8, Булганд 5.2, Архангайд 5.2, Хөвсгөлд 5.0 байгаа нь бусдаас өндөр юм. Гэрт амьдардаг өрхийн цахилгааны эх үүсвэрийг нэлээд амжилттай шийдвэрлэж буй орчин цагт төв суурин газарт амьдарч байгаа өрхийн цахилгааны эх үүсвэрийг үндсэнд нь шийдвэрлэх боломж байна гэж үзэж болно.

Гэрт амьдардаг өрхийн цахилгаан хангамжийг аймаг, нийслэлийн хэмжээгээр үзэхэд алгаатай тал бүр ч илүү ажиглагдана.

ХҮСНЭГТ 3.8. ГЭРТ АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ТОО,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНААР ХАНГАСАН БАЙДАЛ, 2010 ОН.

Аймаг, нийслэл	Өрхийн тоо		Цахилгаантай		Цахилгаангүй	
	Бүгд	Хувь	Өрхийн тоо	эзлэх Хувь	Өрхийн тоо	Хувь
<b>БҮГД</b>	<b>156 744</b>	<b>100.0</b>	<b>152 135</b>	<b>97.1</b>	<b>4 609</b>	<b>2.9</b>
Архангай	2 479	100.0	2 350	94.8	129	5.2
Баян-Өлгий	207	100.0	193	93.2	14	6.8
Баянхонгор	6 275	100.0	6 176	98.4	99	1.6
Булган	905	100.0	858	94.8	47	5.2
Говь-Алтай	3 288	100.0	3 202	97.4	86	2.6
Дорноговь	3 052	100.0	2 928	95.9	124	4.1
Дорнод	1 690	100.0	1 654	97.9	36	2.1
Дундговь	2 715	100.0	2 615	96.3	100	3.7
Завхан	2 803	100.0	2 777	99.1	26	0.9
Өвөрхангай	7 108	100.0	6 992	98.4	116	1.6
Өмнөговь	4 075	100.0	4 014	98.5	61	1.5
Сүхбаатар	2 196	100.0	2 109	96.0	87	4.0
Сэлэнгэ	1 690	100.0	1 545	91.4	145	8.6
Төв	1 509	100.0	1 492	98.9	17	1.1
Увс	5 486	100.0	5 372	97.9	114	2.1
Ховд	4 128	100.0	4 086	99.0	42	1.0
Хөвсгөл	5 151	100.0	4 895	95.0	256	5.0
Хэнтий	4 499	100.0	4 344	96.6	155	3.4
Дархан-Уул	3 328	100.0	3 209	96.4	119	3.6
Улаанбаатар	87 537	100.0	84 857	96.9	2 680	3.1
Орхон	5 542	100.0	5 418	97.8	124	2.2
Говьсүмбэр	1 081	100.0	1 049	97.0	32	3.0

Манай улсын хот суурин газрын гэрт амьдардаг өрхийн 90-ээс дээш хувь нь цахилгааны эх үүсвэрээр хангасан байгаа нь өнгөрсөн тооллогын үеэс ихээхэн ахицтай боловч гэрт амьдардаг цахилгаангүй өрхийн 58.1 хувь буюу 2.7 мянган өрх нийслэлд байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Аймгуудаас Сэлэнгэ, Баян-Өлгий аймгийн хот, тосгоны өрхийн цахилгааны хангамж бусдаас доогуур, цахилгааны эх үүсвэртэй болгох асуудлыг орон нутгийн төр захиргааны байгууллага анхаарах нь зүйтэй.

Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн цахилгааны хангамжийн байдлаас үзэхэд аймаг орон нутагт нэлээд ялгаатай байна. Гэрт амьдардаг хөдөөгийн 16.6 мянган өрх буюу бүх өрхийн 10.0 хувь нь цахилгааны эх үүсгэвэргүй байна. Хөдөө цахилгааны эх үүсвэргүй өрхийн эзлэх хувийн жин Баян-Өлгийд 20.9 хувь, Дорноговьд 16.6 хувь, Дорнодод 14.4 хувь байгаа нь бусдаас өндөр байна.

ХҮСНЭГТ 3.9. ГЭРТ АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖИЙН БАЙДАЛ, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд		Цахилгаантай		Цахилгаангүй	
	өрхийн тоо	хувь	өрхийн тоо	хувь	өрхийн тоо	хувь
БҮГД	166 092	100.0	149 484	90.0	16 608	10.0
Архангай	15 583	100.0	13 640	87.5	1 943	12.5
Баян-Өлгий	771	100.0	610	79.1	161	20.9
Баянхонгор	12 420	100.0	11 072	89.1	1 348	10.9
Булган	7 568	100.0	6 902	91.2	666	8.8
Говь-Алтай	8 864	100.0	8 388	94.6	476	5.4
Дорноговь	4 462	100.0	3 720	83.4	742	16.6
Дорнод	4 259	100.0	3 645	85.6	614	14.4
Дундговь	6 259	100.0	5 805	92.7	454	7.3
Завхан	11 103	100.0	10 271	92.5	832	7.5
Өвөрхангай	15 947	100.0	14 471	90.7	1 476	9.3
Өмнөговь	7 898	100.0	7 142	90.4	756	9.6
Сүхбаатар	7 664	100.0	6 865	89.6	799	10.4
Сэлэнгэ	4 913	100.0	4 501	91.6	412	8.4
Төв	13 820	100.0	12 589	91.1	1 231	8.9
Увс	10 335	100.0	9 718	94.0	617	6.0
Ховд	9 780	100.0	8 699	88.9	1 081	11.1
Хөвсгөл	15 540	100.0	13 675	88.0	1 865	12.0
Хэнтий	7 311	100.0	6 333	86.6	978	13.4
Дархан-Уул	921	100.0	815	88.5	106	11.5
Орхон	382	100.0	358	93.7	24	6.3
Говьсүмбэр	292	100.0	265	90.8	27	9.2

Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн цахилгааны хангамж өнгөрсөн тооллогын үеэс эрс сайжирсан аж. Тухайлбал, 2000 онд хөдөөгийн нийт өрхөд цахилгааны эх үүсвэргүй өрхийн эзлэх хувь улсын дунджаар 75.2 хувь байсны дотор Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Сэлэнгээс бусад аймагт 60-аас дээш хувь нь цахилгааны эх үүсвэргүй байсны дотор Баян-өлгийд 95.0 хувь, Дорнодод 85.7, Хөвсгөлд 81.8 хувь Баянхонгорт 81.7 хувь байсан нь бусдаас өндөр байжээ. Эдгээр үзүүлэлтийг хүснэгт 3.9-ийн холбогдох аймгийн үзүүлэлттэй зэрэгцүүлэхэд тэдгээр аймгийн гэрт амьдардаг өрхийн цахилгааны эх үүсвэрээр хэр зэрэг сайжирсныг харж болно.

### 3.3. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ

Гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөлийг тооллогоор тодорхойлохдоо бие засах газар, хатуу хог, хаягдал болон бохир ус зайлуулах хэлбэрийг нь өрх тус бүрээс асуусан. Эдгээр үзүүлэлтийг тус бүрээр нь нэгтгэвэл гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн ерөнхий дүр төрх харагдаж байна.

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг тодорхойлох нь төв суурин газрын орчны бохирдол, хүн амын эрүүл ахуйг сайжруулахад бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болно.

ХҮСНЭГТ 3.10. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Ахуйн нөхцөл	Бүгд	Хот	Хөдөө
<b>БИЕ ЗАСАХ ГАЗАРТАЙ ЭСЭХ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бусадтай хамтран ашигладаг	43.5	58.4	29.5
Бусадтай хамтран ашигладаггүй	30.7	36.9	24.8
Тогтсон газар байхгүй	25.8	4.7	45.7
<b>ХАТУУ ХОГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Үйлчилгээний байгууллагаар	43.0	80.1	7.9
Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	21.9	10.0	33.2
Тогтсон газар байхгүй	35.1	9.9	58.9
<b>БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Цооногт асгадаг	56.5	81.7	32.6
Задгай асгадаг	43.5	18.3	67.4

Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 25.8 хувийг эзэлж байгаа бол уг үзүүлэлт хотод 4.7 хувь буюу 7.4 мянга байгаа нь анхаарал татна. Хотод бие засах газраа олон өрх дундаа ашиглах, тогтсон газар байхгүй байх нь хөрсний бохирдол, хүн амд халдварт өвчин тархах магадлалыг нэмэгдүүлж байдгийг анхаарах нь чухал юм.

ХҮСНЭГТ 3.11. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо	Бохир ус зайлуулах хэлбэр		Хатуу хог хаягдлаа зайлуулах хэлбэр			Бие засах газартай эсэх		
		Цооногт асгадаг	Задгай асгадаг	Үйлчилгээний байгууллагаар	Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	Тогтсон газар байхгүй	Бусадтай хамтран ашигладаг	Бусадтай хамтран ашигладаггүй	Тогтсон газар байхгүй
БҮГД	100.0	56.5	43.5	43.0	21.9	35.1	43.5	30.7	25.8
Архангай	100.0	24.5	75.5	13.0	33.0	54.0	45.9	23.6	30.5
Баян-Өлгий	100.0	38.2	61.8	9.5	30.3	60.2	30.4	19.1	50.5
Баянхонгор	100.0	49.1	50.9	35.3	16.6	48.1	34.6	17.7	47.7
Булган	100.0	33.4	66.6	12.7	24.8	62.5	28.4	36.7	34.9
Говь-Алтай	100.0	51.0	49.0	24.7	28.4	46.9	40.1	13.8	46.1
Дорноговь	100.0	44.2	55.8	48.0	9.5	42.5	36.9	26.7	36.4
Дорнод	100.0	35.8	64.2	23.9	30.4	45.8	38.7	38.8	22.5
Дундговь	100.0	55.4	44.6	36.2	20.7	43.1	38.0	23.7	38.3
Завхан	100.0	58.3	41.7	20.5	42.1	37.4	40.9	23.4	35.7
Өвөрхангай	100.0	45.9	54.1	39.4	15.9	44.7	32.4	21.8	45.8
Өмнөговь	100.0	66.7	33.3	46.0	19.1	34.9	47.7	26.1	26.3
Сүхбаатар	100.0	34.0	66.0	22.6	22.5	55.0	31.9	16.0	52.1
Сэлэнгэ	100.0	39.3	60.7	6.2	42.7	51.1	30.0	49.4	20.5
Төв	100.0	34.3	65.7	15.9	34.2	49.9	28.9	34.4	36.7
Увс	100.0	43.6	56.4	5.0	53.8	41.2	33.5	28.4	38.1
Ховд	100.0	49.6	50.4	15.8	42.0	42.2	34.6	24.2	41.2
Хөвсгөл	100.0	51.9	48.1	23.4	27.8	48.8	43.3	40.8	15.9
Хэнтий	100.0	45.2	54.8	20.3	39.0	40.6	39.6	33.2	27.2
Дархан-Уул	100.0	65.8	34.2	56.6	18.2	25.1	41.9	51.8	6.3
Улаанбаатар	100.0	83.0	17.0	87.7	4.0	8.3	60.1	37.3	2.6
Орхон	100.0	85.4	14.6	80.2	2.9	16.9	43.4	51.1	5.6
Говьсүмбэр	100.0	48.4	51.6	44.6	16.5	38.8	47.3	25.7	26.9

Гэрт амьдардаг өрхийн 43.5 хувь нь буюу 140.5 мянган өрх, Дундговь, Дархан-Уул, Орхон аймаг, Нийслэл хотоос бусад аймгийн талаас илүү хувь нь бохир усаа задгай асгаж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Ялангуяа, хотын өрхийн 18.3 хувь нь бохир усаа задгай асгаж байгаагийн дотор Архангай, Булган, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр аймгийн хотын өрхийн 30-аас дээш хувь нь бохир усаа бас задгай асгаж буйг анхаарч аймгийн төр захиргааны байгууллагууд холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.


Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх хотын нийт өрхийн 9.9 хувь, байгаагийн дотор Булган, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн хотын өрхийн 30-аас дээш хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй байгаа нь хот, суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж, цаашид судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

Гэрт амьдардаг хотын өрхийн 4.7 хувь нь бие засах тогтсон цэг байхгүй байгаагийн дотор Говьсүмбэр аймагт 25.7 хувь, Сүхбаатар аймагт 22.6 хувь Дундговь аймагт 18.0 хувь байгаа нь бусдаас өндөр байна.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Гэрт амьдардаг өрхийн 55.7 хувь нь баталгаатай ундны эх үүсвэрээс ундны усаа авч байна. Харин 44.3 хувь нь баталгаагүй ундны ус хэрэглэж байгаагаас 36.1 хувь нь гол мөрөн, нуур, булаг шанд, 8.2 хувь нь зөөврийн ус хэрэглэж байна. Энэ нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө амьдардагтай холбоотой. Өрхийн ундны усны эх үүсвэрийн талаарх 2010 оны тооллогын асуулт өмнөх тооллогынхоос ялгаатай тул зэрэгцүүлэх боломжгүй юм.

ЗУРАГ 3.6. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010 ОН



Ундны усны эх үүсвэрээс хамгийн их хувийн жин эзэлж байгаа нь гол мөрөн, хамгаалагдаагүй нуур, цөөрөм эзэлж байгаа нь тус улсын онцлог юм. Энэ нь гэрт амьдардаг өрхийн дийлэнх нь хөдөө орон нутагт суурьшдаг, томоохон гол мөрөн цэнгэг устай нуур, цөөрмөөс ундныхаа усыг авч ашиглаж ирсэн уламжлал хэвээр байгааг харуулж байна.

Манай орны гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэр нь аймаг орон нутгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй юм.

ХҮСНЭГТ 3.12. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд*	Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг шанд	Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг шанд
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>11.2</b>	<b>21.3</b>	<b>1.2</b>	<b>21.9</b>	<b>8.2</b>	<b>36.1</b>
Архангай	100.0	0.4	15.7	1.8	8.1	5.2	68.8
Баян-Өлгий	100.0	0.0	7.7	1.4	0.0	4.3	86.6
Баянхонгор	100.0	0.3	18.7	2.1	4.1	25.6	49.2
Булган	100.0	0.5	28.8	3.5	2.6	10.3	54.3
Говь-Алтай	100.0	0.3	24.9	1.6	2.0	19.6	51.7
Дорноговь	100.0	16.7	19.0	0.4	10.9	15.8	37.2
Дорнод	100.0	17.7	23.7	1.1	5.9	8.4	43.3
Дундговь	100.0	19.3	29.4	0.2	0.9	2.9	47.2
Завхан	100.0	0.3	20.5	0.4	6.5	13.4	59.0
Өвөрхангай	100.0	0.4	26.2	1.5	21.8	4.4	45.6
Өмнөговь	100.0	31.9	24.8	1.8	0.8	3.1	37.7
Сүхбаатар	100.0	14.7	23.8	3.1	2.6	4.4	51.4
Сэлэнгэ	100.0	3.7	22.2	0.4	5.3	19.6	48.7
Төв	100.0	1.4	40.3	1.4	10.8	8.2	37.9
Увс	100.0	0.8	44.0	0.8	0.6	2.5	51.2
Ховд	100.0	3.0	31.7	1.2	0.1	2.6	61.4
Хөвсгөл	100.0	0.4	20.0	2.6	9.7	7.4	59.9
Хэнтий	100.0	10.8	38.8	2.2	4.6	7.3	36.4
Дархан-Уул	100.0	0.9	40.9	0.4	28.1	14.6	15.0
Улаанбаатар	100.0	27.4	7.9	0.3	57.5	5.4	1.5
Орхон	100.0	0.6	10.5	0.6	73.5	2.3	12.5
Говьсүмбэр	100.0	7.1	27.7	0.2	4.7	39.8	20.5

\* Тайлбар: Цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг өрх улсын хэмжээнд 31 байгаагийн дотор Дорноговьд 23, Өмнөговьд 3, Сэлэнгэд 3, Дундговь аймаг, Нийслэлд тус бүр 1 байна.

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлт тус бүрд хэрхэн хангасан талаар бид өмнө нь үзүүлсэн. Харин гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн 5 үзүүлэлтийг сонгож хамтатган үзвэл орон сууцны ахуйн нөхцөлийг хэр зэрэг хангасныг дараах байдлаар ангилж үзүүлэв. Үүнд:

- У-** Ундны усны баталгаат эх үүсвэртэй өрх. Эдгээрт ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн систем болон төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг шанд, цэвэршүүлэн савласан усаар хангасан өрх
- Ц** –Цахилгааны эх үүсвэрээр хангасан өрх. Цахилгааны эх үүсвэр нь төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан эх үүсвэрээр хангасан өрх
- Ж-** Бие засах газраа дангаараа ашигладаг өрх. Гэрт амьдардаг өрх бие засах газраа дангаараа ашигладаг өрх
- Б-** Бохир ус зайлуулах тодорхой цэгтэй өрх. Бохир усаа тодорхой цэгт (цооногт) асгадаг өрх
- Х-** Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, эсвэл тогтоосон цэгт зайлуулдаг өрх. Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар эсвэл зөвшөөрөгдсөн цэгт асгаад тогтмол зайлуулдаг өрх



Гэрт амьдардаг өрхийг ахуйн нөхцөлийг хангасан байдлыг 6 ангилж үзсэн (Ангиллыг 2 дугаар бүлгээс үзнэ үү).

Улсын хэмжээнд гэрт амьдардаг өрхийн 15.5 хувь нь ахуйн нөхцөл сайтай (дээр дурьдсан таван ахуйн нөхцөл бүгдээр нь хангасан) байгаагийн дотор хотод 24.2 хувь, хөдөөд 7.3 хувь нь байгаа нь нэлээд хангалтгүй үзүүлэлт юм.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлөөр хангасан өрхөд гүний болон уурхайн худгаас усаа авдаг, бие засах зориулалтын цэгтэй, цахилгаан гэрэлтэй өрх гэсэн 3 үзүүлэлтийг хамруулж байсан аж. Өмнөх тооллогод энэ 3 үзүүлэлтийг бүрэн хангасан өрх, бүх өрхийн 28.7 хувийг эзэлж байсны дотор хотод 66.3 хувь, хөдөөд 12.2 хувь байжээ. Үүнээс гадна гэрт амьдардаг өрхийн сууцны нөхцөлийг хангасан өрхийг дотор нь сайн хангасан, хангасан, дутуу хангасан гэх зэргээр ангилаагүй байжээ.

Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг тодорхойлох аргачлал нь зөрүүтэйн зэрэгцээгээр 2000 оны тооллогын дүнгээр ахуйн нөхцөлийг хангасан өрхийг тодорхойлохдоо 3 үзүүлэлтийг авснаас гадна ундны усны баталгаат эх үүсвэр зэрэг тодорхойлолтыг хэрэглэдэггүй байсантай уялдан гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг 2010 онтой зэрэгцүүлэх боломжгүй юм.

### ХҮСНЭГТ 3.13. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд*	Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг шанд	Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг шанд
<b>БҮГД</b>	100.0	11.2	21.3	1.2	21.9	8.2	36.1
Архангай	100.0	0.4	15.7	1.8	8.1	5.2	68.8
Баян-Өлгий	100.0	0.0	7.7	1.4	0.0	4.3	86.6
Баянхонгор	100.0	0.3	18.7	2.1	4.1	25.6	49.2
Булган	100.0	0.5	28.8	3.5	2.6	10.3	54.3
Говь-Алтай	100.0	0.3	24.9	1.6	2.0	19.6	51.7
Дорноговь	100.0	16.7	19.0	0.4	10.9	15.8	37.2
Дорнод	100.0	17.7	23.7	1.1	5.9	8.4	43.3
Дундговь	100.0	19.3	29.4	0.2	0.9	2.9	47.2
Завхан	100.0	0.3	20.5	0.4	6.5	13.4	59.0
Өвөрхангай	100.0	0.4	26.2	1.5	21.8	4.4	45.6
Өмнөговь	100.0	31.9	24.8	1.8	0.8	3.1	37.7
Сүхбаатар	100.0	14.7	23.8	3.1	2.6	4.4	51.4
Сэлэнгэ	100.0	3.7	22.2	0.4	5.3	19.6	48.7
Төв	100.0	1.4	40.3	1.4	10.8	8.2	37.9
Увс	100.0	0.8	44.0	0.8	0.6	2.5	51.2
Ховд	100.0	3.0	31.7	1.2	0.1	2.6	61.4
Хөвсгөл	100.0	0.4	20.0	2.6	9.7	7.4	59.9
Хэнтий	100.0	10.8	38.8	2.2	4.6	7.3	36.4
Дархан-Уул	100.0	0.9	40.9	0.4	28.1	14.6	15.0
Улаанбаатар	100.0	27.4	7.9	0.3	57.5	5.4	1.5
Орхон	100.0	0.6	10.5	0.6	73.5	2.3	12.5
Говьсүмбэр	100.0	7.1	27.7	0.2	4.7	39.8	20.5

\* Тайлбар: Цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг өрх улсын хэмжээнд 31 байгаагийн дотор Дорноговьд 23, Өмнөговьд 3, Сэлэнгэд 3, Дундговь аймаг, Нийслэлд тус бүр 1 байна.

Гэрт амьдардаг ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь том хот тухайлбал, Эрдэнэт, Дархан, Улаанбаатарт зүй ёсоор тэргүүлж дараа нь Дундовь, Өмнөговь,

Увс, Өвөрхангай аймгууд бусдаас өндөр хувьтай байхад Баян-Өлгий, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Говьсүмбэр аймгууд бусдаас доогуур байна. Хотын өрхийн хувьд Өвөрхангай, Ховд, Архангай, Өмнөговь, Увс, Дундговь аймгуудын ойролцоогоор 4-5 өрх дутмын нэг нь ахуйн нөхцөлийн сонгосон 5 нөхцөлийг бүрэн хангасан байхад хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлт хангалтгүй байгааг хүснэгт 3.13-аас харж болно. Баян-Өлгий аймгийн 100 өрх дутмын 2, Архангай, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймгийн 3-5 өрх ахуйн нөхцөлийг харуулсан 5 үзүүлэлтийг хангасан байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

### ХҮСНЭГТ 3.14. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	4 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангасан	Хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>108 635</b>	<b>33.7</b>	<b>156 744</b>	<b>79 652</b>	<b>50.8</b>	<b>166 092</b>	<b>28 983</b>	<b>17.4</b>
Архангай	18 062	2 478	13.7	2 479	1 051	42.4	15 583	1 427	9.2
Баян-Өлгий	978	127	13.0	207	50	24.2	771	77	10.0
Баянхонгор	18 695	3 905	20.9	6 275	2 107	33.6	12 420	1 798	14.5
Булган	8 473	1 343	15.9	905	304	33.6	7 568	1 039	13.7
Говь-Алтай	12 152	2 921	24.0	3 288	920	28.0	8 864	2 001	22.6
Дорноговь	7 514	2 120	28.2	3 052	1 462	47.9	4 462	658	14.7
Дорнод	5 949	1 368	23.0	1 690	729	43.1	4 259	639	15.0
Дундговь	8 974	2 930	32.6	2 715	1 486	54.7	6 259	1 444	23.1
Завхан	13 906	3 838	27.6	2 803	1 261	45.0	11 103	2 577	23.2
Өвөрхангай	23 055	6 605	28.6	7 108	3 619	50.9	15 947	2 986	18.7
Өмнөговь	11 973	4 975	41.6	4 075	2 839	69.7	7 898	2 136	27.0
Сүхбаатар	9 860	2 070	21.0	2 196	1 022	46.5	7 664	1 048	13.7
Сэлэнгэ	6 603	1 275	19.3	1 690	438	25.9	4 913	837	17.0
Төв	15 329	3 440	22.4	1 509	747	49.5	13 820	2 693	19.5
Увс	15 821	4 436	28.0	5 486	2 415	44.0	10 335	2 021	19.6
Ховд	13 908	3 729	26.8	4 128	2 353	57.0	9 780	1 376	14.1
Хөвсгөл	20 691	5 402	26.1	5 151	2 860	55.5	15 540	2 542	16.4
Хэнтий	11 810	3 358	28.4	4 499	1 996	44.4	7 311	1 362	18.6
Дархан-Уул	4 249	1 634	38.5	3 328	1 447	43.5	921	187	20.3
Улаанбаатар	87 537	47 900	54.7	87 537	47 900	54.7	-	-	-
Орхон	5 924	2 475	41.8	5 542	2 395	43.2	382	80	20.9
Говьсүмбэр	1 373	306	22.3	1 081	251	23.2	292	55	18.8

Гэрт амьдардаг өрхийн ахуйн 5 нөхцөлөөс аль нэгийг нь хангаагүй дөрвөн нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 33.7 хувь байгаагийн дотор хотын өрхүүд 50.8 хувь, хөдөөгийн өрхүүд 17.4 хувь байна. Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн 4 нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Дундговь аймагт бусдаас өндөр байхад Баян-Өлгий, Архангай, Булган, Сэлэнгэ аймгууд доогуур буюу 5-8 өрх дутмын нэг нь 4 нөхцөлийг хангахгүй байгаа юм. Гэрт амьдардаг хотын өрхийн ахуйн нөхцөлийн 5 үзүүлэлтээс 4-ийг нь хангасан өрх нийт өрхөд эзлэх хувь хөдөөнийхөөс 2.9 дахин өндөр байгаа нь хотын өрх ахуйн нөхцөлөөр арай илүү хангасныг харуулж байна. Хотын өрхийн дотор Өмнөговь, Дундговь, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Дорноговь, Төв, Увс, Орхон аймгууд бусдаас өндөр байгаа бол Баян-Өлгий, Сэлэнгэ, Говь-Алтай, Баянхонгор, Булган аймгууд бусдаас доогуур байгаа юм. Хөдөөгийн өрхийн дотор Дундговь, Өмнөговь, Завхан, Говь-Алтай, Дархан-Уул, Орхон аймгуудын 5 өрх дутмын нэг нь ахуйн нөхцөлийг 4 үзүүлэлтээр хангасан байхад бусад аймгууд төдийлөн хангалттай биш байна.

ХҮСНЭГТ 3.15. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦЛӨӨР ХАГАС ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН.

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	3 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангасан	Хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>50 470</b>	<b>15.6</b>	<b>156 744</b>	<b>27 127</b>	<b>17.3</b>	<b>166 092</b>	<b>23 343</b>	<b>14.1</b>
Архангай	18 062	2 439	13.5	2 479	492	19.8	15 583	1 947	12.5
Баян-Өлгий	978	202	20.7	207	113	54.6	771	89	11.5
Баянхонгор	18 695	4 254	22.8	6 275	3 348	53.4	12 420	906	7.3
Булган	8 473	1 209	14.3	905	211	23.3	7 568	998	13.2
Говь-Алтай	12 152	2 600	21.4	3 288	1 798	54.7	8 864	802	9.0
Дорноговь	7 514	1 333	17.7	3 052	675	22.1	4 462	658	14.7
Дорнод	5 949	1 495	25.1	1 690	534	31.6	4 259	961	22.6
Дундговь	8 974	792	8.8	2 715	114	4.2	6 259	678	10.8
Завхан	13 906	3 000	21.6	2 803	1 122	40.0	11 103	1 878	16.9
Өвөрхангай	23 055	2 246	9.7	7 108	732	10.3	15 947	1 514	9.5
Өмнөговь	11 973	1 343	11.2	4 075	169	4.1	7 898	1 174	14.9
Сүхбаатар	9 860	1 167	11.8	2 196	95	4.3	7 664	1 072	14.0
Сэлэнгэ	6 603	1 602	24.3	1 690	469	27.8	4 913	1 133	23.1
Төв	15 329	2 513	16.4	1 509	209	13.9	13 820	2 304	16.7
Увс	15 821	2 250	14.2	5 486	1 103	20.1	10 335	1 147	11.1
Ховд	13 908	2 120	15.2	4 128	651	15.8	9 780	1 469	15.0
Хөвсгөл	20 691	3 428	16.6	5 151	563	10.9	15 540	2 865	18.4
Хэнтий	11 810	2 295	19.4	4 499	967	21.5	7 311	1 328	18.2
Дархан-Уул	4 249	855	20.1	3 328	638	19.2	921	217	23.6
Улаанбаатар	87 537	12 407	14.2	87 537	12 407	14.2	-	-	-
Орхон	5 924	472	8.0	5 542	365	6.6	382	107	28.0
Говьсүмбэр	1 373	448	32.6	1 081	352	32.6	292	96	32.9

Гэрт амьдардаг өрхийн ахуйн 5 нөхцөлөөс 3-ыг хангасан өрхийг ахуйн нөхцөлийг хагас хангасан гэж үзэв. Ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 15.6, үүний дотор хотынх 17.3, хөдөөнийх 14.1 байна. Өмнөх тооллогын дүнгээр гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдлыг 3 нөхцөлөөр тодорхойлж байсныг дээр тэмдэглэсэн. 2000 онд сонгосон 3 нөхцөлөөс хоёрыг нь хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь 24.7 байсан аж. Өмнөх тооллогын эл үзүүлэлтийг 2010 оныхтой шууд зэрэгцүүлэх боломжгүй ч ерөнхийдөө ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеэс нэлээд буурсан нь ахуйн нөхцөл, сайтай, болон ахуйн нөхцөлийг хангасан өрхийг тусад нь тодорхойлж байгаатай холбоотой.

Гэрт амьдардаг өрхөөс ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь аймаг нийслэлд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Говьсүмбэр аймагт хамгийн өндөр 32.6 хувь байхад энэ үзүүлэлт Орхон аймагт 8.0, Дундговь аймагт 8.8 хувь буюу улсын дунджаас 1,8 дахин доогуур байна. Энэ нь Орхон, Дундговь аймагт гэрт амьдардаг өрхүүдийн ахуйн нөхцөл сайтай, ахуйн нөхцөлийг хангасан өрхийн эзлэх хувь бусад аймгаас өндөр байсан нь нөлөөлж байгаа юм.

ХҮСНЭГТ 3.16. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛӨӨР ДУТУУ ХАНГАСАН  
ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	2 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангасан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангасан	Хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>33 445</b>	<b>10.4</b>	<b>156 744</b>	<b>6 681</b>	<b>4.3</b>	<b>166 092</b>	<b>26 764</b>	<b>16.1</b>
Архангай	18 062	4 080	22.6	2 479	140	5.6	15 583	3 940	25.3
Баян-Өлгий	978	123	12.6	207	21	10.1	771	102	13.2
Баянхонгор	18 695	1 300	7.0	6 275	164	2.6	12 420	1 136	9.1
Булган	8 473	2 026	23.9	905	135	14.9	7 568	1 891	25.0
Говь-Алтай	12 152	594	4.9	3 288	101	3.1	8 864	493	5.6
Дорноговь	7 514	839	11.2	3 052	260	8.5	4 462	579	13.0
Дорнод	5 949	1 232	20.7	1 690	112	6.6	4 259	1 120	26.3
Дундговь	8 974	793	8.8	2 715	81	3.0	6 259	712	11.4
Завхан	13 906	956	6.9	2 803	52	1.9	11 103	904	8.1
Өвөрхангай	23 055	1 912	8.3	7 108	222	3.1	15 947	1 690	10.6
Өмнөговь	11 973	1 197	10.0	4 075	76	1.9	7 898	1 121	14.2
Сүхбаатар	9 860	1 267	12.8	2 196	177	8.1	7 664	1 090	14.2
Сэлэнгэ	6 603	1 641	24.9	1 690	361	21.4	4 913	1 280	26.1
Төв	15 329	3 071	20.0	1 509	38	2.5	13 820	3 033	21.9
Увс	15 821	1 185	7.5	5 486	390	7.1	10 335	795	7.7
Ховд	13 908	1 446	10.4	4 128	71	1.7	9 780	1 375	14.1
Хөвсгөл	20 691	3 958	19.1	5 151	298	5.8	15 540	3 660	23.6
Хэнтий	11 810	1 820	15.4	4 499	353	7.8	7 311	1 467	20.1
Дархан-Уул	4 249	489	11.5	3 328	270	8.1	921	219	23.8
Улаанбаатар	87 537	2 920	3.3	87 537	2 920	3.3	-	-	-
Орхон	5 924	359	6.1	5 542	248	4.5	382	111	29.1
Говьсүмбэр	1 373	237	17.3	1 081	191	17.7	292	46	15.8

Гэрт амьдардаг өрхөөс ахуйн нөхцөлийн 5 үзүүлэлтээс зөвхөн хоёрыг нь хангасан өрхийг ахуйн нөхцөлийг дутуу хангасан гэж үзсэн билээ. Сонгосон 5 нөхцөлөөс зөвхөн 2-ыг хангаж байгаа нь сайн үзүүлэлт биш юм. Гэсэн ч гэрт амьдардаг өрхөөс ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь аймаг, нийслэлд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, ахуйн нөхцөлөөр дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Сэлэнгэ аймагт хамгийн өндөр 24.9, Булганд 23.9, Архангайд 22.6, Дорнодод 20.7, Төвд 20.0 хувь байгаа нь бусдаас өндөр. Дээрх аймгуудын гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл сайтай, ахуйн нөхцөл хангасан, хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусдаас өндөр байгаагүй нь эдгээр аймгуудын гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн байдал учир дутагдалтай байгааг харуулж байна. Дээрх аймгуудын гэрт амьдардаг хот, хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн хувь бусдаас өндөр байгааг хүснэгт 3.16-гаас харж болно. Эдгээрээс гадна Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, аймгийн гэрт амьдардаг хөдөөгийн ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусдаас нэлээд өндөр байгаа юм. Гэтэл эдгээр аймгуудын хөдөөгийн өрхөөс ахуйн нөхцөл сайтай, ахуйн нөхцөлийг хангасан, хагас хангасан өрхийн эзлэх хувь бусад аймаг, нийслэлээс өндөр бишээс үзэхэд эдгээр аймгийн хөдөөгийн гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл тааламжгүй байгаа нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 3.17. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦЛИЙГ МУУ ХАНГАСАН  
ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Нэг нөхцөл хангасан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангасан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангасан	Хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>69 310</b>	<b>21.5</b>	<b>156 744</b>	<b>4 682</b>	<b>3.0</b>	<b>166 092</b>	<b>64 628</b>	<b>38.9</b>
Архангай	18 062	6 680	37.0	2 479	127	5.1	15 583	6 553	42.1
Баян-Өлгий	978	377	38.5	207	11	5.3	771	366	47.5
Баянхонгор	18 695	6 956	37.2	6 275	237	3.8	12 420	6 719	54.1
Булган	8 473	2 722	32.1	905	87	9.6	7 568	2 635	34.8
Говь-Алтай	12 152	4 850	39.9	3 288	275	8.4	8 864	4 575	51.6
Дорноговь	7 514	1 896	25.2	3 052	112	3.7	4 462	1 784	40.0
Дорнод	5 949	1 137	19.1	1 690	25	1.5	4 259	1 112	26.1
Дундговь	8 974	2 758	30.7	2 715	388	14.3	6 259	2 370	37.9
Завхан	13 906	4 256	30.6	2 803	12	0.4	11 103	4 244	38.2
Өвөрхангай	23 055	7 731	33.5	7 108	457	6.4	15 947	7 274	45.6
Өмнөговь	11 973	2 419	20.2	4 075	52	1.3	7 898	2 367	30.0
Сүхбаатар	9 860	3 835	38.9	2 196	311	14.2	7 664	3 524	46.0
Сэлэнгэ	6 603	1 355	20.5	1 690	225	13.3	4 913	1 130	23.0
Төв	15 329	3 848	25.1	1 509	7	0.5	13 820	3 841	27.8
Увс	15 821	5 131	32.4	5 486	374	6.8	10 335	4 757	46.0
Ховд	13 908	4 490	32.3	4 128	7	0.2	9 780	4 483	45.8
Хөвсгөл	20 691	4 787	23.1	5 151	219	4.3	15 540	4 568	29.4
Хэнтий	11 810	2 351	19.9	4 499	273	6.1	7 311	2 078	28.4
Дархан-Уул	4 249	255	6.0	3 328	88	2.6	921	167	18.1
Улаанбаатар	87 537	926	1.1	87 537	926	1.1	-	-	-
Орхон	5 924	290	4.9	5 542	263	4.7	382	27	7.1
Говьсүмбэр	1 373	260	18.9	1 081	206	19.1	292	54	18.5


Гэрт амьдардаг өрхөөс ахуйн сонгосон 5 нөхцөлөөс зөвхөн нэг нөхцөлийг хангасан өрхийг ахуйн нөхцөл муу хангасан гэж үзэв. Гэрт амьдардаг нийт өрхөд ахуйн нэг нөхцөл хангасан өрхийн эзлэх хувь Дархан-Уул, Орхон аймаг, нийслэлээс бусад бүх аймаг 19-өөс дээш хувьтай байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм. Ялангуяа, Сүхбаатар, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Увс, Ховд (Дархан-Уул, Орхон аймаг, нийслэл) аймгаас бусад бүх аймгийн 100 өрхөөс 3-4 өрх ахуйн нөхцөлийн зөвхөн нэг нөхцөлийг хангасан байна. Энэ үзүүлэлт хотуудад нэлээд бага хувийн жин эзэлж байгаа нь гэрт амьдардаг хотын өрхийн дотор ахуйн нөхцөлийг хангасан, хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин өндөр байсантай холбоотой. Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөл нэлээд доогуур байгаа нь хүснэгт 3.17 -гоос харагдаж байна. Ялангуяа, Баянхонгор, Увс, Ховд, Сүхбаатар, Өвөрхангай, Баян-Өлгий, Архангай аймгуудын хөдөөгийн гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл бусдаас доогуур байгаад аймгийн төр захиргааны байгууллага анхаарч ажиллах нь зүйтэй.

ХҮСНЭГТ 3.18. ГЭРТ АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦЛИЙГ ОГТ ХАНГААГҮЙ  
ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Ахуйн нөхцөл хангаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангаагүй	Хувь
<b>БҮГД</b>	<b>322 836</b>	<b>10 944</b>	<b>3.4</b>	<b>156 744</b>	<b>747</b>	<b>0.5</b>	<b>166 092</b>	<b>10 197</b>	<b>6.1</b>
Архангай	18 062	1 262	7.0	2 479	51	2.1	15 583	1 211	7.8
Баян-Өлгий	978	128	13.1	207	3	1.4	771	125	16.2
Баянхонгор	18 695	1 035	5.5	6 275	32	0.5	12 420	1 003	8.1
Булган	8 473	352	4.2	905	14	1.5	7 568	338	4.5
Говь-Алтай	12 152	410	3.4	3 288	57	1.7	8 864	353	4.0
Дорноговь	7 514	570	7.6	3 052	9	0.3	4 462	561	12.6
Дорнод	5 949	260	4.4	1 690	2	0.1	4 259	258	6.1
Дундговь	8 974	370	4.1	2 715	72	2.7	6 259	298	4.8
Завхан	13 906	566	4.1	2 803	1	0.0	11 103	565	5.1
Өвөрхангай	23 055	1 231	5.3	7 108	30	0.4	15 947	1 201	7.5
Өмнөговь	11 973	358	3.0	4 075	7	0.2	7 898	351	4.4
Сүхбаатар	9 860	610	6.2	2 196	47	2.1	7 664	563	7.3
Сэлэнгэ	6 603	192	2.9	1 690	51	3.0	4 913	141	2.9
Төв	15 329	602	3.9	1 509	0	0.0	13 820	602	4.4
Увс	15 821	598	3.8	5 486	57	1.0	10 335	541	5.2
Ховд	13 908	635	4.6	4 128	4	0.1	9 780	631	6.5
Хөвсгөл	20 691	1 010	4.9	5 151	72	1.4	15 540	938	6.0
Хэнтий	11 810	528	4.5	4 499	60	1.3	7 311	468	6.4
Дархан-Уул	4 249	44	1.0	3 328	12	0.4	921	32	3.5
Улаанбаатар	87 537	118	0.1	87 537	118	0.1	-	-	-
Орхон	5 924	26	0.4	5 542	26	0.5	382	-	-
Говьсүмбэр	1 373	39	2.8	1 081	22	2.0	292	17	5.8

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдлыг нийтэд нь авч үзвэл нийт өрхөд ахуйн сонгосон 5 нөхцөлийг бүгдийг хангасан өрх 15.5 хувь байхад огт хангаагүй өрх 3.4 хувь байгаа юм. Гэрт амьдардаг 100 өрхөөс зургаа нь ахуйн нөхцөлийг хагас хангасан, 5 өрхийн нэг нь муу хангасан байгаа нь анхаарах асуудал. Гэрт амьдардаг хотын өрх ахуйн нөхцөлийг хөдөөгийнхөөс арай илүү хангасан байгаа нь дараах 2 зургаас харагдаж байна. Гэхдээ хотын өрхийн 3.5 хувь нь буюу 5.4 мянган өрх ахуйн нөхцөл муу эсвэл огт хангаагүй байгаа нь төв суурин газарт оршин суугаа ард иргэдийн эрүүл ахуй, орчны бохирдолд сөргөөр нөлөөлж байгаа нь тодорхой билээ. Иймээс эхний ээлжинд хот суурин газарт амьдарч байгаа гэр хорооллын өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ авах болсныг тооллогын дүн харуулж байна.

ЗУРАГ 3.7. ГЭРТ АМЬДАРДАГ ХОТ, ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛӨӨР ХАНГАСАН БАЙДАЛ, ХУВИАР, 2010 ОН



Хөдөөгийн гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл хотынхоос нэлээд доогуур байгаа нь зарим талаар манай орны онцлог гэж үзэж болох боловч цаашдаа ахуйн нөхцөл нь огт хангаагүй, муу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жинг бууруулах талаар тусгайлан бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ





## 4.1. СУУЦНЫ БАГТААМЖ

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, өрөөний тоог Монгол Улсын хүн ам, орон сууцны 1969 оны тооллогоос хойших бүх тооллогын асуулгад оруулсан нь байшинд амьдардаг ард түмний сууцны зай талбайн өөрчлөлт улмаар оршин суугчдын эрүүл ахуйн шаардлагыг хэр зэрэг хангасныг аймаг, бүс нутгийг жиших, гадаад орнуудын адил төрлийн үзүүлэлттэй зэрэгцүүлж, бодлого төлөвлөлтөд ашиглах зорилго агуулдаг.

ХҮСНЭГТ 4.1. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2010 ОН


Ам бүлийн тоо	Бүгд		Сууцны талбай (квадрат метр)					
			20 хүртэл		21-40		40-өөс дээш	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>378.2</b>	<b>100.0</b>	<b>50.4</b>	<b>13.3</b>	<b>151.3</b>	<b>40.0</b>	<b>176.5</b>	<b>46.7</b>
1-2	95.0	100.0	19.1	20.1	39.8	41.8	36.2	38.1
3-4	180.6	100.0	22.6	12.5	72.6	40.2	85.3	47.3
5-6	82.8	100.0	7.2	8.7	31.4	37.9	44.2	53.4
7+	19.8	100.0	1.5	7.5	7.4	37.6	10.9	54.9

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үед байшинд амьдардаг нийт өрхийн 54.9 хувь нь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байсан бол эл үзүүлэлт 2010 онд 40 хувь болж өмнөх тооллогын үеэс 14.9 пунктээр буурчээ. Гэтэл 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд суудаг өрхийн хувь 46.7 хувь болж, 2.9 дахин өссөн нь 10 жилийн өмнөхтэй зэрэгцүүлэхэд орон сууцны багтаамж сайжирсан гэж үзэж болно. Үүнийг нотлох үзүүлэлт бол 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 54.9 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байранд амьдарч байгаа явдал юм. Дөчөөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа өрхийн нийт өрхөд эзлэх хувийг аймаг, нийслэлээр өмнөх тооллогын үетэй зэрэгцүүлэхэд орон нутагт сууцны багтаамж хэр зэрэг сайжирсаныг харуулна.

Өмнөх тооллогын үетэй зэрэгцүүлэхэд байшинд амьдардаг нийт өрхөд 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдардаг өрхийн тоо Сүхбаатарт 4.8, Баянхонгорт 3.8, Улаанбаатарт 3.4, Орхонд 3.3 дахин нэмэгдсэн нь бусдаас илүү их өсчээ (Зураг 4.1).

Байшинд амьдардаг хотын нийт өрхөд 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин улсын дунджаар 2000 онд 15.5 хувийг эзэлж байсан бол 2010 онд 46.7 хувь болж 3 дахин өсчээ. Уг үзүүлэлт хөдөөд 2.4 дахин өссөн аж. Нэг сонирхолтой үзүүлэлт нь байшинд амьдардаг нийт өрхөд 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 2010 онд хот, хөдөөд ижилхэн 46,7 хувь байгаа хэдийг Баян-Өлгий, Хэнтий, Орхон аймгаас бусад аймагт онцын их ялгаагүй юм (Хавсралт 4.1).

ЗУРАГ 4.1. БАЙШИНД АМЬДАРДАГ НИЙТ ӨРХӨД 40-ӨӨС ДЭЭШ КВАДРАТ МЕТР ТАЛБАЙТАЙ СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010 ОН



Өрөөний болон өрхийн ам бүлийн тоог харьцуулж үзэхэд сууцны багтаамж нэмэгдсэн нь илүү тодорхой харагдана.

ХҮСНЭГТ 4.2. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>33.6</b>	<b>39.5</b>	<b>18.9</b>	<b>5.5</b>	<b>2.1</b>	<b>0.3</b>	<b>0.2</b>
1-2	100.0	43.5	37.0	14.5	3.5	1.2	0.2	0.2
3-4	100.0	32.8	40.8	18.9	5.2	1.9	0.2	0.2
5-6	100.0	26.5	40.0	22.4	7.5	3.0	0.4	0.2
7+	100.0	23.5	38.4	24.9	8.5	3.9	0.5	0.2

Тооллогоор байшинд амьдардаг нийт өрхөд 1-2 өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үед 80.8 хувь байсан бол 2010 онд 73.1 хувь болж 7.7 пунктээр буурсан хэдий ч тус улсын байшинд амьдардаг өрхийн түгээмэл сууц нь 1-2 өрөө болох нь харагдаж байна. Энэ үзүүлэлтийг аймаг, нийслэлээр ангилж үзэхэд дараах байдалтай байна.

**ХҮСНЭГТ 4.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>33.6</b>	<b>39.5</b>	<b>18.9</b>	<b>5.5</b>	<b>2.1</b>	<b>0.3</b>	<b>0.2</b>
Архангай	100.0	31.6	43.7	18.0	5.0	1.4	0.1	0.1
Баян-Өлгий	100.0	20.7	25.8	23.6	19.1	9.1	1.5	0.3
Баянхонгор	100.0	24.7	51.0	18.7	3.5	1.8	0.1	0.2
Булган	100.0	56.8	31.7	8.8	1.9	0.6	0.1	0.1
Говь-Алтай	100.0	32.2	46.0	16.3	3.4	1.8	0.2	0.1
Дорноговь	100.0	39.3	40.3	16.4	2.8	1.0	0.1	0.1
Дорнод	100.0	50.9	35.5	11.4	1.8	0.3	0.0	0.1
Дундговь	100.0	30.6	46.2	17.3	4.7	1.2	0.0	0.1
Завхан	100.0	33.5	45.7	15.6	3.7	1.2	0.1	0.2
Өвөрхангай	100.0	19.7	44.0	25.9	7.6	2.6	0.2	0.1
Өмнөговь	100.0	30.4	45.0	16.8	5.1	2.2	0.1	0.4
Сүхбаатар	100.0	43.0	43.2	11.7	1.2	0.7	0.1	0.2
Сэлэнгэ	100.0	36.8	39.8	17.4	4.8	1.0	0.1	0.2
Төв	100.0	39.4	41.0	14.3	4.0	1.1	0.1	0.2
Увс	100.0	26.2	45.7	20.4	5.4	2.0	0.2	0.0
Ховд	100.0	29.7	46.4	17.9	4.0	1.6	0.2	0.2
Хөвсгөл	100.0	54.0	29.0	11.6	4.3	0.7	0.1	0.3
Хэнтий	100.0	49.3	35.7	12.3	1.8	0.7	0.1	0.2
Дархан-Уул	100.0	36.7	38.7	18.9	4.9	0.6	0.1	0.1
Улаанбаатар	100.0	30.4	40.8	20.6	5.4	2.3	0.3	0.2
Орхон	100.0	38.9	38.6	17.8	3.5	0.9	0.0	0.2
Говьсүмбэр	100.0	26.1	53.3	17.3	2.5	0.5	0.0	0.3

Байшинд амьдардаг өрхийн сууцны өрөөний тоог аймаг, нийслэл, хот хөдөөгөөр ангилахад нэлээд ялгаатай байна. Тухайлбал, байшинд амьдардаг хотын өрхийн өрөөний тоогоор Баян-Өлгий аймаг нэлээд онцлогтой юм. Тав түүнээс дээш өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн нийт байшинд суудаг өрхөд эзлэх хувь улсын дунджаар 2.7 байхад энэ үзүүлэлт Баян-Өлгий аймагт 16.4 байна. Энэ аймгийн иргэд өөрсдөө байшингаа барьж суудаг, нөгөө талаар Казахын ард түмний өрхийн дундаж ам бүлийн тоо улсын дунджаас дээгүүр байдагтай холбоотой. Бусад аймаг, нийслэлийн хувьд байшинд амьдардаг хотын нийт өрхөд 2 өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь ерөнхийдөө ойролцоо, 40-өөс дээш хувийг эзэлж байна. Байшинд амьдардаг хотын өрхийн 3 түүнээс дээш өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үед 21.4 хувь байсан бол 2010 онд 28.2 хувь болж өссөн зэргээс үзэхэд хотын өрхийн сууцны багтаамж сайжирсныг харуулж байна. (Хавсралт 4.2).

Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн хувьд сууцных нь өрөөний тоо хотын өрхөөс нэлээд ялгаатай юм. Тухайлбал, Байшинд амьдардаг хотын нийт өрхөд нэг өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 31,5 хувь байхад хөдөөд энэ үзүүлэлт 43.6 хувь буюу 12.1 пунктээр илүү юм. Гэхдээ энэ үзүүлэлт өмнөх тооллогын үеэс 12.6 пунктээр буурсан байна. Харин 2 өрөөтэй сууцанд амьдрагчдын хувь хөдөөд хотоос 5.2 пунктээр бага байгаагаас үзэхэд хөдөөд нэг өрөөтэй сууц арай дамгайлдаг аж. Булган аймгийн нэг өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 68.6 байгаа нь бусдаас нэлээд өндөр үзүүлэлт юм (Хавсралт 4.3).

Байшинд амьдардаг өрхийн сууцны багтаамжийг харуулах өөр нэг үзүүлэлт бол сууцны өрөөний тоог өрхийн ам бүлийн тоогоор харьцуулсан үзүүлэлт билээ. Тус улсын өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 73.6 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад 9.1 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт хотод 72.5 хувь байгаа нь өмнөх тооллогын үеэс 8.2 пунктээр, хөдөөд 81.0 хувь байгаа нь өмнөх тооллогын үеэс 9.0 пунктээр тус тус буурсан аж. Харин 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 62.0 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 11.7 пунктээр буурсан аж. Долоо, түүнээс дээш ам бүлтэй байшинд амьдардаг өрхийн 4.6 хувь 5-аас олон өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2000 оныхоос 5.1 дахин өссөн зэргээс үзэхэд байшинд амьдардаг өрхийн сууцны багтаамж өмнөх 10 жилийнхээс нэлээд сайжирсныг харуулж байна.

#### ХҮСНЭГТ 4.4 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛ, ӨРӨӨНИЙ ТООГООР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд*		Өрөөний тоо							
			нэг		хоёр		гурав		дөрөв ба дээш	
	мян. өрх	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>378.2</b>	<b>100.0</b>	<b>127.1</b>	<b>33.6</b>	<b>149.4</b>	<b>39.5</b>	<b>71.4</b>	<b>18.9</b>	<b>30.2</b>	<b>8.0</b>
1-2	95.0	100.0	41.3	43.5	35.1	37.0	13.8	14.5	4.8	5.1
3-4	180.6	100.0	59.2	32.8	73.6	40.8	34.2	18.9	13.6	7.5
5-6	82.8	100.0	22.0	26.5	33.1	40.0	18.6	22.4	9.2	11.1
7+	19.8	100.0	4.7	23.5	7.6	38.4	4.9	24.9	2.6	13.1
<b>БҮГД- ХОТ</b>	<b>312.1</b>	<b>100.0</b>	<b>98.3</b>	<b>31.5</b>	<b>126.1</b>	<b>40.4</b>	<b>62.3</b>	<b>20.0</b>	<b>25.3</b>	<b>8.1</b>
1-2	77.9	100.0	32.2	41.3	29.5	37.9	12.1	15.5	4.2	5.4
3-4	149.8	100.0	46.2	30.9	62.2	41.5	29.8	19.9	11.5	7.7
5-6	67.8	100.0	16.4	24.1	27.8	41.0	16.1	23.8	7.5	11.1
7+	16.7	100.0	3.6	21.6	6.6	39.6	4.3	25.9	2.1	12.8
<b>БҮГД-ХӨДӨӨ</b>	<b>66.0</b>	<b>100.0</b>	<b>28.8</b>	<b>43.6</b>	<b>23.3</b>	<b>35.2</b>	<b>9.1</b>	<b>13.8</b>	<b>4.9</b>	<b>7.4</b>
1-2	17.1	100.0	9.2	53.5	5.6	32.9	1.7	10.0	0.6	3.7
3-4	30.8	100.0	13.0	42.1	11.4	36.9	4.4	14.1	2.1	6.9
5-6	15.0	100.0	5.6	37.3	5.3	35.3	2.4	16.2	1.7	11.2
7+	3.1	100.0	1.0	34.1	1.0	31.7	0.6	19.4	0.5	14.8

\* Нийтийн зориулалтын байр, бусад байр ороогүй

#### 4.2. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ

Байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамжийн үзүүлэлтийг өмнөх тооллогын үеэс нэлээд дэлгэрэнгүй эх үүсвэрээр нь авсан. Ингэхдээ тухайн өрхийн цахилгааны эх үүсвэрээс үл хамааран цахилгааны эх үүсвэртэй бол цахилгаанаар хангасан гэж үзэв. Нэгдүгээр бүлэгт орон нутгийг цахилгаанаар хангах төсөл хөтөлбөр гаргаж багагүй хөрөнгө хүч зарцуулсны дүнд чамлахааргүй амжилт олсныг тэмдэглэсэн. Байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамж өнгөрсөн 10 жилд нэлээд нэмэгдсэн боловч аймаг, нийслэл, байршлаар ангилж үзэхэд анхаарх зарим зүйл байна.

ХҮСНЭГТ 4.5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН.

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>382.8</b>	<b>100.0</b>	<b>315.8</b>	<b>100.0</b>	<b>67.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	358.3	93.6	310.4	98.3	47.9	71.5
Дизель станц	7.0	1.8	3.8	1.2	3.3	4.9
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	13.5	3.5	0.6	0.2	12.9	19.3
Бага оврын цахилгаан үүсгүүр	2.0	0.5	0.6	0.2	1.3	2.0
Цахилгааны эх үүсвэргүй	2.0	0.5	0.8	0.2	1.3	1.9


Байшинд амьдардаг нийт өрхийн 99.5 хувийг цахилгаанаар хангасан байна. Өмнөх тооллогын үед хотын бүх өрхийн 1.5 хувь нь цахилгаангүй байсан бол 2010 онд 0.5 хувь болсон нь сайн талтай боловч, 2.0 мянган өрх үүний дотор хотод 800 өрх цахилгааны эх үүсвэргүй байна.

ХҮСНЭГТ 4.6. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНААР ХАНГАСАН БАЙДАЛ, 2010 ОН.

	Бүгд		Цахилгаантай		Цахилгаангүй	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>382.8</b>	<b>100.0</b>	<b>380.8</b>	<b>99.5</b>	<b>2.0</b>	<b>0.5</b>
Архангай	6.4	100.0	6.4	99.5	0.0	0.5
Баян-Өлгий	18.2	100.0	17.7	97.4	0.5	2.6
Баянхонгор	2.9	100.0	2.9	99.7	0.0	0.3
Булган	7.2	100.0	7.1	98.6	0.1	1.4
Говь-Алтай	2.3	100.0	2.3	99.7	0.0	0.3
Дорноговь	8.8	100.0	8.8	99.8	0.0	0.2
Дорнод	11.7	100.0	11.6	98.6	0.2	1.4
Дундговь	1.9	100.0	1.9	99.8	0.0	0.2
Завхан	4.6	100.0	4.6	99.8	0.0	0.2
Өвөрхангай	4.9	100.0	4.9	99.9	0.0	0.1
Өмнөговь	2.8	100.0	2.8	99.6	0.0	0.4
Сүхбаатар	4.0	100.0	4.0	99.2	0.0	0.8
Сэлэнгэ	20.1	100.0	19.9	99.4	0.1	0.6
Төв	9.1	100.0	9.0	99.7	0.0	0.3
Увс	2.8	100.0	2.8	99.6	0.0	0.4
Ховд	4.9	100.0	4.8	97.7	0.1	2.3
Хөвсгөл	12.2	100.0	12.0	98.6	0.2	1.4
Хэнтий	7.2	100.0	7.1	98.9	0.1	1.1
Дархан-Уул	19.6	100.0	19.6	99.7	0.1	0.3
Улаанбаатар	210.6	100.0	210.1	99.8	0.5	0.2
Орхон	18.1	100.0	18.1	99.8	0.0	0.2
Говьсүмбэр	2.4	100.0	2.4	99.8	0.0	0.2

Байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамж аймаг, нийслэлд ерөнхийдөө өнгөрсөн 10 жилээс жигд сайжирсныг дараах зургаас харж болно.

ЗУРАГ 4.2. БАЙШИНД АМЬДАРДАГ ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРГҮЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН.



Баян-Өлгий аймгийн байшинд суудаг цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 10 жилийн өмнөхөөс 23.8 дахин буурсан нь хамгийн дээд үзүүлэлт юм. Үүний дараа Дорнодод 18.3 дахин, Сүхбаатарт 16.6 дахин, Хэнтийд 15 дахин, Хөвсгөлд 11.5 дахин нэмэгджээ.

### 4.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ДЭД БҮТЭЦ, АХУЙН НӨХЦӨЛ

Энэ удаагийн тооллогоор байшинд амьдардаг өрхийн дэд бүтэц, орон сууцны нөхцөлийн талаар өмнөх тооллогынхоос нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулсныг дээр дурдсан. Байшинд амьдардаг өрхийн сууцны нөхцөлийн хувьд цахилгааны хангамж, усан хангамж, бие засах газар, гал тогооны өрөө, хог хаягдал, халаалт зэргийг хамруулсан болно.

#### ДУЛААНЫ ХАНГАМЖ

Хүйтний улиралд байр сууцаа дулаан байлгах нь гэр бүлийн тав тухтай, эрүүл амьдрах нэг чухал нөхцөл болдог билээ. Байшинд амьдардаг өрхийн 43.8 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 0.6 пунктээр буурсан аж. Хотын төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн хувь 3.2 пунктээр буурсан бол хөдөөд бараг 3 дахин нэмэгджээ. Сууцаа ердийн галлагаагаар халаадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь хот, хөдөөд нэмэгдсэний дотор ялангуяа хотод илүү нэмэгдсэн байна. Энэ бүхнээс үзэхэд өнгөрсөн 10 жилийн хугацаанд дулааны шугам сүлжээ, дэд бүтцийг бий болгох асуудал учир дутагдалтай явж ирснийг харуулна. Нөгөө талаар иргэд гол төлөв ердийн галлагаатай байшин барьж амьдрах нь нэмэгдсэнтэй холбоотойгоор төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувийн жин буурчээ. Хотод ердийн галлагаагаар сууцаа халаах явдал нэмэгдсэн нь томоохон хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх нэг нөхцөл болж байна.

#### ХҮСНЭГТ 4.7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Халаалтын төрөл	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн	44.4	54.8	2.5	43.8	51.6	7.2
Төвлөрсөн бус	12.2	12.0	13.0	5.9	6.3	4.1
<i>Нам даралтын зуух</i>	-	-	-	5.3	5.6	3.6
<i>Цахилгаан халаагуур</i>	-	-	-	0.6	0.7	0.5
Ердийн галлагаа	43.4	33.2	84.5	50.2	42.1	88.7

Байшинд амьдардаг өрхийн орон сууцны халаалтын төрөл нь аймаг, нийслэлд харилцан адилгүй байна.

ХҮСНЭГТ 4.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР,  
ХАЛААЛТЫН ТӨРЛӨӨР, ХУВИАР, 2000, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд		Халаалтын төрөл					
	мян.өрх	эзлэх хувь	Төвлөрсөн		Төвлөрсөн бус		Ердийн галлагаа	
			мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>382.8</b>	<b>100.0</b>	<b>167.5</b>	<b>43.8</b>	<b>23</b>	<b>6.0</b>	<b>192.3</b>	<b>50.2</b>
Архангай	6.4	100.0	0.6	9.7	0.2	2.9	5.6	87.4
Баян-Өлгий	18.2	100.0	0.6	3.4	0.7	4.0	16.8	92.6
Баянхонгор	2.9	100.0	1.0	32.9	0.3	9.3	1.7	57.8
Булган	7.2	100.0	0.4	5.9	0.1	1.8	6.7	92.3
Говь-Алтай	2.3	100.0	1.1	45.3	0.3	12.1	1.0	42.6
Дорноговь	8.8	100.0	3.9	44.5	0.7	8.1	4.2	47.4
Дорнод	11.7	100.0	4.6	39.0	0.2	2.1	6.9	58.9
Дундговь	1.9	100.0	0.6	33.0	0.2	8.7	1.1	58.3
Завхан	4.6	100.0	0.7	15.5	0.2	3.8	3.7	80.7
Өвөрхангай	4.9	100.0	0.8	15.5	0.4	8.2	3.7	76.4
Өмнөговь	2.8	100.0	0.9	32.5	0.4	13.4	1.5	54.0
Сүхбаатар	4.0	100.0	1.0	25.6	0.3	8.1	2.7	66.4
Сэлэнгэ	20.1	100.0	4.5	22.3	0.5	2.4	15.1	75.2
Төв	9.1	100.0	1.8	20.0	0.5	5.0	6.8	75.0
Увс	2.8	100.0	0.7	27.0	0.3	11.1	1.7	61.9
Ховд	4.9	100.0	1.2	24.6	0.5	9.7	3.2	65.6
Хөвсгөл	12.2	100.0	0.7	5.8	0.2	1.9	11.2	92.3
Хэнтий	7.2	100.0	2.5	34.1	0.4	5.7	4.3	60.2
Дархан-Уул	19.6	100.0	12.6	64.0	0.3	1.5	6.8	34.5
Улаанбаатар	210.6	100.0	115.6	54.9	15.9	7.6	79.1	37.6
Орхон	18.1	100.0	10.1	55.7	0.3	1.8	7.7	42.5
Говьсүмбэр	2.4	100.0	1.6	67.4	0.1	4.5	0.7	28.1

Өнгөрсөн тооллогын үед байшинд суудаг өрхөөс төвлөрсөн халаалтын системгүй байсан Архангай аймгийн байшинд суудаг өрхийн 9.7 хувь, Баянхонгор аймгийн 32.9 хувь нь төвлөрсөн системээр халдаг болсон дэвшил гарсан байна. Үүнээс гадна өмнөх тооллогын үед төвлөрсөн халаалтын системд холбогдсон өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жингээр хамгийн доогуур хувьтай байсан Баян-Өлгий аймагт 3.4 хувь, Хөвсгөл аймагт 5.8 хувь болж өссөнөөс гадна Төв аймагт 20.0 хувь болж өмнөхөөсөө 6.3 дахин нэмэгджээ. Мөн Завхан аймгийн байшинд амьдардаг нийт өрхийн 15.5 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон нь өмнөх тооллогын үеэс 2.3 дахин өссөн аж.

Байшинд амьдардаг нийт өрхөөс халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 38.7 байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 1.1 пунктээр буурчээ. Үг үзүүлэлт хотод 46.0 хувь, байгаа нь өмнөх тооллогын үеэс 3.3 пунктээр буурчээ. Энэ нь иргэд хувиараа байшин барьж суух нь олширч, төвлөрсөн системд холбогдсон халуун, хүйтэн устай тохилог сууцанд орогчдоос илүү байгааг харуулна. Харин хөдөөд халуун хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 3.7 байгаа нь өнгөрсөн тооллогын үеэс 2 дахин нэмэгдсэн байна. Байшинд амьдардаг өрхийн 56.8 хувь буюу 214.7 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор хотын 152.7 мянган өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 3.0 пунктээр нэмэгдсэний дотор хотод 5.5 пункт, хөдөөд 1.3 пунктээр тус тус ихэсчээ.



ХҮСНЭГТ 4.9. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Усан хангамж	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Төвлөрсөн усан хангамж</b>	<b>42.8</b>	<b>50.6</b>	<b>5.9</b>
Халуун, хүйтэн устай	38.5	45.8	3.6
Зөвхөн хүйтэн устай	4.4	4.8	2.4
<b>Төвлөрсөн бус усан хангамж</b>	<b>57.2</b>	<b>49.4</b>	<b>94.1</b>
Бие даасан систем	0.4	0.4	0.3
Халуун, хүйтэн устай	0.2	0.2	0.2
Зөвхөн хүйтэн устай	0.2	0.2	0.2
Зөөврийн	56.8	48.9	93.8

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно.

ХҮСНЭГТ 4.10. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХУВИАР, 2000, 2010 ОН


	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БИЕ ЗАСАХ ГАЗАР</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Сууцны дотор</b>	<b>46.9</b>	<b>57.9</b>	<b>2.9</b>	<b>42.4</b>	<b>50.1</b>	<b>5.9</b>
Бусадтай хамтран ашигладаг	1.9	2.4	0.1	6.1	7.2	0.8
Бусадтай хамтран ашигладаггүй	45.0	55.5	2.8	36.3	42.9	5.2
<b>Сууцны гадна</b>	<b>53.1</b>	<b>42.1</b>	<b>97.1</b>	<b>55.5</b>	<b>49.4</b>	<b>84.3</b>
Бусадтай хамтран ашигладаг	-	-	-	24.9	23.3	32.5
Бусадтай хамтран ашигладаггүй	-	-	-	30.7	26.2	51.8
<b>Тогтсон газар байхгүй</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2.1</b>	<b>0.5</b>	<b>9.7</b>
<b>ОНГОЦ, ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Өрөөтэй</b>	<b>43.4</b>	<b>53.5</b>	<b>3.0</b>	<b>40.6</b>	<b>47.8</b>	<b>6.6</b>
Байнгын суурилуулсан	-	-	-	40.0	47.1	6.0
Угсардаг /зөөврийн/	-	-	-	0.7	0.7	0.5
<b>Нийтээрээ ашигладаг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2.2</b>	<b>2.5</b>	<b>0.5</b>
<b>Өрөөгүй</b>	<b>56.7</b>	<b>46.5</b>	<b>97.0</b>	<b>57.2</b>	<b>49.6</b>	<b>92.9</b>

Сууцны дотор бие засах газартай өрх улсын хэмжээнд 42.4 хувь болсон нь 2000 оноос 4.5 пунктээр буурсан бол сууцны гаднаа бие засах газартай өрх нэмэгджээ. Хот суурин газарт бие засах тогтсон газаргүй 1458 өрх байна.

Байшинд амьдардаг өрхийн онгоц, шүршүүрийг энэ удаагийн тооллогод өрх дангаараа эзэмшдэг болон нийтээрээ ашигладаг, онгоц шүршүүргүй гэсэн ангиллаар тусгасан. Өмнөх тооллогод уг үзүүлэлтийг онгоц, шүршүүрийн өрөөтэй, өрөөгүй гэж ангилан, өрөөтэйг


тусдаа болон нийтийн хэмжээнд салгаж тодорхойлсон. Үүнийг энэ бүлэгт 2 тооллогын үр дүнг харьцуулах үүднээс тусдаа, нийтийн гэсэн дэд ангиллыг салгаж оруулсангүй (хүснэгт 4.9). Байшинд амьдардаг нийт өрхийн 42.8 хувь (тусдаа эзэмшдэг 40.6 хувь, нийтээрээ ашигладаг 2.2 хувь) нь онгоц, шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 0.6 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт хотод 3.1 пунктээр буурсан бол хөдөөд 4.1 пунктээр нэмэгдсэн байна. Байнгын суурилуулсан онгоц, шүршүүртэй сууцанд амьдардаг өрх нийт байшинд амьдардаг өрхийн 40.0 хувийг эзэлж байгаагийн дотор хөдөөд 6 хувь байгаа нь хангалтгүй юм. Харин онгоц шүршүүргүй өрхийн хувь улсын хэмжээнд 57.2 байхад хөдөөгийн өрхийн бараг 93 хувь нь ийм сууцанд амьдарч байна.

ЗУРАГ 4.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН, ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН



Өрхийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдлоос гарахад ихээхэн нөлөөтэй, ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот суурин газруудад хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө. Байшинд амьдардаг өрхийн 77.1 хувь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеэс ихээхэн дэвшил гарсан байна. 2000 онд байшинд суудаг өрхийн 10 хувь хатуу хог хаягдлыг зайлуулах тодорхой цэг байхгүй байсан бол 2010 онд 5 хувь болтлоо буурчээ.

ЗУРАГ 4.4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН



Байшинд амьдардаг өрхийн 42.3 хувь нь төвлөрсөн системээр, 0.4 хувь нь бие даасан системээр бохир усаа зайлуулж, 48.3 хувь нь цооногт, үлдсэн 9 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгаж байгаа хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоотой.

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлт тус бүрд хэрхэн хангасан талаар бид өмнө нь үзүүлсэн. Харин байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн голлох 5 үзүүлэлтийг сонгож хамтатган үзвэл хэр зэрэг хангасан байдлыг дараах байдлаар ангилж үзүүлэв. Үүнд:

- У- Ундны усны баталгаат эх үүсвэртэй өрх. Эдгээрт ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн систем болон төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг шанд, цэвэршүүлэн савласан усаар хангасан өрх
- Ц- Цахилгааны эх үүсвэрээр хангасан өрх. Цахилгааны эх үүсвэр нь төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан эх үүсвэрээр хангасан өрх
- Ж- Бие засах цэг нь сууц дотор, дангаараа өрх. Байшинд амьдардаг орон сууцны болон тохилог сууцанд бол сууц дотроо, орон сууцны тусдаа байшин буюу төв суурин газрын гэр хорооллын байшингуудын хувьд бие засах газраа дангаараа ашигладаг өрх
- Б- Бохир ус зайлуулах төвлөрсөн, төвлөрсөн бус системтэй, өрх. Бохир усаа төвлөрсөн системээр, эсвэл бие даасан системээр зайлуулдаг, мөн цооногт асгадаг өрх
- Х- Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар, эсвэл тогтсон цэгт асгадаг өрх. Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар эсвэл зөвшөөрөгдсөн цэгт асгаад тогтмол зайлуулдаг өрх

Байшинд амьдардаг өрхүүдийг ахуйн нөхцөлийг хангасан байдлаар дараах байдлаар 6 ангилж үзэв (Ангиллыг 1 дүгээр бүлгээс үзнэ үү).

ХҮСНЭГТ 4.11. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	УЦЖБХ	Хувь	Бүгд	УЦЖБХ	Хувь	Бүгд	УЦЖБХ	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>138 563</b>	<b>36.2</b>	<b>316 116</b>	<b>135 188</b>	<b>42.8</b>	<b>66 692</b>	<b>3 375</b>	<b>5.1</b>
Архангай	6 425	456	7.1	3 267	453	13.9	3 158	3	0.1
Баян-Өлгий	18 175	441	2.4	6 834	440	6.4	11 341	1	0.0
Баянхонгор	2 923	820	28.1	2 091	820	39.2	832	-	-
Булган	7 245	344	4.7	3 264	337	10.3	3 981	7	0.2
Говь-Алтай	2 324	735	31.6	1 529	732	47.9	795	3	0.4
Дорноговь	8 804	2 817	32.0	6 339	2 375	37.5	2 465	442	17.9
Дорнод	11 714	3 169	27.1	7 761	3 158	40.7	3 953	11	0.3
Дундговь	1 872	516	27.6	1 078	511	47.4	794	5	0.6
Завхан	4 609	415	9.0	2 012	411	20.4	2 597	4	0.2
Өвөрхангай	4 903	556	11.3	3 474	549	15.8	1 429	7	0.5
Өмнөговь	2 846	699	24.6	1 509	660	43.7	1 337	39	2.9
Сүхбаатар	4 000	774	19.4	1 977	702	35.5	2 023	72	3.6
Сэлэнгэ	20 063	3 474	17.3	11 545	2 657	23.0	8 518	817	9.6
Төв	9 060	1 225	13.5	2 195	972	44.3	6 865	253	3.7
Увс	2 767	610	22.0	1 530	610	39.9	1 237	-	-
Ховд	4 944	1 033	20.9	2 849	1 021	35.8	2 095	12	0.6
Хөвсгөл	12 187	425	3.5	6 266	421	6.7	5 921	4	0.1
Хэнтий	7 212	1 804	25.0	4 188	1 795	42.9	3 024	9	0.3
Дархан-Уул	19 620	9 873	50.3	16 399	8 783	53.6	3 221	1 090	33.8
Улаанбаатар	210 596	98 320	46.7	210 596	98 320	46.7	-	-	-
Орхон	18 108	8 730	48.2	17 674	8 589	48.6	434	141	32.5
Говьсүмбэр	2 411	1 327	55.0	1 739	872	50.1	672	455	67.7

Байшинд амьдардаг нийт өрхийн 36.2 хувь нь ахуйн нөхцөл сайтай байгаагийн дотор орон сууцны байшин, бие даасан тохилог сууц олонтой том хотуудын тал шахам хувь нь хангажээ. Харин аймгуудаас орон сууцны байшин олонтой Говьсүмбэр аймаг илүү хангасан аж. Үүнээс гадна Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Завхан аймгуудын байшинд амьдардаг нийт өрхийн 10 хүрэхгүй хувь нь ахуйн нөхцөлийг сайн хангасан байгаа нь бусдаас доогуур байгааг анхаарч тухайн аймгийн төр захиргааны байгууллагууд ард иргэдийг орон сууцжуулах болон орон сууцны тусдаа байшинд амьдрагчдын ахуйн нөхцөлийг сайжруулах талаар тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй. Байшинд амьдардаг хотын нийт өрхөд ахуйн нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь улсын дунджаар 42.8 хувь байгаагийн дотор Баян-Өлгий, Хөвсгөл аймгууд улсын дунджаас бараг 7 дахин, бусад аймгуудаас ч ихээхэн доогуур байгаа нь эдгээр аймгийн байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах талаар онцгойлон анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 4.12. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>24 715</b>	<b>6.5</b>	<b>316 116</b>	<b>24 066</b>	<b>7.6</b>	<b>66 692</b>	<b>649</b>	<b>1.0</b>
Архангай	6 425	91	1.4	3 267	91	2.8	3 158	-	-
Баян-Өлгий	18 175	129	0.7	6 834	128	1.9	11 341	1	0.0
Баянхонгор	2 923	69	2.4	2 091	68	3.3	832	1	0.1
Булган	7 245	69	1.0	3 264	62	1.9	3 981	7	0.2
Говь-Алтай	2 324	139	6.0	1 529	138	9.0	795	1	0.1
Дорноговь	8 804	966	11.0	6 339	811	12.8	2 465	155	6.3
Дорнод	11 714	1 208	10.3	7 761	1 202	15.5	3 953	6	0.2
Дундговь	1 872	55	2.9	1 078	54	5.0	794	1	0.1
Завхан	4 609	141	3.1	2 012	140	7.0	2 597	1	0.0
Өвөрхангай	4 903	117	2.4	3 474	113	3.3	1 429	4	0.3
Өмнөговь	2 846	164	5.8	1 509	136	9.0	1 337	28	2.1
Сүхбаатар	4 000	166	4.2	1 977	130	6.6	2 023	36	1.8
Сэлэнгэ	20 063	522	2.6	11 545	342	3.0	8 518	180	2.1
Төв	9 060	310	3.4	2 195	221	10.1	6 865	89	1.3
Увс	2 767	106	3.8	1 530	105	6.9	1 237	1	0.1
Ховд	4 944	131	2.6	2 849	128	4.5	2 095	3	0.1
Хөвсгөл	12 187	68	0.6	6 266	67	1.1	5 921	1	0.0
Хэнтий	7 212	467	6.5	4 188	459	11.0	3 024	8	0.3
Дархан-Уул	19 620	2 555	13.0	16 399	2 450	14.9	3 221	105	3.3
Улаанбаатар	210 596	15 868	7.5	210 596	15 868	7.5	-	-	-
Орхон	18 108	1 170	6.5	17 674	1 159	6.6	434	11	2.5
Говьсүмбэр	2 411	204	8.5	1 739	194	11.2	672	10	1.5

Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг сайн хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь нэлээд өндөр байсан Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, нийслэлийн ахуйн нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь бага байгаа нь зүйн асуудал билээ. Гэвч байшинд амьдардаг ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусад аймгаас доогуур байсан Хөвсгөл, Баян-Өлгий, Завхан аймгууд ахуйн нөхцөлийг хангасан өрхийн дотор мөн л сүүлчийн байрыг эзэлж байгаагаас үзэхэд эдгээр аймагт байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгааг тооллогын дүн харуулж байна.

Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг сайн хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь нэлээд өндөр байсан Дорноговь, Дорнод аймгийн ахуйн нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь нэлээд өндөр байгаа нь эдгээр аймгийн байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл бусад аймгуудыг бодвол нэлээд сайн байгааг харуулжээ.

ХҮСНЭГТ 4.13. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАГАС ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>158 998</b>	<b>41.5</b>	<b>316 116</b>	<b>129 595</b>	<b>41.0</b>	<b>66 692</b>	<b>29 403</b>	<b>44.1</b>
Архангай	6 425	3 908	60.8	3 267	2 412	73.8	3 158	1 496	47.4
Баян-Өлгий	18 175	1 844	10.1	6 834	802	11.7	11 341	1 042	9.2
Баянхонгор	2 923	902	30.9	2 091	252	12.1	832	650	78.1
Булган	7 245	3 945	54.5	3 264	1 606	49.2	3 981	2 339	58.8
Говь-Алтай	2 324	865	37.2	1 529	248	16.2	795	617	77.6
Дорноговь	8 804	3 543	40.2	6 339	2 245	35.4	2 465	1 298	52.7
Дорнод	11 714	4 361	37.2	7 761	2 859	36.8	3 953	1 502	38.0
Дундговь	1 872	1 110	59.3	1 078	488	45.3	794	622	78.3
Завхан	4 609	2 332	50.6	2 012	628	31.2	2 597	1 704	65.6
Өвөрхангай	4 903	3 638	74.2	3 474	2 488	71.6	1 429	1 150	80.5
Өмнөговь	2 846	1 584	55.7	1 509	671	44.5	1 337	913	68.3
Сүхбаатар	4 000	2 485	62.1	1 977	1 087	55.0	2 023	1 398	69.1
Сэлэнгэ	20 063	6 402	31.9	11 545	3 209	27.8	8 518	3 193	37.5
Төв	9 060	5 519	60.9	2 195	826	37.6	6 865	4 693	68.4
Увс	2 767	1 424	51.5	1 530	715	46.7	1 237	709	57.3
Ховд	4 944	2 001	40.5	2 849	1 242	43.6	2 095	759	36.2
Хөвсгөл	12 187	6 543	53.7	6 266	4 908	78.3	5 921	1 635	27.6
Хэнтий	7 212	3 617	50.2	4 188	1 668	39.8	3 024	1 949	64.5
Дархан-Уул	19 620	5 500	28.0	16 399	4 088	24.9	3 221	1 412	43.8
Улаанбаатар	210 596	89 470	42.5	210 596	89 470	42.5	-	-	-
Орхон	18 108	7 624	42.1	17 674	7 428	42.0	434	196	45.2
Говьсүмбэр	2 411	381	15.8	1 739	255	14.7	672	126	18.8

Байшинд амьдардаг ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дундговь, Увс, Хэнтий Булган аймгууд бусдаас нэлээд өндөр, 100-гаас 2-3 өрх нь ахуйн нөхцөлийг хагас хангасан байхад уг үзүүлэлт Баян-Өлгий, Хөвсгөл аймагт 100-д 3 орчим өрх, Завханд 9 өрхөд ногдож байгаа нь бусдаас доогуур байна. Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл сайтай, ахуйн нөхцөлийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь маш бага байсан хөдөөгийн өрхийн хувь ахуйн нөхцөлийг хагас хангасан байдал нэлээд өндөр болж байгаа нь байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн ахуйн нөхцөлийн байдал тийм ч хангалттай биш байдгийг харуулж байна. Байшинд амьдардаг хөдөөгийн нийт өрхөд ахуйн нөхцөлийг хагас хангасан өрхийн эзлэх хувь Өвөрхангай, Баянхонгор, Дундговь аймагт бусдаас нэлээд өндөр байгаа боловч эдгээр аймгууд байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайн хангах талаар цаашид анхаарах шаардлага байгаа юм. Түүнчлэн, Баян-Өлгий аймаг байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах талаар бодлогын чанартай томоохон арга хэмжээ авах шаардлагатайг хүснэгт 4.10, 4.11, 4.12-оос тодорхой харагдаж байна. Энэ аймгийн нийт өрхөд байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь бусад аймгаас өндөр байгааг бид 1 дүгээр бүлгээс харж болох боловч тэдгээрийн ахуйн нөхцөлийг сайжруулахад анхаарах шаардлага тавигдаж байна.

ХҮСНЭГТ 4.14. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ДУТУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>47 042</b>	<b>12.3</b>	<b>316 116</b>	<b>25 256</b>	<b>8.0</b>	<b>66 692</b>	<b>21 786</b>	<b>32.7</b>
Архангай	6 425	1 711	26.6	3 267	304	9.3	3 158	1 407	44.6
Баян-Өлгий	18 175	8 965	49.3	6 834	5 280	77.3	11 341	3 685	32.5
Баянхонгор	2 923	1 115	38.1	2 091	950	45.4	832	165	19.8
Булган	7 245	2 044	28.2	3 264	1 039	31.8	3 981	1 005	25.2
Говь-Алтай	2 324	559	24.1	1 529	407	26.6	795	152	19.1
Дорноговь	8 804	1 394	15.8	6 339	899	14.2	2 465	495	20.1
Дорнод	11 714	2 302	19.7	7 761	501	6.5	3 953	1 801	45.6
Дундговь	1 872	165	8.8	1 078	22	2.0	794	143	18.0
Завхан	4 609	1 682	36.5	2 012	829	41.2	2 597	853	32.8
Өвөрхангай	4 903	553	11.3	3 474	319	9.2	1 429	234	16.4
Өмнөговь	2 846	298	10.5	1 509	40	2.7	1 337	258	19.3
Сүхбаатар	4 000	544	13.6	1 977	57	2.9	2 023	487	24.1
Сэлэнгэ	20 063	8 015	39.9	11 545	4 578	39.7	8 518	3 437	40.3
Төв	9 060	1 716	18.9	2 195	166	7.6	6 865	1 550	22.6
Увс	2 767	588	21.3	1 530	95	6.2	1 237	493	39.9
Ховд	4 944	1 464	29.6	2 849	454	15.9	2 095	1 010	48.2
Хөвсгөл	12 187	4 009	32.9	6 266	808	12.9	5 921	3 201	54.1
Хэнтий	7 212	994	13.8	4 188	238	5.7	3 024	756	25.0
Дархан-Уул	19 620	1 484	7.6	16 399	976	6.0	3 221	508	15.8
Улаанбаатар	210 596	6 561	3.1	210 596	6 561	3.1	-	-	-
Орхон	18 108	410	2.3	17 674	329	1.9	434	81	18.7
Говьсүмбэр	2 411	469	19.5	1 739	404	23.2	672	65	9.7

Байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн эзлэх хувь Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Завхан, Баянхонгор аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад өндөр байгаа нь сайн үзүүлэлт биш юм. Ялангуяа, эдгээр аймгийн байшинд амьдардаг хотын өрхийн дотор ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрхийн эзлэх хувь бусдаас өндөр байгаа нь төв суурин газрын хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг дээшлүүлэх, байгаль орчны бохирдлыг багасгах талаар анхаарах цаг болсон аж.

Байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөлийг муу хангасан өрхийн эзлэх хувь ерөнхийдөө бага байгаа боловч зарим аймгууд анхаарал татаж байна. Эдгээрийн дотор зуун өрх дутамд Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ аймаг тус бүрд хоёр өрх дутмын нэг нь, Хөвсгөл аймгийн 10 өрх дутмын нэг нь орон сууцны нөхцөл муутай байгаа аж. Хөдөөгийн байшинд амьдардаг зуун өрхөөс орон сууцны нөхцөлийг муу хангасан өрх Баян-Өлгийд 2, Булган, Дорнод, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт 6-10 өрх дутмын нэг нь ахуйн нөхцөлийг муу хангасныг Хүснэгт 4.14-өөс харж болно.

ХҮСНЭГТ 4.15. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛИЙГ МУУ ХАНГАСАН  
ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>12 695</b>	<b>3.3</b>	<b>316 116</b>	<b>1 901</b>	<b>0.6</b>	<b>66 692</b>	<b>10 794</b>	<b>16.2</b>
Архангай	6 425	241	3.8	3 267	4	0.1	3 158	237	7.5
Баян-Өлгий	18 175	6 419	35.3	6 834	172	2.5	11 341	6 247	55.1
Баянхонгор	2 923	17	0.6	2 091	1	0.0	832	16	1.9
Булган	7 245	773	10.7	3 264	216	6.6	3 981	557	14.0
Говь-Алтай	2 324	24	1.0	1 529	3	0.2	795	21	2.6
Дорноговь	8 804	79	0.9	6 339	9	0.1	2 465	70	2.8
Дорнод	11 714	628	5.4	7 761	38	0.5	3 953	590	14.9
Дундговь	1 872	26	1.4	1 078	3	0.3	794	23	2.9
Завхан	4 609	34	0.7	2 012	4	0.2	2 597	30	1.2
Өвөрхангай	4 903	38	0.8	3 474	4	0.1	1 429	34	2.4
Өмнөговь	2 846	97	3.4	1 509	2	0.1	1 337	95	7.1
Сүхбаатар	4 000	30	0.8	1 977	1	0.1	2 023	29	1.4
Сэлэнгэ	20 063	1 609	8.0	11 545	738	6.4	8 518	871	10.2
Төв	9 060	282	3.1	2 195	10	0.5	6 865	272	4.0
Увс	2 767	38	1.4	1 530	5	0.3	1 237	33	2.7
Ховд	4 944	290	5.9	2 849	4	0.1	2 095	286	13.7
Хөвсгөл	12 187	1 042	8.6	6 266	51	0.8	5 921	991	16.7
Хэнтий	7 212	304	4.2	4 188	27	0.6	3 024	277	9.2
Дархан-Уул	19 620	190	1.0	16 399	96	0.6	3 221	94	2.9
Улаанбаатар	210 596	339	0.2	210 596	339	0.2	-	-	-
Орхон	18 108	165	0.9	17 674	160	0.9	434	5	1.2
Говьсүмбэр	2 411	30	1.2	1 739	14	0.8	672	16	2.4

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор байшинд амьдардаг өрхийн орон сууцны нөхцөлийг сонгосон 5 үзүүлэлтээр тодорхойлсноос сууцных нь нөхцөл огт хангагдаагүй өрхийн эзлэх хувь 0,2 хувь байгаа нь хэдийгээр бага мэт байгаа боловч бодит тоогоороо 886 өрх байгаагийн 378 буюу 42,7 хувь нь ганцхан Баян-Өлгий аймагт байна. Мөн Хөвсгөл аймгийн байшинд амьдардаг нийт өрхийн 0.8 хувь буюу 101 өрх ахуйн нөхцөлийг огт хангаагүй байна.




ХҮСНЭГТ 4.16. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦЛИЙГ ОГТ ХАНГААГҮЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагдаагүй	Хувь
<b>БҮГД</b>	<b>382 808</b>	<b>795</b>	<b>0.2</b>	<b>316 116</b>	<b>110</b>	<b>0.0</b>	<b>66 692</b>	<b>685</b>	<b>1.0</b>
Архангай	6 425	18	0.3	3 267	3	0.1	3 158	15	0.5
Баян-Өлгий	18 175	377	2.1	6 834	12	0.2	11 341	365	3.2
Баянхонгор	2 923	-	-	2 091	-	-	832	-	-
Булган	7 245	70	1.0	3 264	4	0.1	3 981	66	1.7
Говь-Алтай	2 324	2	0.1	1 529	1	0.1	795	1	0.1
Дорноговь	8 804	5	0.1	6 339	-	-	2 465	5	0.2
Дорнод	11 714	46	0.4	7 761	3	0.0	3 953	43	1.1
Дундговь	1 872	-	-	1 078	-	-	794	-	-
Завхан	4 609	5	0.1	2 012	-	-	2 597	5	0.2
Өвөрхангай	4 903	1	0.0	3 474	1	0.0	1 429	-	-
Өмнөговь	2 846	4	0.1	1 509	-	-	1 337	4	0.3
Сүхбаатар	4 000	1	0.0	1 977	-	-	2 023	1	0.0
Сэлэнгэ	20 063	41	0.2	11 545	21	0.2	8 518	20	0.2
Төв	9 060	8	0.1	2 195	-	-	6 865	8	0.1
Увс	2 767	1	0.0	1 530	-	-	1 237	1	0.1
Ховд	4 944	25	0.5	2 849	-	-	2 095	25	1.2
Хөвсгөл	12 187	100	0.8	6 266	11	0.2	5 921	89	1.5
Хэнтий	7 212	26	0.4	4 188	1	0.0	3 024	25	0.8
Дархан-Уул	19 620	18	0.1	16 399	6	0.0	3 221	12	0.4
Улаанбаатар	210 596	38	0.0	210 596	38	0.0	-	-	-
Орхон	18 108	9	0.0	17 674	9	0.1	434	-	-
Говьсүмбэр	2 411	-	-	1 739	-	-	672	-	-

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг гэрт амьдардаг өрхийнхтэй зэрэгцүүлэхэд ерөнхийдөө дээгүүр байна. Тухайлбал, байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөлийг сайн хангасан өрхийн эзлэх хувь 3.7 дахин өндөр байхад, ахуйн нөхцөл нь огт хангагдаагүй өрхийн эзлэх хувь 17.5 дахин бага байна.

ЗУРАГ 4.5 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ХУВИАР, 2010 ОН



# ТАВДУГААР БҮЛЭГ

ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД  
АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ



Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор зориулалтын бус, бусад сууцанд 8.1 мянган өрх амьдарч байгааг 2 дугаар бүлэгт тэмдэглэсэн (*Зориулалтын бус, бусад сууцны тодорхойлолтыг нэгдүгээр бүлгээс үзнэ үү*). Эдгээр өрхийн сууцны нөхцөлийг энэ бүлэгт оруулав.

Зориулалтын бус, бусад байранд амьдардаг нийт өрхийн 81.6 хувь нь хотод, 18.4 хувь нь хөдөө оршин сууж байна.

## 5.1. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ӨМЧИЙН БОЛОН ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

Зориулалтын бус, бусад сууцанд амьдарч байгаа нийт өрхийн 39.8 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 48.6 хувь нь иргэний өмчийн байранд сууж байгаагийн дотор хөдөөд энэ үзүүлэлт 54.3 хувь байна.

ХҮСНЭГТ 5.1. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД БАЙРАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ӨМЧИЙН БОЛОН ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Сууцны өмчийн болон эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР-БҮГД</b>	<b>8 136</b>	<b>100.0</b>	<b>6 643</b>	<b>100.0</b>	<b>1 493</b>	<b>100.0</b>
Төрийн өмчийн	940	11.6	583	8.8	357	23.9
ААНБ-ын	3 238	39.8	2 913	43.9	325	21.8
Иргэний	3 958	48.6	3 147	47.4	811	54.3
<b>ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭРЭЭР-БҮГД</b>	<b>8 136</b>	<b>100.0</b>	<b>6 643</b>	<b>100.0</b>	<b>1 493</b>	<b>100.0</b>
Өөрийн эзэмшлийн	2 557	31.4	1 903	28.6	654	43.8
Бусдын сууцанд түрээстэй суудаг	2 257	27.8	2 011	30.3	246	16.5
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	2 029	24.9	1 586	23.9	443	29.7
Бусад	1 293	15.9	1 143	17.2	150	10.0

Зориулалтын бус, бусад сууцанд амьдарч байгаа нийт өрхийн 31.4 хувь нь өөрийнх нь эзэмшилд байгаагийн дотор хотод 28.6 хувь нь, хөдөөд 43.8 хувь байна. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 68.8 хувь буюу 5.6 мянган өрх, үүний дотор хотод 4.7 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь анхаарал татах асуудал юм.

ХҮСНЭГТ 5.2. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН  
СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Төрийн өмчийн	Аж ахуйн нэгж, байгууллагын	Иргэний
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>11.6</b>	<b>39.6</b>	<b>48.6</b>
Архангай	100.0	14.1	18.8	67.2
Баян-Өлгий	100.0	20.8	22.2	56.9
Баянхонгор	100.0	22.1	7.8	70.1
Булган	100.0	20.2	34.8	44.9
Говь-Алтай	100.0	14.0	11.6	74.4
Дорногвоь	100.0	16.0	22.2	61.8
Дорнод	100.0	2.9	10.6	86.4
Дундговь	100.0	32.7	22.4	44.9
Завхан	100.0	32.2	11.9	55.9
Өвөрхангай	100.0	36.6	25.8	37.6
Өмнөговь	100.0	20.8	12.5	66.7
Сүхбаатар	100.0	39.3	9.1	51.6
Сэлэнгэ	100.0	16.6	41.3	42.2
Төв	100.0	19.5	28.5	52.0
Увс	100.0	20.8	15.1	64.2
Ховд	100.0	7.6	25.0	67.4
Хөвсгөл	100.0	21.7	14.7	63.6
Хэнтий	100.0	17.6	36.0	46.4
Дархан-Уул	100.0	10.9	39.4	49.7
Улаанбаатар	100.0	8.5	57.8	33.7
Орхон	100.0	2.9	39.8	57.3
Говьсүмбэр	100.0	59.6	24.6	15.8

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг улсын хэмжээний нийт өрхийн 11.6 хувь нь төрийн өмчийн байранд сууж байна. Энэ үзүүлэлт Говьсүмбэрт улсын дунджаас 5.1 дахин өндөр байна. Хэдүйгээр зориулалтын бус, бусад сууц нь анхнаасаа хүн амьдархад зориулагдаагүй боловч хүн амьдархад зориулан засч тохижуулсан, тооллогын товын үед хүн амьдарч байгаа сууцыг хамруулсныг эхний бүлэгт тэмдэглэсэн. Хүн амьдрах үндсэн нөхцөлийн нэг болсон өөрийн өмчийн орон сууцтай болох нь өрхийн гишүүдийн амьдралын нэг чухал асуудал юм. Сууцыг өмчлөхөд анхаарал хандуулж, өрх бүрийг өөрийн өмчийн сууцтай болгох нь ард түмний амьдралыг дээшлүүлэх чухал асуудал учир төр засгийн шат шатны байгууллага болон иргэд өөрсдөө анхаарч хүчин чармайлт гаргах нь зүйтэй юм. Зориулалтын бус, бусад сууцанд амьдарч байгаа нийт өрхийн 39.6 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын өмч байгаагийн дотор Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт улсын дунджаас дээгүүр, Орхон, Булган, Хэнтий, аймгууд улсын дундажтай ойролцоо төвшинд байна. Аж ахуйн нэгж байгууллагын эзэмшилд байгаа сууц нь цаашдаа иргэний өмчлөлд шилжих боломж хомс байдгаараа онцлог юм.

ХҮСНЭГТ 5.3. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Өөрийн эзэмшлийн	Бусдын сууцанд түрээстэй суудаг	Бусдын сууцанд түрээсгүй суудаг	Бусад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>31.4</b>	<b>27.8</b>	<b>24.9</b>	<b>15.9</b>
Архангай	100.0	39.1	18.8	31.3	10.9
Баян-Өлгий	100.0	30.6	31.9	26.4	11.1
Баянхонгор	100.0	63.6	14.3	16.9	5.2
Булган	100.0	33.7	20.2	27.0	19.1
Говь-Алтай	100.0	68.6	8.1	17.4	5.8
Дорноговь	100.0	37.8	27.1	24.0	11.1
Дорнод	100.0	69.5	4.5	16.8	9.3
Дундговь	100.0	36.7	18.4	18.4	26.5
Завхан	100.0	44.1	16.9	23.7	15.3
Өвөрхангай	100.0	23.7	40.9	24.7	10.8
Өмнөговь	100.0	45.0	30.0	19.2	5.8
Сүхбаатар	100.0	46.3	7.7	19.6	26.3
Сэлэнгэ	100.0	21.1	26.5	33.2	19.3
Төв	100.0	40.6	20.1	33.2	6.0
Увс	100.0	60.4	1.9	18.9	18.9
Ховд	100.0	66.3	8.7	21.7	3.3
Хөвсгөл	100.0	22.5	10.1	51.2	16.3
Хэнтий	100.0	26.4	15.2	44.0	14.4
Дархан-Уул	100.0	31.3	26.8	24.0	17.9
Улаанбаатар	100.0	15.3	40.0	26.3	18.5
Орхон	100.0	34.0	22.4	20.3	23.2
Говьсүмбэр	100.0	61.4	1.8	24.6	12.3

Улсын хэмжээгээр зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 31.4 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдарч байна. Энэ үзүүлэлт Дорнод, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Говьсүмбэр аймагт бусдаас өндөр байгаа нь тэдгээр өрх зориулалтын бус сууцанд сууж байгаа хэдий ч тухайн сууц нь өөрийн эзэмшлийн сууц байгаа нь сайн талтай юм. Гэвч Баянхонгор, Дорнод, Увс, Ховд, Говьсүмбэр аймгаас бусад бүх аймаг, нийслэлд бусдын байранд суудаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 50 дээш хувьтай байгаагийн дотор Улаанбаатар хот, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий аймагт 70-аас дээш хувьтай байна. Эдгээр аймгийн төр захиргааны байгууллага анхаарч, өөрийн эзэмшлийн сууцтай болгох талаар тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

## 5.2. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛ

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны ахуйн нөхцөлд цахилгааны хангамж, ундны усны эх үүсвэр, бохир ус, хатуу хог хаягдал зайлуулах зэргийг хамруулав.

### УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан булаг шандаас усаа авдаг болон цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг өрхийг хамруулж байгааг эхний бүлэгт тэмдэглэсэн. Үүгээр тооцвол зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 70.9 хувь нь ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдсан байна.

### ХҮСНЭГТ 5.4. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН

Ундны усны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>8 136</b>	<b>100.0</b>	<b>6 643</b>	<b>100.0</b>	<b>1 493</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	3 627	44.6	3 598	54.2	29	1.9
Төвлөрсөн системд хологдсон ус түгээх байр	927	11.4	878	13.2	49	3.3
Хамгаалагдсан худаг	1 160	14.3	394	5.9	766	51.3
Хамгаалагдсан булаг, шанд	44	0.5	7	0.1	37	2.5
Цэвэршүүлэн савласан ус	8	0.1	8	0.1	-	-
Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	1 084	13.3	1 013	15.2	71	4.8
Зөөврийн ус	716	8.8	592	8.9	124	8.3
Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй булаг шанд	570	7.0	153	2.3	417	27.9

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхөөс ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээгээр 15.8 хувь байгаагийн дотор хотод 11.2 хувь, хөдөөд 36.2 хувь байна. Ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь хөдөөд өндөр байгаа нь гол, мөрөн, хамгаалагдаагүй булаг шандаас ундныхаа усыг авдаг өрх хамрагддаггүй нь манай орны онцлог юм.

ХҮСНЭГТ 5.5. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо			Хувиар		
	Бүгд	Баталгаат эх үүсвэртэй	Баталгаагүй эх үүсвэртэй	Бүгд	Баталгаат эх үүсвэртэй	Баталгаагүй эх үүсвэртэй
<b>БҮГД</b>	<b>8136</b>	<b>6850</b>	<b>1286</b>	<b>100.0</b>	<b>84.2</b>	<b>15.8</b>
Архангай	64	27	37	100.0	42.2	57.8
Баян-Өлгий	72	19	53	100.0	26.4	73.6
Баянхонгор	77	46	31	100.0	59.7	40.3
Булган	89	64	25	100.0	71.9	28.1
Говь-Алтай	86	76	10	100.0	88.4	11.6
Дорноговь	225	170	55	100.0	75.6	24.4
Дорнод	1 232	966	266	100.0	78.4	21.6
Дундговь	49	32	17	100.0	65.3	34.7
Завхан	59	41	18	100.0	69.5	30.5
Өвөрхангай	93	63	30	100.0	67.7	32.3
Өмнөговь	120	104	16	100.0	86.7	13.3
Сүхбаатар	285	240	45	100.0	84.2	15.8
Сэлэнгэ	223	118	105	100.0	52.9	47.1
Төв	298	258	40	100.0	86.6	13.4
Увс	53	33	20	100.0	62.3	37.7
Ховд	92	51	41	100.0	55.4	44.6
Хөвсгөл	129	80	49	100.0	62.0	38.0
Хэнтий	125	100	25	100.0	80.0	20.0
Дархан-Уул	358	301	57	100.0	84.1	15.9
Улаанбаатар	4 109	3 800	309	100.0	92.5	7.5
Орхон	241	209	32	100.0	86.7	13.3
Говьсүмбэр	57	52	5	100.0	91.2	8.8

Зориулалтын бус, бусад байранд амьдардаг өрхийн баталгаат ундны усны эх үүсвэртэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 84.2 хувь байхад 6 аймаг, нийслэл улсын дунджаас өндөр, харин улсын дунджаас доогуур байгаагийн дотор Баян-Өлгий улсын дунджаас 3.2 дахин доогуур байна. Гэхдээ энэ аймаг өндөр уулсын бүсэд оршдог гол төлөв булаг шанд, гол, нуур цөөрмөөс усаа авдаг онцлог. Мөн Архангай аймаг улсын дунджаас 2 дахин доогуур байгаа нь хангайн бүсэд оршдог гол мөрөн нуур цөөрмөөс ундныхаа усыг хэрэглэдэгтэй холбоотой.

**ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР**

Зориулалтын бус, бусад байранд амьдардаг өрхийн цахилгааны эх үүсвэрийг цахилгаан гаргадаг эх үүсвэрээр нь тодорхойлохын зэрэгцээгээр огт цахилгаан эх үүсвэргүй өрхийн тоог улсын хэмжээгээр, аймаг, нийслэлээр тодорхойлсон болно.

ХҮСНЭГТ 5.6. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО,  
ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН

Ундны усны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	8 136	100.0	6 643	100.0	1 493	100.0
Төвлөрсөн систем	7 372	90.6	6 314	95.0	1 058	70.9
Дизель станц	144	1.8	34	0.5	110	7.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	181	2.2	24	0.4	157	10.5
Бага оврын цахилгаан үүсгүүр	62	0.8	32	0.5	30	2.0
Цахилгааны эх үүсвэргүй	377	4.6	239	3.6	138	9.2

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг нийт өрхийн 4.6 хувь буюу 377 өрх цахилгааны эх үүсвэргүй байгаагийн дотор хотын өрхийн 3.6 хувь, хөдөөгийн өрхийн 9.2 хувь нь цахилгааны эх үүсвэргүй юм. Өнгөрсөн 10 жилд хот, хөдөөгийн өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангах талаар олон талт арга хэмжээ авсны дүнд цахилгаан эх үүсвэрээр хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь эрс сайжирсныг өмнөх бүлгүүдэд тэмдэглэж байсан. Гэвч зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүд үүний дотор хөдөөгийн 138 өрх цахилгааны эх үүсвэргүй байгаа нь сэргээгдэх эрчим хүчний хэрэгцээ нэлээд байгаа нь харагдаж байна. Хөдөөгийн цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 4.6 хувь байхад Хэнтий, Хөвсгөл, Архангай, Дорноговь, Завхан аймагт уг үзүүлэлт 2-3 дахин өндөр байна.

ХҮСНЭГТ 5.7. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Цахилгааны эх үүсвэр					
	Бүгд	Төвлөрсөн сиситем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан эх үүсвэр	Цахилгааны эх үүсвэргүй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>90.6</b>	<b>1.8</b>	<b>2.2</b>	<b>0.8</b>	<b>4.6</b>
Архангай	100.0	70.3	0.0	14.1	1.6	14.1
Баян-Өлгий	100.0	81.9	0.0	11.1	0.0	6.9
Баянхонгор	100.0	80.5	0.0	16.9	0.0	2.6
Булган	100.0	92.1	0.0	1.1	2.2	4.5
Говь-Алтай	100.0	8.1	65.1	23.3	0.0	3.5
Дорноговь	100.0	79.1	5.3	4.0	0.4	11.1
Дорнод	100.0	89.8	0.2	2.6	0.6	6.9
Дундговь	100.0	87.8	0.0	6.1	6.1	0.0
Завхан	100.0	6.8	79.7	3.4	0.0	10.2
Өвөрхангай	100.0	83.9	3.2	5.4	0.0	7.5
Өмнөговь	100.0	68.3	14.2	6.7	4.2	6.7
Сүхбаатар	100.0	97.2	0.0	0.7	0.0	2.1
Сэлэнгэ	100.0	88.3	0.0	4.0	2.2	5.4
Төв	100.0	89.6	2.0	1.7	2.3	4.4
Увс	100.0	71.7	0.0	20.8	0.0	7.5
Ховд	100.0	75.0	0.0	17.4	2.2	5.4
Хөвсгөл	100.0	76.0	0.0	5.4	4.7	14.0
Хэнтий	100.0	78.4	0.8	5.6	0.0	15.2
Дархан-Уул	100.0	93.3	0.0	0.0	0.0	6.7
Улаанбаатар	100.0	96.6	0.0	0.3	0.6	2.6
Орхон	100.0	92.9	0.0	0.4	0.0	6.6
Говьсүмбэр	100.0	98.2	0.0	0.0	0.0	1.8



### БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг нийт өрхөөс 3133 өрх бохир усаа цооногт, 1677 өрх задгай асгаж байгаа нь анхаарах асуудал билээ.

#### ХҮСНЭГТ 5.8. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БОХИР УС ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР, 2010 ОН

Бохир ус зайлуулдаг хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>8 136</b>	<b>100.0</b>	<b>6 643</b>	<b>100.0</b>	<b>1 493</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн системээр зайлуулдаг	3 249	39.9	3 224	48.5	25	1.7
Бие даасан системээр зайлуулдаг	77	0.9	61	0.9	16	1.1
Цооногт асгадаг	3 133	38.5	2 182	32.8	951	63.7
Задгай асгадаг	1 677	20.6	1 176	17.7	501	33.6

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 20.6 хувь нь бохир усаа задгай асгаж байгаагийн дотор хотод 17.7 хувь, хөдөөд 33.6 хувь байна. Хот суурин газарт амьдарч байгаа өрх бохир усаа задгай асгаж байгаа нь орчны бохирдол, оршин суугчдын эрүүл ахуйд сөрөг нөлөөтэйг анхаарах нь зүйтэй юм.

#### ХҮСНЭГТ 5.9. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, БОХИР УС ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Бохир ус зайлуулалт			
		Төвлөрсөн сиситемээр зайлуулдаг	Бие даасан системээр зайлуулдаг	Цооногт асгадаг	Задгай асгадаг
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>39.9</b>	<b>0.9</b>	<b>38.5</b>	<b>20.6</b>
Архангай	100.0	-	-	50.0	50.0
Баян-Өлгий	100.0	-	1.4	77.8	20.8
Баянхонгор	100.0	6.5	1.3	81.8	10.4
Булган	100.0	6.7	-	68.5	24.7
Говь-Алтай	100.0	4.7	-	83.7	11.6
Дорноговь	100.0	22.7	1.8	39.1	36.4
Дорнод	100.0	3.0	0.8	49.1	47.1
Дундговь	100.0	10.2	-	61.2	28.6
Завхан	100.0	6.8	1.7	83.1	8.5
Өвөрхангай	100.0	4.3	-	71.0	24.7
Өмнөговь	100.0	12.5	1.7	78.3	7.5
Сүхбаатар	100.0	29.5	0.4	41.8	28.4
Сэлэнгэ	100.0	9.4	3.1	45.3	42.2
Төв	100.0	12.4	-	53.4	34.2
Увс	100.0	7.5	-	58.5	34.0
Ховд	100.0	12.0	1.1	71.7	15.2
Хөвсгөл	100.0	0.8	1.6	82.2	15.5
Хэнтий	100.0	9.6	-	40.8	49.6
Дархан-Уул	100.0	51.1	2.5	24.9	21.5
Улаанбаатар	100.0	63.8	0.9	26.7	8.7
Орхон	100.0	56.8	0.4	27.0	15.8
Говьсүмбэр	100.0	14.0	-	59.6	26.3

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд бохир усаа задгай асгадаг өрхийн 34.6 хувь буюу 580 өрх нь ганцхан Дорнод аймагт байгаа нь ихээхэн анхаарах асуудал юм. Энэ аймаг зориулалтын бус, бусад сууцанд амьдарч байгаа өрхийн бохир ус зайлуулах асуудлыг зориуд анхаарч шийдвэрлэх шаадлагатай болсон байна. Мөн нийслэл хотод зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг 356 өрх байгаа нь улсын хэмжээний ийм төрлийн сууцанд амьдардаг нийт өрхийн 21.2 хувийг эзлэж байгаад нийслэлийн төр захиргааны байгууллага онцгой анхаарч уул өрхийн хаяг байршлыг тогтоон харьяалагдах дүүрэг, хороодын захиргаа арга хэмжээ авах нь зүйтэй юм.

### ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхөөс хатуу хог хаягдалаа тогтсон газар зайлуулдаггүй өрх улсын хэмжээнд 830 байгаа нь хот суурин газарт орчныг бохирдуулах, эрүүл ахуйн шаардлагад сөрөг нөлөө үзүүлэх хөдөө нутагт байгаль орчныг бохирдуулах гол эх үүсвэр болдог сөрөг талтайг анхаарах шаардлагатай.

### ХҮСНЭГТ 5.10. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Хатуу хог хаягдлаа зайлуулдаг хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>8 136</b>	<b>100.0</b>	<b>6 643</b>	<b>100.0</b>	<b>1 493</b>	<b>100.0</b>
Үйлчилгээний байгууллагаар	5 733	70.5	5 440	81.9	293	19.6
Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	1 573	19.3	663	10.0	910	61.0
Тогтсон газар байхгүй	830	10.2	540	8.1	290	19.4

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 70.5 хувь нь үүний дотор хотод 81.9 хувь, хөдөөд 19.6 хувь нь хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулж байгаа нь нэлээд дэвшилттэй. Гэхдээ хатуу хог хаягдлаа тогтсон цэгт хаядаггүй өрх улсын хэмжээнд 860 буюу 10.3 хувь, хотод 8.1 хувь, хөдөөд 19.4 хувь байна. Хот суурин газрын өрхүүдийг ил задгай газар хатуу хог хаягдлаа хаяж байгаа нь оршин суугчдын өөрсдөд нь төдийгүй орон нутгийн нийт оршин суугчдын эрүүл ахуйд сөрөг нөлөөтэйг ухуулан ойлгуулах, захиргааны хариуцлага тооцох талаар орон нутгийн төр захиргааны байгууллага холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй юм.


Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн хатуу хог хаягдлаа зайлуулдаг байдлаас үзэхэд улсын хэмжээнд 10.2 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулдаг тогтсон цэг байхгүй байгаагийн дотор Сэлэнгэ аймаг улсын дунджаас 3 дахин өндөр, Архангай, Булган, Дундговь, Хэнтий аймгууд 2-2.5 дахин илүү байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн хатуу хог хаягдалаа зайлуулдаг тогтсон цэг байхгүй өрх Дорнодод 233, Улаанбаатарт 205 өрх байгаа нь зөвхөн 2 газарт нийт өрхийн 53.8 хувь нь оршин сууж байна. Дорнод аймаг, Улаанбаатар хотын зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн бохир ус зайлуулах, хатуу хог хаягдал зайлуулах асуудлыг хяналтдаа авч орчны бохирдлыг багасгах, хүн амын эрүүл ахуйн ийг дээшлүүлэх талаар онцгой анхаарах болсныг харуулж байна.

ХҮСНЭГТ 5.11. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО,  
ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Хатуу хог хаягдал зайлуулалт		
		Үйлчилгээний байгууллагаар	Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	Тогтсон газар байхгүй
<b>БҮГД</b>	100.0	70.5	19.3	10.2
Архангай	100.0	14.1	60.9	25.0
Баян-Өлгий	100.0	20.8	59.7	19.4
Баянхонгор	100.0	42.9	53.2	3.9
Булган	100.0	32.6	47.2	20.2
Говь-Алтай	100.0	33.7	59.3	7.0
Дорногвь	100.0	67.1	16.9	16.0
Дорнод	100.0	60.0	21.9	18.1
Дундговь	100.0	53.1	26.5	20.4
Завхан	100.0	30.5	67.8	1.7
Өвөрхангай	100.0	45.2	41.9	12.9
Өмнөговь	100.0	65.8	25.8	8.3
Сүхбаатар	100.0	59.3	33.0	7.7
Сэлэнгэ	100.0	10.8	57.4	31.8
Төв	100.0	55.7	31.5	12.8
Увс	100.0	9.4	71.7	18.9
Ховд	100.0	25.0	63.0	12.0
Хөвсгөл	100.0	17.8	68.2	14.0
Хэнтий	100.0	28.0	47.2	24.8
Дархан-Уул	100.0	69.6	17.0	13.4
Улаанбаатар	100.0	89.0	6.0	5.0
Орхон	100.0	85.5	7.5	7.1
Говьсүмбэр	100.0	10.5	71.9	17.5

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



Өнгөрсөн 10 жилд шилжих хөдөлгөөний нөлөөгөөр өрхийн тоо, бүтцэд нэлээд өөрчлөлт гарчээ. Нийт өрх 2000 оноос 31.9 хувиар өссөний дотор хотынх 61.8 хувиар нэмэгдэж, хөдөөгийнх 4.3 хувиар буурчээ.

Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.3 байсан бол 2010 онд 3.6 болж буурав. Өрхийн ам бүл хот, хөдөөд ялгаатай байгаа боловч 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд бараг адил байна. Гэхдээ шилжих хөдөлгөөний нөлөөгөөр хот, хөдөөгийн өрхийн ам бүлийн дундаж тоо өөрчлөгдөж байгааг тооллогын дүнгээс харж болно. Тухайлбал, 2000 онд 1-2 ам бүлтэй өрх хөдөөд хотоос 4.5 пунктээр илүү байсан бол 2010 онд хотод хөдөөгөөс 2.5 пунктээр илүү болсон байна. Мөн долоо, түүнээс дээш ам бүлтэй өрх хотод хөдөөгөөс 3 дахин олон байгаа нь хотод их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр эрхлэхээр шилжин ирэгчид тусдаа эсвэл хамаатантайгаа өрх болж тоолуулсантай холбоотой байж болох талтай.

Шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор өөрчлөгдөж байгаа өөр нэг асуудал бол гэр, байшинд амьдардаг өрхийн харьцаа юм. Хот, хөдөөгийн гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жингийн зөрүү тооллого хооронд буурчээ. Хотод нийт өрхийн 65.9 хувь нь байшинд, 32.7 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, гэрт амьдардаг өрхийнх нэмэгджээ. Энэ нь гол төлөв томоохон хот, аймгийн төвүүдэд хөдөөнөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд эхлээд гэр хороололд суурьшдагтай холбоотой. Хотын байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 48.8 хувиар өссөн хэдий боловч гэрт амьдрагчдын тоо илүү ихээр нэмэгджээ. Энэ нь хот, хөдөөд байшинд амьдардаг өрхийн тоо өсч байгаа нь тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч, орон сууцаар хангах бодлого хөтөлбөрийн үр дүн тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгааг харуулж байна.

Улсын хэмжээний нийт өрхийн хэдэн хувь нь өөрийн орон сууцтай, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх зэргийг илэрхийлэх үзүүлэлт бол өрхийн сууцны өмчлөл, эзэмшил юм.

Нийт өрхийн 98.4 хувь хувийн (96.2 хувь нь иргэний, 2.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд амьдарч байгаа нь 2000 оныхоос 7.7 пунктээр нэмэгджээ. Гэрт суудаг өрхийн 99.6 хувь нь хувийн өмчийн сууцанд байгаа нь 2000 оныхоос 0.1 пунктээр өсөв. Байшинд амьдардаг өрхийн 2.5 хувь нь төрийн өмчийн сууцанд, 97.5 хувь нь хувийн өмчийн сууцанд амьдарч байна. Харин 2000 оны тооллогын дүнгээс үзэхэд байшинд амьдардаг нийт өрхийн 16.6 хувь нь төрийн, 81.6 хувь нь хувийн өмчийн сууцанд амьдарч байжээ. Төрийн өмчийн сууц ийнхүү багассан нь улсаас төрийн мэдлийн орон сууцыг хувьчилж, иргэдээ өмчтэй болгох бодлого хэрэгжүүлэх ажил үндсэндээ дууссантай холбоотой.

Улсын хэмжээнд нийт өрхийн 13.3 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаагийн 78.4 мянга нь хотын өрх юм. Нэг орон байранд 2 –оос дээш өрх хамт амьдарч байгаа нөхцөлд тэдний хэнийх нь сууц эзэмшигч хэнийх нь хамт сууж байгааг асууж, сайн дурынх нь үндсэн дээр хэн нь сууц эзэмшигч өрх гэдгийг ялгаж тоолсон тул эзэмшлийн хэлбэрийг тодорхой илэрхийлэх бололцоотой байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Өөрийн эзэмшлийн сууцгүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймаг, нийслэлд бусдаас өндөр байна. Өөрийн эзэмшлийн сууцгүй өрхийн тоо Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод ихэнх нь байна. Тухайлбал, эдгээр 3 хотод өөрийн гэсэн сууцгүй нийт өрхийн 66 хувь нь оршин сууж байна. Ялангуяа, нийслэл хотод 55.2 мянган өрх өөрийн сууцгүй байгааг анхаарч Улаанбаатар хотын өрхийг орон сууцжуулах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага байгааг тооллогын дүн харуулж байна.

### ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ

Өнгөрсөн 10 жилд улс орон даяар, ялангуяа хөдөөгийн айл өрхийг цахилгаанаар хангахаар хэрэгжүүлсэн бодлого хөтөлбөрийн үр дүнд улсын хэмжээнд нийт өрхийн 96.7

хувь нь цахилгааны эх үүсвэртэй байна. Энэ нь өмнөх тооллогын үеэс 29.4 пунктээр их байна. Гэхдээ өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангах арга хэмжээг цаашид үргэлжүүлэх шаардлага бас байна. Улсын хэмжээнд 23.6 мянган өрх цахилгаангүй байна. Энэ нь өмнөх тооллогын үеэс 7.5 дахин буурсан үзүүлэлт юм. Цахилгаангүй өрхийн 91.3 хувь нь гэрт амьдардаг бөгөөд тэдгээрийн 78.3 хувь нь хөдөө оршин амьдарч байгаагаас үзэхэд сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн хэрэгцээ нэлээд байгаа нь харагдаж байна.

Улсын хэмжээний нийт өрхөд цахилгааны эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн эзлэх хувь Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Хэнтий аймгуудад бусдаас өндөр байгаад эдгээр аймгийн ард иргэдийг цахилгааны эх үүсвэрээр хангах талаар эхний ээлжинд анхаарч үзэх шаардлагатай аж. Нийслэл хотын өрхийн 1.1 хувь нь цахилгааны эх үүсвэргүй нь бага мэт боловч үнэндээ 3.3 мянган өрх буюу улсын хэмжээний цахилгаангүй өрхийн 14.0 хувийг эзэлж байна.

### ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ГЭРИЙН ХЭМЖЭЭ, ОНЦЛОГ

Монголын ард түмний уламжилалт сууц болох гэрт нийт өрхийн олонх нь амьдарсан хэвээр байна. Гэрийн ханын хэмжээ аймаг орон нутгийн онцлогоос хамаарч янз бүр боловч улсын дунджаар 25.4 хувь нь таваас цөөн ханатай гэрт амьдарч байхад Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Хэнтий аймгуудад улсын дунджаас 2 дахин олон өрх амьдарч байна. Мөн 5 ханатай гэрт бүх өрхийн 56.3 хувь нь сууж байгаа нь 5 ханатай гэр манай ард түмний түгээмэл сууц гэдгийг харуулж байна. Гэвч энэ үзүүлэлт аймаг тус бүрд харилцан адилгүй, тухайлбал: Увс аймагт 5 ханатай гэрт бүх өрхийнх нь дөнгөж 6.2 хувь, Ховдод 27.5 хувь, Баян-Өлгийд 28.3 хувь, Завханд 29.4 хувь байгаа нь улсын дунджаас 2 дахин цөөн юм. Гэтэл 6 ханатай гэрт амьдардаг бүх өрхийн эзлэх хувь Ховдод 64.5, Увсад 63.9, Баян-Өлгийд 62.2, Завханд 61.8 хувийг тус тус эзэлж байна. Дээрхээс харахад баруун аймгийн ард түмэн нэлээд том гэрт харин зүүн аймгийнхан арай цөөн ханатай гэрт амьдардаг заншилтай нь харагдаж байна.

### ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ХАНГАМЖ

Улсын хэмжээнд өрхийн цахилгааны хангамжинд өөрчлөлт гарч байгаагийн дотор гэрт амьдардаг бүх өрхийн 93.5 хувь нь цахилгаанаар хангасан байна. Өмнөх тооллогын үеэс 2.2 дахин өссөн нь ерөнхийдөө том дэвшил гарсан гэж үзэж болох байна. Үүний дотор хотын өрхийн 97.1 хувь хөдөөгийнх 90.0 хувь нь цахилгаанаар хангасан нь өнгөрсөн тооллогын үеэс 3.6 дахин өсчээ.

Өнгөрсөн 10 гаруй жилд цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар дорвитой өөрчлөлт хийсэн боловч анхаарах асуудал байсаар байна. Улсын хэмжээнд гэрт амьдардаг 21.2 мянган өрх цахилгаангүй байгаагийн дотор хотын 3 мянга, хөдөөгийн 16.6 мянган өрх цахилгаангүй байна. Энэ нь цаашдаа сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж болон цахилгааны бага оврын тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага нэлээд байгааг харуула.

Гэрт амьдардаг хотын өрхөөс цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Сэлэнгэд 8.6, Баян-Өлгийд 6.8, Булганд 5.2, Архангайд 5.2, Хөвсгөлд 5.0 хувь байгаа нь бусдаас өндөр байна. Гэрт амьдардаг өрхийн цахилгааны эх үүсвэрийг нэлээд амжилттай шийдвэрлэж байгаа орчин цагт төв суурин газарт амьдарч байгаа өрхийн цахилгааны эх үүсвэрийг үндсэнд нь шийдвэрлэх боломж байна гэж үзэж болно.

Өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах төр засгийн бодлого, хөтөлбөр боловсруулахад үндэслэл болох үзүүлэлтийг тодорхойлохын тулд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийн орон сууцны нөхцөлийн үзүүлэлтийг өмнөх тооллогын үеэс нэлээд дэлгэрүүлж авсан. Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар цуглуулж, зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдлыг багасгахад ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн хот суурин газруудад хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд тооллогын дүн хариулт өглөө.

Улсын хэмжээний нийт өрхийн 26.7 хувь нь ахуйн нөхцөлөөр сайтай байгаагийн дотор нийслэлээс гадна Эрдэнэт, Дархан зэрэг том хот төвтэй аймгууд, хэдүйгээр хүн ам цөөнтэй боловч орон сууцны байшин олонтой Говьсүмбэр аймгийн өрхийн орон сууцны нөхцөл нь бусад аймгаас илүү сайтай байдаг аж. Өрхийнх нь орон сууцны нөхцөл нь бусад аймаг, улсын дунджаас нэлээд доогуур байгаа аймгуудад Баян-Өлгий, Архангай, Булган, Хөвсгөл, Завхан, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгууд орж байна. Тооллогын дүнгээс үзэхэд хотын өрхийн орон сууцны нөхцөлөөр хангасан байдал нь хөдөөгийн өрхөөс илүү байгаа нь зүй ёсны асуудал билээ. Гэвч улсын хэмжээнд орон сууцны нөхцөл сайтай хотын өрхүүд нийт хотын өрхөд эзлэх хувь 36.6 байгаа нь хөдөөгийн өрхийн улсын дунджаас 5.5 дахин өндөр байна. Гэхдээ том хотуудаас гадна аймгийн төвүүдийн дотор Дорнод аймгийн төв нь орон сууцны байшин олонтой, орон сууцны нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дундажтай бараг ижил байна. Олон хүн төвлөрсөн хот суурин газарт амьдарч байгаа өрхийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, үүний дотор хатуу хог хаягдал, бохир ус зайлуулах, бие засах цэгийг олшруулах, зөв байршуулах зэрэг асуудлыг зохицуулахад орон нутгийн төр захиргааны байгууллагууд сайтар анхаарах шаардлагатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

Орон сууцны ахуйн нөхцөлийг огт хангаагүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 1.7 хувь буюу 11.7 мянган өрх байна. Ялангуяа хотын орон сууцны нөхцөлийг огт хангаагүй 857 өрх дотор нийслэлд 156 өрх байгаа нь хотын орон сууцны нөхцөлийг хангаагүй 5 өрхийн нэг нь болж байгаа нь анхаарал татаж байна. Төв суурин газрын өрх орон сууцны нөхцөл муу байх нь тухайн өрхийн асуудал бус орон нутгийн тухайлбал баг, хорооны нийт ард иргэдэд хамааралтай, орчны эрүүл ахуй, байгаль орчны бохирдол, хүн амын эрүүл мэндэд хамааралтай юм. Иймээс тухайн орон нутгийн захиргаа уг асуудалд зориуд анхаарч ажиллах шаардлагатай юм.

Тооллогоор өрхийн орон сууцны ахуйн нөхцөлийг гэрт амьдардаг байшинд амьдардаг, сууцны бус, бусад сууцанд амьдардаг өрхийг тус тусд нь тодорхойлсон юм.

### ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн талаарх үзүүлэлтийг 3 дугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн. Энэ бүлэгт гол төлөв анхаарах асуудлыг оруулахыг хичээв. Бохир усаа ил задгай асгах, хатуу хог хаягдлыг зөвшөөрсөн цэгт асгаж, тогтмол зайлуулж хэвших, бие засах тогтсон стандартын шаардлага хангасан цэгтэй болох нь учир дутагдалтай байгааг тооллогын дүн харуулж байна. Тооллогын дүнгээр гэрт амьдардаг өрхийн 45.5 хувь нь буюу 140.5 мянган өрх нь бохир усаа задгай асгаж байгаагийн дотор Дундговь, Дархан-Уул, Орхон аймаг, Нийслэл хотоос бусад аймгийн өрхийн талаас илүү хувь нь бохир усаа задгай асгаж байгаа нь ихээхэн анхаарал татах асуудал болжээ. Ялангуяа, хотын өрхийн 18.3 хувь нь бохир усаа задгай асгаж байгаагийн дотор Архангай, Булган, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр аймгийн хотын өрхийн өрхийн 30-аас дээш хувь нь бохир усаа задгай асгаж байгааг тэдгээр аймгийн төр захиргааны байгууллагууд холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх хотын нийт өрхийн 9.9 хувь, байгаагийн дотор Булган, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн хотын өрхийн 30-аас дээш хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй байгаа нь хот, суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байгаад анхаарч, цаашид судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

Гэрт амьдардаг хотын өрхийн 4.7 хувь нь бие засах тогтсон цэг байхгүй байгаагийн дотор Говьсүмбэр аймагт 25.7 хувь, Сүхбаатар аймагт 22.6 хувь Дундговь аймагт 18.0 хувь байгаа нь бусдаас ихээхэн өндөр байна.

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хангасан байдлыг нийтэд нь үзвэл бүх өрхөд ахуйн сонгосон 5 нөхцөлийг бүгдийг хангасан өрх 15.5 хувь байхад огт хангагдаагүй өрх

3.4 хувь байгаа юм. Гэрт амьдардаг 100 өрхөөс зургаа нь ахуйн нөхцөлөөр хагас хангасан, 5 өрхийн нэг нь муу хангасан байгаа нь анхаарах асуудал болж байна. Гэрт амьдардаг хотын өрхийн ахуйн нөхцөл хөдөөгийнхөөс арай илүү хангасан байгааг 3 бүлэгт тодорхой харуулсан. Гэхдээ хотын өрхийн 3.5 хувь нь буюу 5.4 мянган өрх ахуйн нөхцөл муу эсвэл огт хангагдаагүй байгаа нь төв суурин газарт оршин суугаа ард иргэдийн эрүүл ахуй, орчны бохирдолд сөргөөр нөлөөлж байгаа нь тодорхой билээ. Иймээс эхний ээлжинд хот суурин газарт амьдарч байгаа гэр хорооллын өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ авах болсныг тооллогын дүн харуулж байна.

Хөдөөгийн гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг хотынхоос нэлээд доогуур байгаа нь зарим талаар манай орны онцлог гэж үзэж болох боловч цаашдаа ахуйн нөхцөлийг огт хангаагүй, муу хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жинг бууруулах талаар тусгайлсан бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

### *БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ БАГТААМЖ*

Байшинд амьдардаг өрхийн сууцны багтаамжийг харуулах үзүүлэлт бол өрөөний тоо юм. Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн хувьд сууцных нь өрөөний тоо хотын өрхийнхээс нэлээд ялгаатай юм. Тухайлбал, байшинд амьдардаг хотын нийт өрхөд нэг өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 31.5 хувь байхад хөдөөд энэ үзүүлэлт 43.6 хувь буюу 12.1 пунктээр илүү юм. Гэхдээ энэ үзүүлэлт өмнөх тооллогоос 12.6 пунктээр буурсан байна. Харин 2 өрөөтэй сууцанд амьдрагчдын хувь хөдөөд хотоос 5.2 пунктээр бага байгаагаас үзэхэд хөдөөд нэг өрөөтэй сууц давамгайлдаг аж.

Байшинд амьдардаг өрхийн сууцны багтаамжийг харуулах нэг үзүүлэлт бол сууцны өрөөний тоог өрхийн ам бүлийн тоотой харьцуулсан үзүүлэлт билээ. Тус улсын өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 73.6 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг өмнөх тооллогынхтой харьцуулахад 9.1 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт хотод 72.5 хувь байгаа нь өмнөх тооллогын үеэс 8.2 пунктээр, хөдөөд 81.0 хувь байгаа нь өмнөх тооллогын үеэс 9.0 пунктээр тус тус буурсан аж. Харин 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 62.0 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 11.7 пунктээр буурсан аж. Долоо, түүнээс дээш ам бүлтэй байшинд амьдардаг өрхийн 4.6 хувь 5-аас олон өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2000 оныхоос 5.1 дахин өссөн зэргээс үзэхэд байшинд амьдардаг өрхийн сууцны багтаамж өмнөх 10 жилээс дээшилснийг харуулж байна.

### *БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ*

Өнгөрсөн 10 жилд иргэд хувиараа байшин барьж суух нь олширч байгааг түрүүнд тэмдэглэсэн. Үүнтэй холбоотойгоор төвлөрсөн системд холбогдсон халуун, хүйтэн устай тохилог сууцанд орсон өрхийн тоо, хувиараа байшин барьж суусан өрхийн тооноос цөөн байгаагаас халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 38.7 байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 1.1 пунктээр буурсан байна. Энэ үзүүлэлт хотод 46.0 хувь, байгаа нь өмнөх тооллогын үеэс 3,3 пунктээр буурчээ. Байшинд амьдардаг өрхийн 56.8 хувь буюу 214.7 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор хотын 152.7 мянган өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 3.0 пунктээр нэмэгдсэний дотор хотод 5.5 пункт, хөдөөд 1.3 пунктээр тус тус ихэсчээ.

Байшинд амьдардаг нийт өрхийн 42.8 хувь (тусдаа эзэмшдэг 40.6 хувь, нийтээрээ ашигладаг 2.2 хувь) нь онгоц, шүршүүртэй байгааг нь өмнөх тооллоготой харьцуулахад 0.6 пунктээр буурчээ.



### БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг 4 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй тусгасан. Анхаарах зарим асуудлаас дурдвал:

Сууцны дотор бие засах газартай байшинд амьдардаг өрхийн хувь улсын хэмжээнд 42.4 хувь болсон нь 2000 оноос 4.5 пунктээр буурсан бол сууцны гаднаа бие засах газартай өрхийн хувь нэмэгдэв. Байшинд амьдардаг өрхийн 77.1 хувь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үетэй харьцуулахад дэвшил гарсан. 2000 онд байшинд суудаг өрхийн 10 хувь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэг байхгүй байсан бол 2010 онд 5 хувь болтлоо буурчээ.

Байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөлийг муу хангасан өрхийн эзлэх хувь ерөнхийдөө бага байгаа боловч зарим аймгууд анхаарал татаж байна. Эдгээрийн дотор зуун өрх дутамд Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ аймаг тус бүрд хоёр өрх дутмын нэг нь, Хөвсгөл аймгийн 10 өрх дутмын нэг нь орон сууцны нөхцөл муутай байгаа аж. Хөдөөгийн байшинд амьдардаг зуун өрхөөс орон сууцны нөхцөлийг муу хангасан өрх Баян-Өлгийд 2, Булган, Дорнод, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт 6-10 өрх дутмын нэг нь ахуйн нөхцөлийг муу хангажээ.

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг гэрт амьдардаг өрхтэй зэрэгцүүлэхэд ерөнхийдөө сайн байна. Тухайлбал, байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөлийг сайн хангасан өрхийн эзлэх хувь 3.7 дахин өндөр байхад, ахуйн нөхцөлийг огт хангаагүй өрхийн эзлэх хувь 17.5 дахин бага байна.

### ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛ

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 70.5 хувь нь үүний дотор хотод 81.9 хувь, хөдөөд 19.6 хувь нь хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулж байгаа нь нэлээд дэвшилттэй юм. Гэхдээ хатуу хог хаягдлаа тогтсон цэгт хаядаггүй өрх улсын хэмжээнд 860 буюу 10.3 хувь, хотод 8.1 хувь, хөдөөд 19.4 хувь байна. Хот суурин газрын өрхийг ил задгай газар хатуу хог хаягдлаа асгаж байгаа нь оршин суугчдын өөрсдөд нь төдийгүй орон нутгийн нийт оршин суугчдын эрүүл ахуйд сөрөг нөлөөтэйг ухуулан ойлгуулах, захиргааны хариуцлага тооцох талаар орон нутгийн төр захиргааны байгууллага холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн хатуу хог хаягдалаа зайлуулдаг байдлаас үзэхэд улсын хэмжээнд 10.2 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулдаг тогтсон цэг байхгүй байгаагийн дотор Сэлэнгэ аймаг улсын дунджаас 3 дахин өндөр, Архангай, Булган, Дундговь, Хэнтий аймгууд 2-2.5 дахин илүү байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн хатуу хог хаягдалаа зайлуулдаг тогтсон цэг байхгүй өрх Дорнодод 233, Улаанбаатарт 205 байгаа нь зөвхөн энэ 2 газарт нийт өрхийн 53.8 хувь нь оршин сууж байна. Дорнод аймаг, Улаанбаатар хотын зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн бохир ус зайлуулалт, хатуу хог хаягдал зайлуулах асуудлыг анхаарахгүй бол орчны бохирдлыг багасгах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах талаар онцгой анхаарах цаг болсныг харуулж байна.

# ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ 2.1. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУУЦНЫ ЭЗЭМШИЛ,  
ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд		Өөрийн эзэмшлийн		Бусдын сууцанд түрээстэй амьдардаг		Бусдын сууцанд түрээсгүй амьдардаг		Бусад				
	бүгд	хот	хөдөө	бүгд	хот	хөдөө	бүгд	хот	хөдөө	хот	хөдөө		
<b>БҮГД</b>	<b>713 780</b>	<b>619 034</b>	<b>401 089</b>	<b>217 945</b>	<b>44 951</b>	<b>40 903</b>	<b>4 048</b>	<b>43 544</b>	<b>32 980</b>	<b>10 564</b>	<b>6 251</b>	<b>4 531</b>	<b>1 720</b>
Архангай	24 551	23 089	5 071	18 018	351	253	98	989	370	619	122	65	57
Баян-Өлгий	19 225	18 243	6 465	11 778	467	346	121	430	242	188	85	27	58
Баянхонгор	21 695	21 317	8 209	13 108	159	96	63	184	73	111	35	11	24
Булган	15 807	14 621	3 800	10 821	266	158	108	806	240	566	114	19	95
Говь-Алтай	14 562	13 990	4 516	9 474	284	171	113	254	133	121	34	10	24
Дорноговь	16 543	13 028	7 418	5 610	1 483	1 057	426	1 663	887	776	369	177	192
Дорнод	18 895	14 574	8 034	6 540	1 401	1 014	387	2 488	1 237	1 251	432	195	237
Дундговь	10 895	10 400	3 617	6 783	251	94	157	191	74	117	53	31	22
Завхан	18 574	17 702	4 509	13 193	239	125	114	528	161	367	105	42	63
Өвөрхангай	28 051	27 339	10 204	17 135	297	183	114	295	154	141	120	71	49
Өмнөговь	14 939	13 679	5 191	8 488	545	172	373	654	261	393	61	23	38
Сүхбаатар	14 145	12 731	3 869	8 862	244	141	103	947	198	749	223	149	74
Сэлэнгэ	26 889	22 676	10 901	11 775	1 264	818	446	2 614	1 451	1 163	335	170	165
Төв	24 687	21 757	3 158	18 599	830	158	672	1 714	339	1 375	386	147	239
Увс	18 641	18 171	6 811	11 360	142	83	59	230	104	126	98	34	64
Ховд	18 944	18 103	6 539	11 564	244	184	60	523	254	269	74	28	46
Хөвсгөл	33 007	30 551	10 330	20 221	334	169	165	1 912	840	1 072	210	102	108
Хэнтий	19 147	16 026	6 869	9 157	670	459	211	2 169	1 283	886	282	135	147
Дархан-Уул	24 227	19 746	15 917	3 829	2 512	2 343	169	1 791	1 623	168	178	164	14
Улаанбаатар	302 242	247 029	247 029	-	31 193	31 193	-	21 221	21 221	-	2 799	2 799	-
Орхон	24 273	21 001	20 288	713	1 535	1 480	55	1 636	1 585	51	101	99	2
Говьсүмбэр	3 841	3 261	2 344	917	240	206	34	305	250	55	35	33	2

ХАВСРАЛТ 2.2. ХОТЫН ӨРХИЙН ТОО, АЙМАГ НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР,  
 ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо- бүгд	Цахилгааны эх үүсвэрээр			
		Хангагдсан	хувь	Хангагдаагүй	хувь
<b>БҮГД</b>	<b>479 503</b>	<b>473 892</b>	<b>98.8</b>	<b>5 611</b>	<b>1.2</b>
Архангай	5 759	5 618	97.6	141	2.4
Баян-Өлгий	7 080	7 036	99.4	44	0.6
Баянхонгор	8 389	8 286	98.8	103	1.2
Булган	4 217	4 156	98.6	61	1.4
Говь-Алтай	4 830	4 830	100.0	90	1.9
Дорноговь	9 248	9 394	101.6	145	1.6
Дорнод	10 480	10 376	99.0	104	1.0
Дундговь	3 816	3 716	97.4	100	2.6
Завхан	4 837	4 810	99.4	27	0.6
Өвөрхангай	10 612	10 494	98.9	118	1.1
Өмнөговь	5 647	5 580	98.8	67	1.2
Сүхбаатар	4 357	4 268	98.0	89	2.0
Сэлэнгэ	13 340	13 139	98.5	201	1.5
Төв	3 802	3 783	99.5	19	0.5
Увс	7 032	6 917	98.4	115	1.6
Ховд	7 005	6 960	99.4	45	0.6
Хөвсгөл	11 441	11 157	97.5	284	2.5
Хэнтий	8 746	8 574	98.0	172	2.0
Дархан-Уул	20 047	19 883	99.2	164	0.8
Улаанбаатар	302 242	298 935	98.9	3 307	1.1
Орхон	23 452	23 273	99.2	179	0.8
Говьсүмбэр	2 833	2 797	98.7	36	1.3

ХАВСРАЛТ 4.1 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
СУУЦНЫ ТАЛБАЙ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Сууцны талбай (квадрат метр)								
		20 хүртэл			21-40			40-өөс дээш		
		Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>13.3</b>	<b>13.5</b>	<b>12.5</b>	<b>40.0</b>	<b>39.8</b>	<b>40.8</b>	<b>46.7</b>	<b>46.7</b>	<b>46.7</b>
Архангай	100.0	9.8	10.3	9.3	36.2	37.6	34.7	54.1	52.2	56.0
Баян-Өлгий	100.0	7.1	5.7	8.0	26.9	17.8	32.4	66.0	76.4	59.7
Баянхонгор	100.0	10.3	9.8	11.4	44.3	45.0	42.6	45.4	45.2	46.0
Булган	100.0	9.2	9.0	9.4	44.3	43.8	44.8	46.5	47.2	45.8
Говь-Алтай	100.0	10.8	11.1	10.3	45.2	40.8	53.5	44.0	48.1	36.2
Дорноговь	100.0	21.8	23.1	18.6	42.5	38.8	51.7	35.7	38.1	29.7
Дорнод	100.0	21.9	23.1	19.6	52.5	53.3	51.2	25.6	23.7	29.2
Дундговь	100.0	13.6	12.0	15.8	37.7	39.4	35.2	48.7	48.5	49.0
Завхан	100.0	9.4	5.8	12.2	37.1	39.9	35.0	53.5	54.3	52.8
Өвөрхангай	100.0	8.0	8.7	6.3	25.5	26.0	24.2	66.5	65.3	69.5
Өмнөговь	100.0	13.6	12.2	15.3	39.3	34.7	44.5	47.1	53.1	40.2
Сүхбаатар	100.0	9.0	9.9	8.1	50.9	48.7	53.0	40.1	41.4	38.9
Сэлэнгэ	100.0	15.6	16.0	15.2	40.3	42.9	36.7	44.1	41.1	48.1
Төв	100.0	15.7	23.4	13.3	41.5	45.1	40.3	42.7	31.5	46.4
Увс	100.0	8.7	9.8	7.3	36.5	38.7	33.8	54.8	51.5	58.8
Ховд	100.0	8.8	9.4	8.1	38.0	37.9	38.1	53.1	52.7	53.7
Хөвсгөл	100.0	12.6	10.6	14.7	39.7	35.6	43.9	47.8	53.8	41.5
Хэнтий	100.0	19.3	14.4	25.9	45.8	44.5	47.6	34.8	41.1	26.5
Дархан-Уул	100.0	10.9	11.7	7.0	45.4	42.9	57.8	43.7	45.4	35.2
Улаанбаатар	100.0	13.3	13.3	-	38.8	38.8	-	47.8	47.8	-
Орхон	100.0	15.8	16.0	6.0	51.1	51.3	44.0	33.1	32.7	50.0
Говьсүмбэр	100.0	14.9	14.7	15.5	36.0	39.0	28.4	49.0	46.3	56.1

**ХАВСРАЛТ 4.2. БАЙШИНД АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ХУВЬ,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨРӨӨНИЙ ТОО, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>31.5</b>	<b>40.4</b>	<b>20.0</b>	<b>5.5</b>	<b>2.2</b>	<b>0.3</b>	<b>0.2</b>
Архангай	100.0	28.4	44.5	20.2	5.4	1.3	0.1	0.1
Баян-Өлгий	100.0	12.5	23.0	26.6	21.5	13.5	2.6	0.3
Баянхонгор	100.0	23.6	52.9	17.8	3.6	1.8	0.1	0.2
Булган	100.0	42.5	42.7	11.3	2.4	1.0	0.1	0.1
Говь-Алтай	100.0	29.6	45.4	18.1	4.2	2.3	0.3	0.1
Дорноговь	100.0	36.3	40.2	18.5	3.4	1.3	0.1	0.1
Дорнод	100.0	47.2	36.4	13.9	2.0	0.3	0.0	0.1
Дундговь	100.0	26.8	43.5	21.6	6.4	1.7	-	-
Завхан	100.0	27.1	52.3	15.8	3.2	1.5	-	0.2
Өвөрхангай	100.0	19.3	44.0	26.3	7.1	3.0	0.2	0.1
Өмнөговь	100.0	24.1	43.7	21.7	6.9	3.1	0.1	0.5
Сүхбаатар	100.0	36.7	44.2	16.4	1.6	1.0	0.2	-
Сэлэнгэ	100.0	34.0	40.4	18.4	5.8	1.2	0.1	0.2
Төв	100.0	37.0	42.9	13.1	4.2	2.5	0.0	0.2
Увс	100.0	18.0	47.9	23.4	7.3	3.0	0.4	0.1
Ховд	100.0	25.9	48.3	19.0	4.5	1.7	0.3	0.2
Хөвсгөл	100.0	42.6	34.0	15.9	6.1	0.9	0.1	0.4
Хэнтий	100.0	36.7	41.9	17.9	2.4	0.7	0.1	0.2
Дархан-Уул	100.0	34.6	39.0	20.2	5.4	0.7	0.1	0.1
Улаанбаатар	100.0	30.4	40.8	20.6	5.4	2.3	0.3	0.2
Орхон	100.0	38.6	38.5	18.1	3.6	0.9	0.1	0.2
Говьсүмбэр	100.0	22.4	55.0	18.9	3.0	0.4	-	0.3

ХАВСРАЛТ 4.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>43.6</b>	<b>35.2</b>	<b>13.8</b>	<b>5.4</b>	<b>1.6</b>	<b>0.2</b>	<b>0.2</b>
Архангай	100.0	34.9	42.9	15.8	4.6	1.5	0.1	0.2
Баян-Өлгий	100.0	25.7	27.4	21.8	17.6	6.4	0.8	0.2
Баянхонгор	100.0	27.4	46.2	21.0	3.2	1.9	0.1	0.2
Булган	100.0	68.6	22.6	6.8	1.5	0.3	0.1	0.1
Говь-Алтай	100.0	37.2	47.1	13.0	1.8	0.8	0.1	-
Дорноговь	100.0	46.7	40.3	11.0	1.3	0.3	-	0.3
Дорнод	100.0	58.1	33.8	6.5	1.5	0.1	0.1	0.1
Дундговь	100.0	35.9	49.9	11.3	2.3	0.5	-	0.1
Завхан	100.0	38.5	40.7	15.4	4.2	0.9	0.2	0.2
Өвөрхангай	100.0	20.5	44.1	24.9	8.9	1.6	0.1	-
Өмнөговь	100.0	37.8	46.5	11.1	3.1	1.3	0.1	0.2
Сүхбаатар	100.0	49.2	42.2	7.1	0.9	0.3	-	0.3
Сэлэнгэ	100.0	40.7	39.1	15.9	3.5	0.6	0.1	0.1
Төв	100.0	40.1	40.3	14.7	3.9	0.7	0.1	0.2
Увс	100.0	36.4	43.0	16.6	3.2	0.8	-	-
Ховд	100.0	34.8	43.8	16.3	3.3	1.4	0.2	0.1
Хөвсгөл	100.0	66.0	23.7	7.0	2.5	0.4	0.1	0.3
Хэнтий	100.0	65.9	27.6	4.8	1.0	0.6	0.1	0.1
Дархан-Уул	100.0	47.5	37.7	12.2	2.5	0.1	0.0	-
Орхон	100.0	50.0	41.7	7.4	0.9	-	-	-
Говьсүмбэр	100.0	35.8	49.1	13.1	1.0	0.6	-	0.3